



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

## Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн тандан судалгаа

### Судалгааг удирдсан:

Г.Өнөрцэцэг

“И-Монгол академи” УТҮГ-ын  
ГХХАГ-н дарга

### Судлаач:

М.Үнэнзаяа

“И-Монгол академи” УТҮГ-ын  
Судалгааны хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар  
2026 он

## АГУУЛГА

Удиртгал

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

1.1. Нийгмийн сүлжээн дэх хүүхдийн эрх, аюулгүй байдлын зөрчлийн нөхцөл байдал

1.2. Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай ойлголтыг хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан байдал

1.3 Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон нь

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсан байдал

Дөрөв. Хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах

Тав. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийсэн байдал

Зургаа. Олон улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулан судласан байдал

Долоо. Дүгнэлт, зөвлөмж

Эх сурвалж

Хавсралт

## УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил эрчимтэй нэмэгдэж, хүүхдийн цахим хэрэглээ өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болж өөрчлөгдөж байна. Хүүхдүүд цахим орчныг боловсрол эзэмших, мэдээлэл авах, найз нөхөдтэйгээ харилцах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх зэрэг олон зорилгоор ашиглаж байгаа хэдий ч үүний зэрэгцээ цахим орчинтой холбоотой олон төрлийн эрсдэл, сөрөг нөлөөлөл нэмэгдэж байна. Тухайлбал цахим дээрэлхэлт, хортой агуулга бүхий контент, цахим залилан, танихгүй этгээдийн дарамт, бэлгийн мөлжлөг, цахим донтолт, хувийн мэдээлэл алдагдах зэрэг нь хүүхдийн аюулгүй байдал, эрүүл хөгжил, сэтгэл зүйд ноцтой нөлөөлөх болсон байна.

Олон улсын хэмжээнд Европын Холбооны “Digital Services Act”, Их Британийн “Online Safety Act”, Австралийн “Online Safety Act 2021” зэрэг хууль тогтоомжууд батлагдаж, хүүхдийг цахим орчинд хамгаалах тусгай зохицуулалтыг бий болгож байна. Монгол Улсад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2025<sup>1</sup> оны судалгаагаар 13–17 насны хүүхдүүдийн 51.3 хувь нь цахим дарамт, доромжлолд өртсөн болохыг тогтоосон бөгөөд цахим дээрэлхэлт нь хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, түгшүүр, сэтгэл гутрал, амиа хорлох бодол төрүүлэх эрсдэлтэйг онцолсон байна.

Энэхүү нөхцөл байдал нь хүүхдийн эрхийг цахим орчинд хамгаалах асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагыг бий болгож байгаа бөгөөд төрөөс хүүхдийн цахим аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Иймд “Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор эцэг эх, багш, нийгмийн ажилтан, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг хамруулсан хоёр судалгааны үр дүнг нэгтгэн энэхүү тандан судалгааг боловсруулав. Судалгаанд нийт 9852 оролцогч хамрагдсан бөгөөд үүнээс 3102 нь эцэг эх, асран хамгаалагч, 11-17 насны 6080 хүүхэд, 670 нь багш, нийгмийн ажилтан болон боловсролын салбарын ажилтнууд байна.<sup>2</sup>

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн цахим хэрэглээ улс орон даяар эрчимтэй нэмэгдэж, хүүхдүүд олон төрлийн цахим платформыг тогтмол ашиглаж байгаа нь тогтоогдсон. Үүний зэрэгцээ хүүхдүүд цахим орчинд төрөл бүрийн эрсдэлд өртөж байгаа бөгөөд эцэг эх, багш, боловсролын байгууллагын зүгээс хяналт, хамгаалалтын тогтолцоо хангалтгүй байгаа нь ажиглагдсан байна. Иймээс хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр тусгайлсан хууль, бодлого, зохицуулалт шаардлагатай байгаа нь энэхүү судалгаагаар нотлогдож байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн

---

<sup>1</sup> [https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2025-08/undp\\_cyberbullying\\_report\\_eng\\_0.pdf](https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2025-08/undp_cyberbullying_report_eng_0.pdf)

<sup>2</sup> Хавсралт 3 Судалгааны нэгтгэл

хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-д тус тус тодорхойлсноор дараах үндсэн 7 үе шатны дагуу тандан судалгааг гүйцэтгэх ёстой. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх аргачлалын агуулга, дэс дарааллын дагуу Нийгмийн сүлжээнд хүүхдийн хэрэгцээг зохицуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлыг гүйцэтгэж, тайланг боловсруулсан болно.

## **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

### **1.1. Нийгмийн сүлжээн дэх хүүхдийн эрхийн нөхцөл байдал**

Хүүхэд нь цахим орчинд мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, боловсрол эзэмших, хөгжих, харилцах зэрэг үндсэн эрхээ хэрэгжүүлэх өргөн боломжтой болсон. Гэвч цахим хэрэглээ эрчимтэй нэмэгдэхийн хэрээр хүүхэд цахим орчин дахь олон төрлийн эрсдэлд өртөх болсон нь хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг шинэ түвшинд авч үзэх шаардлагыг бий болгож байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхдүүд цахим дээрэлхэлт, хортой агуулгатай контент, танихгүй этгээдээс ирсэн хүсэлт, цахим залилан, бэлгийн шинжтэй дарамт зэрэг эрсдэлтэй нөхцөл байдалтай тулгарч байгааг багш, нийгмийн ажилтнууд ажигласан байна.<sup>3</sup>

Түүнчлэн эцэг, эхчүүдээс авсан судалгаагаар хүүхдүүд YouTube, Facebook, TikTok, Instagram зэрэг платформыг өргөн хэрэглэж байгаа нь тогтоогдсон бөгөөд эдгээр платформ нь алгоритмд суурилсан контент түгээдэг онцлогтой тул хүүхэд насанд тохироогүй, сөрөг агуулгад өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд хүүхдийн цахим орчин дахь эрхийг зөвхөн мэдээлэл авах эрхээр хязгаарлах бус, аюулгүй орчинд хөгжих, хувийн мэдээллээ хамгаалуулах, дарамт, хүчирхийллээс ангид байх эрхтэй нь уялдуулан цогцоор авч үзэх шаардлагатай байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25”-д хүүхдийн эрх нь цахим орчинд мөн адил бүрэн хэрэгжих бөгөөд улс орнууд хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах тусгайлсан хууль, бодлогын зохицуулалт бүрдүүлэх үүрэгтэйг тодорхойлсон. Тус тайлбарт дараах асуудлыг үндэсний хууль тогтоомжид тусгах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Хүүхдэд зориулсан default privacy тохиргоо;
- Насны баталгаажуулалтын тогтолцоо;

---

<sup>3</sup> Хавсралт 3 “Багш, нийгмийн ажилтнаас авсан судалгаа” 2026 он

- Хортой контентын хязгаарлалт;
- Донтуулах шинжтэй алгоритмын эрсдэлийг бууруулах зохицуулалт;
- Платформын үүрэг, хариуцлага;
- Хүүхдийн өгөгдөл, хувийн мэдээллийн хамгаалалт;
- “Safety by design” буюу аюулгүй байдлыг анхнаас нь системд шингээх зарчим.

Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны дээрх тайлбарт хүүхдийн “хувьсан хөгжиж буй чадавх”-ын зарчмыг онцлон тусгасан бөгөөд энэ нь хүүхдийн ур чадвар, танин мэдэхүй, өөрийн үйлдлийн үр дагаврыг ойлгох чадвар нас, хөгжлийн түвшнээс хамааран аажмаар төлөвшдөг болохыг илэрхийлдэг. Цахим орчинд хүүхэд эцэг, эх, асран хамгаалагчийн шууд хяналтаас гадуур бие даан оролцох боломжтой байдаг тул хүүхдийн хөгжлийн онцлогийг энэ орчинд тусгайлан харгалзан үзэх шаардлагатай гэж тэмдэглэсэн.

Хүүхдийн цахим орчин дахь эрсдэл, боломж нь нас, хөгжлийн үе шатнаас хамааран харилцан адилгүй байдаг тул улс орнууд хүүхдийг хамгаалах болон цахим орчинд оролцоог нь дэмжих бодлого, арга хэмжээг боловсруулахдаа хүүхдийн нас, хөгжлийн онцлогийг харгалзан үзэх ёстой. Үүний зэрэгцээ, салбар бүрийн хамгийн сүүлийн үеийн судалгаа, нотолгоонд тулгуурлан хүүхдийн насны онцлогт нийцсэн хамгаалалтын арга хэмжээг боловсруулах шаардлагатайг онцолсон<sup>4</sup>.

Түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай конвенц болон түүний Нэмэлт протоколуудад заасан эрхийг цахим орчинд хангах зорилгоор оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжоо олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн тогтмол хянаж, шинэчилж байх үүрэгтэй. Хууль тогтоомж нь технологийн хурдацтай хөгжил, шинээр үүсэж буй нөхцөл байдлаас хоцрох ёсгүй бөгөөд цахим орчинтой холбоотой төрийн байгууллага, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд хүүхдийн эрхийн нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж заасан. Энэ нь цахим орчинтой холбоотой хууль тогтоомж, төсвийн хуваарилалт, захиргааны шийдвэр бүрт хүүхдийн эрхийг тусгах, хамгаалах зорилготой юм.

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалахтай 1989 оны Хүүхдийн эрхийн конвенци зэрэг Монгол Улсын олон улсын гэрээ, мөн Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль зэрэг дотоодын нэлээдгүй олон хууль тогтоомжоор зохицуулж байна

Эдгээр хууль тогтоомж нь хүүхдийн эрх, аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалттай холбоотой суурь зохицуулалтыг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн хэдий ч хүүхдийн цахим орчин дахь хамгаалалтын асуудлыг тусгайлан, цогцоор зохицуулсан эрх зүйн орчин хангалтгүй хэвээр байна.

---

<sup>4</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25”

Хүүхдийн эрхийг хамгаалах нийтлэг хэм хэмжээнд задлан шинжилгээ хийвэл Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.-т “Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно”, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно”, Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр зүйлийн 1-т “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан...” зэрэг зохицуулалт нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдон үүсэх харилцаанд шууд үйлчлэхээр байна.

Харин нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах тусгай хэм хэмжээг судлан үзвэл Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ” мөн зүйлийн 25.3-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхихдах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.”, 25.4-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно” гэсэн нь тухайн асуудлыг зохицуулсан ерөнхий харилцаанд үйлчлэхээр байна.

Монгол Улсын хувьд нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалтай холбоотой нарийвчилсан зохицуулалттай бие даасан хууль байхгүй байна. Нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг 2015 онд Эрүүгийн хуульд хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийг цахим орчин ашиглаж үйлдэх зохицуулалт хийгдсэнээр эхлэл нь тавигдсан байна. Харин цахим орчны хүүхэд хамгаалалтай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах алхмыг хийсэн байна. Тухайлбал, Эрүүгийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжид хүүхдийг цахим орчны хор хөнөөлөөс хамгаалах, гэм буруутай этгээдэд холбогдох хариуцлагыг хүлээлгэхээр зохицуулсан байдаг.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсанаар Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилах” зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “цахим сүлжээ” гэснийг “кибер орчин” болгон өөрчилсөн байна. Кибер аюулгүй байдлын тухай хуульд “кибер орчин” гэх мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах

боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчин байна гэсэн байна.

Нэгтгэн авч үзэхэд хууль тогтоомжийн зохицуулалт нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах, цахим гэмт хэргээс тухайлбал, цахим орчин бэлгийн хүчирхийлэл, зүй бус зар сурталчилгаа, хуурамч, мэдээ, мэдээллээс хэрхэн хамгаалах, сөрөг агуулгатай контентын хандалтыг хязгаарлах, арилгах талаарх эрх зүйн харилцааг цогцоор нь тусгайлан зохицуулаагүй байна.

Тухайлбал, хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахтай холбоотой платформын үүрэг, хариуцлага, насны ангилал болон нас баталгаажуулалтын тогтолцоо, хортой болон насанд тохироогүй контентыг хязгаарлах механизм, цахим орчны эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, шуурхай арга хэмжээ авах тогтолцоо зэрэг асуудал одоогийн хууль тогтоомжид тодорхой, нарийвчилсан байдлаар тусгагдаагүй байна. Мөн хүүхдийн өгөгдөл, хувийн мэдээллийг хамгаалах, хүүхдэд чиглэсэн алгоритмын нөлөөллийг зохицуулах, платформын “safety by design” буюу аюулгүй байдлыг анхнаас нь шингээсэн зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн шаардлага хангалттай бүрдээгүй байна.

Судалгаанд оролцсон багш, нийгмийн ажилтан, боловсролын байгууллагын төлөөллүүдийн зүгээс цахим орчны эрсдэлтэй холбоотой асуудалд ажиллах мэдлэг, арга зүй, мэргэжлийн чадавх, эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг онцолсон байна. Түүнчлэн сургуулийн түвшний хүүхэд хамгааллын бодлого тодорхой бус, цахим орчин дахь эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах дотоод журам хангалтгүй, эцэг, эхийн оролцоо сул байгаа нь хүүхэд хамгааллын тогтолцоонд хүндрэл үүсгэж байгааг дурдсан.

Энэ нь хүүхдийн цахим орчин дахь хамгаалалтын асуудлыг зөвхөн салангид зохицуулалт, байгууллага хоорондын уялдаа сул арга хэмжээгээр бус, хүүхдийн эрхэд суурилсан, олон улсын чиг хандлага болон технологийн хөгжлийн онцлогт нийцсэн нэгдсэн бодлого, тусгайлсан эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцсэн хамгаалалтын стандарт, платформын хариуцлагын тогтолцоо, урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх механизм, хүүхэд хамгааллын байгууллагуудын хамтын ажиллагааг эрх зүйн түвшинд тодорхой болгох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

## **1.2. Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай ойлголтыг хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан байдал**

Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, нийгмийн сүлжээний хэрэглээ, цахим эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, мөн багш, нийгмийн ажилтан, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдээс нийт 9,852 оролцогчийг хамруулсан 3 бүлгийн судалгааг зохион байгуулсан байна. Үүнээс хүүхдийн судалгаанд 6,080 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн судалгаанд 3,102 хүн, багш, мэргэжилтэн, нийгмийн ажилтны судалгаанд 670 оролцогч тус тус хамрагдсан бөгөөд судалгаа нь Улаанбаатар хот болон 21 аймгийн төлөөллийг хамарсан үндэсний хэмжээний түүвэр болсон байна.

Гурван судалгааны нэгдсэн үр дүнгээс харахад хүүхдийн цахим хэрэглээ Монгол Улсад өндөр түвшинд хүрч, өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон бөгөөд хүүхэд, эцэг эх, багш нарын бүх бүлэг цахим орчны эрсдэлийг бодитойгоор хүлээн зөвшөөрч байна. Хүүхдүүдийн хамгийн өргөн хэрэглэдэг платформ нь Facebook, TikTok, Instagram, YouTube байсан бөгөөд алгоритмд суурилсан богино видео, олон платформ дамнасан хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байгааг бүх бүлгийн оролцогчид ижил байдлаар тодорхойлсон байна.

Судалгааны үр дүнгээр хүүхдүүд цахим дээрэлхэлт, хортой контент, танихгүй хүнээс ирсэн чат, цахим залилан, сэтгэл зүйн дарамт, донтуулах шинжтэй контент зэрэг олон төрлийн эрсдэлд өртөж байгаа нь тогтоогдсон. Хүүхдүүд өөрсдөө цахим орчны эрсдэлийг мэдэрч байгаагаа илэрхийлсэн бол эцэг эх, багш нар эдгээр эрсдэл хүүхдийн зан төлөв, сэтгэл зүй, нийгмийн харилцаа, сурлагын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байгааг онцолсон байна. Ялангуяа багш нарын 52.2 хувь нь зан төлөвийн өөрчлөлт, 45.2 хувь нь сэтгэл зүйн шинж тэмдэг, 42.1 хувь нь цахим хэрэглээтэй холбоотой донтолт ажиглагдаж байгааг тэмдэглэсэн нь цахим орчны эрсдэл хүүхдийн хөгжилд бодит нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Мөн гурван бүлгийн оролцогчдын дунд хүүхдийн цахим орчны хамгаалалтад “child safety by default” буюу анхдагч хамгаалалтын зарчим хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн байр суурь маш өндөр түвшинд илэрсэн. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүүхдийн аккаунтыг private тохиргоотой болгох, танихгүй хүнээс ирэх мессежийг хязгаарлах, ёс бус сэтгэгдлийг автоматаар устгах, дэлгэц ашиглалтын хугацаа болон шөнийн хэрэглээг хязгаарлах, донтуулах богино видео болон насанд тохироогүй контентыг автоматаар шүүх шаардлагатай гэж үзсэн байна.

Түүнчлэн хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг зөвхөн гэр бүлийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй болсон бөгөөд платформын хариуцлага, алгоритмын зохицуулалт, хүүхдийн мэдээлэл хамгаалалт, боловсролын байгууллагын оролцоо, цахим боловсролын тогтолцоог уялдуулсан цогц эрх зүйн орчин шаардлагатай байгаа нь судалгааны нэгдсэн дүгнэлтээр тодорхой харагдаж байна. Эцэг эхийн оролцоо сул, хүүхдүүд асуудлаа нууж хаадаг, багш нарын арга зүйн мэдлэг хангалтгүй зэрэг хүндрэлүүд нийтлэг илэрсэн нь хүүхэд хамгааллын тогтолцоог цахим орчны шинэ нөхцөлд нийцүүлэн шинэчлэх бодит шаардлага бий болсныг харуулж байна.

Нэгдсэн дүнгээр авч үзвэл хүүхдийн цахим орчны эрсдэл нь зөвхөн хэрэглээний асуудал бус хүүхдийн эрх, аюулгүй байдал, сэтгэл зүй, эрүүл хөгжил, мэдээллийн аюулгүй байдалтай шууд холбоотой нийгмийн хэмжээний асуудал болсон бөгөөд хүүхдийг цахим орчинд хамгаалах тусгайлсан эрх зүйн зохицуулалт, платформын үүрэг хариуцлага, насны ангилалд суурилсан хамгаалалтын механизм, алгоритмын аюулгүй байдлын зохицуулалт, урьдчилан сэргийлэх боловсролын бодлого зайлшгүй шаардлагатай байгаа нь дээрх судалгаануудаар нотлогдож байна.

### ***а/ Хүүхдээс авсан судалгааны үр дүн:***

Судалгаанд Монгол Улсын хэмжээнд 11–17 насны нийт 6,080 хүүхэд хамрагдсан бөгөөд оролцогчдын 50.7 хувь нь Улаанбаатар хот, үлдсэн нь орон нутгийн бүсүүдээс оролцсон нь судалгааны түүвэр газарзүйн өргөн хамрах хүрээтэй байсныг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн цахим хэрэглээ өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон бөгөөд оролцогчдын 71.6 хувь нь өдөрт 1–5 цаг, 20 гаруй хувь нь 5-аас дээш цагийг цахим орчинд өнгөрүүлдэг байна. Нас ахих тусам цахим хэрэглээний хугацаа нэмэгдэж, 16–17 насны хүүхдүүдийн 31.7 хувь нь өдөрт 5-аас дээш цагийг цахим орчинд өнгөрүүлдэг нь анхаарал татаж байна.

Хүүхдүүдийн хамгийн түгээмэл ашигладаг платформ нь Instagram, YouTube, Facebook, TikTok байсан бөгөөд нас ахих тусам алгоритмд суурилсан, олон платформ зэрэг ашиглах хэрэглээ нэмэгдэж байгаа нь тогтоогдсон. Мөн цахим орчинд тулгарч буй гол эрсдэлд танихгүй хүнээс ирсэн чат, айдас төрүүлсэн контент, цахим дээрэлхэлт, донтуулах шинжтэй богино видео, хуурамч хаяг зэрэг асуудлууд багтаж байна. Ялангуяа эдгээр эрсдэл 16–17 насны хүүхдүүдийн дунд илүү өндөр түвшинд илэрсэн байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн дийлэнх нь цахим орчинд хамгаалалтын тусгай тохиргоо, насанд тохирсон контентын хязгаарлалт шаардлагатай гэж үзсэн бөгөөд 88.2 хувь нь насанд тохироогүй контентыг хязгаарлах, 83.4 хувь нь танихгүй хүн чат бичихийг хязгаарлах, 82.5 хувь нь ёс бус сэтгэгдлийг автоматаар устгах тохиргоог дэмжсэн байна. Мөн 85.4 хувь нь хүүхдийг хортой контентоос хамгаалах зорилгоор тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэж хариулсан нь хүүхдүүд өөрсдөө цахим орчны эрсдэлийг бодитоор мэдэрч байгааг харуулж байна.

Түүнчлэн судалгааны үр дүнгээс хүүхдүүдийн олонх цахим хэрэглээ нь нойр, сэтгэл зүй, төвлөрөл, зан төлөвт сөрөг нөлөө үзүүлдэг болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд шөнийн хэрэглээ, онлайн тоглоом, богино видео болон алгоритмын нөлөөллийг хамгийн эрсдэлтэй хүчин зүйлс гэж үзсэн байна. Үүний зэрэгцээ хүүхдүүдийн 59.2 хувь нь цахим орчны аюулгүй байдлын талаарх сургалт сургууль дээр хэрэгтэй гэж үзсэн нь дижитал боловсрол, хүүхэд хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

### ***б/ Эцэг эхээс авсан судалгааны үр дүн:***

Эцэг эх, асран хамгаалагчаас авсан энэхүү судалгаанд нийт 3,102 хүн хамрагдсан бөгөөд оролцогчид Улаанбаатар хот болон 21 аймгийн төлөөллийг хамарсан байна. Үүнээс Төвийн бүсээс 1,017 хүн (32.8%), Баруун бүсээс 952 хүн (30.7%), Зүүн бүсээс 381 хүн (12.3%), Улаанбаатар хотоос 251 хүн (8.1%), Хангайн бүсээс 137 хүн (4.4%), Говийн бүсээс 66 хүн (2.1%) тус тус оролцсон бөгөөд 297 оролцогч (9.6%) бүсээ тодорхойлоогүй байна. Энэ нь судалгаанд нийслэл болон орон нутгийн өргөн хүрээний төлөөлөл хамрагдсаныг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн цахим хэрэглээ өндөр түвшинд хүрсэн бөгөөд оролцогчдын 67.1 хувь нь хүүхдээ өдөрт 1–5 цаг цахим орчинд зарцуулдаг гэж хариулсан бол 17.2 хувь нь 5 цагаас дээш хугацаагаар хэрэглэдэг

гэжээ. Хүүхдүүдийн хамгийн түгээмэл ашигладаг платформ нь YouTube (62.0%), Facebook (48.7%), TikTok (27.6%), Instagram (25.1%) байсан нь алгоритмд суурилсан социал платформын хэрэглээ өндөр байгааг харуулж байна.

Мөн судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүүхдийг цахим орчин дахь хортой контент, цахим дарамт, танихгүй хүнтэй харилцах эрсдэлээс хамгаалах шаардлагатай гэж үзсэн байна. Тухайлбал оролцогчдын 92.4 хувь нь насанд тохироогүй контентод хязгаарлалт тавих шаардлагатай, 97.0 хувь нь хортой контентыг устгах хугацааг хуульчлах шаардлагатай гэж хариулсан бол 92.2 хувь нь нийгмийн сүлжээний алгоритм хүүхдийг донтуулж, хэт удаан ашиглахад нөлөөлдөг гэж үзсэн байна.

Түүнчлэн “child safety by default” буюу хүүхдийн хамгаалалтын автомат тохиргоог анхдагчаар идэвхжүүлэх шаардлагатай гэсэн олон нийтийн дэмжлэг маш өндөр гарсан. Үүнд насанд хүрэгчдийн болон сэтгэл зүйн сөрөг контентыг хязгаарлах (96.6%), шөнийн хэрэглээг хязгаарлах (95.5%), донтуулах богино видеог хязгаарлах (95.5%), танихгүй хүнээс ирэх мессежийг хязгаарлах (94.7%), хувийн хаягийг private тохиргоотой болгох (92.4%) зэрэг хамгаалалтын арга хэмжээг оролцогчдын дийлэнх нь дэмжсэн байна.

#### ***в/ Багш ажилчдаас авсан судалгааны үр дүн:***

Судалгаанд нийт 670 багш, боловсрол болон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэжилтэн хамрагдсан бөгөөд үүнээс 615 багш (91.8%), 23 нийгмийн ажилтан (3.4%), 6 хүүхдийн сэтгэл зүйч (0.9%), 4 сургалтын менежер (0.6%) оролцсон байна. Мөн цөөн тооны асран хамгаалагч, эмч, мэргэжилтэн болон бусад ажилтнууд хамрагдсан болно.

Бүсчилсэн байдлаар авч үзвэл судалгаанд Ховд аймгаас 224 оролцогч (33.4%), Дархан-Уул аймгаас 190 оролцогч (28.4%), Төв аймгаас 125 оролцогч (18.7%), Хэнтий аймгаас 82 оролцогч (12.2%), Завхан аймгаас 25 оролцогч (3.7%), Улаанбаатар хотоос 17 оролцогч (2.5%) тус тус хамрагдсан байна. Энэ нь хүүхдийн цахим орчны эрсдэл зөвхөн нийслэл бус орон нутгийн хэмжээнд нийтлэг тулгамдсан асуудал болсныг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад багш, мэргэжилтнүүдийн дийлэнх нь сурагчид цахим орчинд цахим дээрэлхэлт, хортой контент, танихгүй хүнээс ирсэн мессеж, цахим залилан, бэлгийн шинжтэй дарамт зэрэг олон төрлийн эрсдэлд өртөж байгааг ажигласан байна. Мөн цахим орчинд асуудалд өртсөн хүүхдүүдэд зан төлөвийн өөрчлөлт (52.2%), сэтгэл зүйн шинж тэмдэг (45.2%), цахим хэрэглээтэй холбоотой донтолт (42.1%) түгээмэл илэрч байгааг онцолсон байна.

Хүүхдүүдийн хамгийн өргөн хэрэглэдэг платформыг Facebook (85.2%), TikTok (68.4%), Instagram (63.2%), YouTube (53.9%) гэж тодорхойлсон бөгөөд алгоритмд суурилсан богино видео болон олон платформ дамнасан хэрэглээ нэмэгдэж байгааг багш нар онцолсон байна.

Түүнчлэн оролцогчдын 94.6 хувь нь хүүхдийг нас, хөгжлийн онцлогт тохироогүй хортой контентоос хамгаалах зорилгоор тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэж үзсэн бөгөөд 95–97 хувийн дэмжлэгтэйгээр хүүхдийн аккаунтыг “private” тохиргоотой болгох, танихгүй хүнээс ирэх мессежийг хязгаарлах, ёс бус комментыг автоматаар устгах, шөнийн хэрэглээ болон донтуулах богино видеог хязгаарлах зэрэг “child safety by default” хамгаалалтын механизмыг дэмжсэн байна.

Судалгааны нэгдсэн дүнгээс үзэхэд хүүхдийн цахим орчны эрсдэл нь боловсролын байгууллагын түвшинд бодитоор илэрч байгаа бөгөөд хүүхэд хамгааллын эрх зүйн орчин, платформын хариуцлага, цахим боловсрол, эцэг эхийн оролцоо болон сургуулийн дотоод хамгаалалтын тогтолцоог цогцоор нь боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

#### Хүснэгт 1. Ерөнхий судалгааны харьцуулалт

№	Судалгааны чиглэл	Гол тоон үзүүлэлт	Дүн шинжилгээ	Хуулийн хэрэгцээ, шаардлага
1	Судалгааны хамрах хүрээ	Эцэг эх, асран хамгаалагчийн судалгаанд <b>3102 хүн</b> , багш, нийгмийн ажилтан, боловсролын байгууллагын ажилтны судалгаанд <b>670 хүн</b> оролцсон.  <b>Эцэг эхийн судалгаанд</b> Төвийн бүс 32.8%, Баруун бүс 30.7%, Зүүн бүс 12.3%, Улаанбаатар 8.1%-ийг эзэлсэн.  <b>Багш нарын судалгаанд</b> Ховд 33.4%, Дархан-Уул 28.4%, Төв 18.7%, Хэнтий 12.2% оролцсон.	Судалгааны оролцоо орон нутагт өндөр байгаа нь хүүхдийн цахим орчны эрсдэл зөвхөн нийслэл төвтэй бус, улсын хэмжээнд нийтлэг тулгамдсан асуудал болсныг харуулж байна.	Хууль нь улсын хэмжээнд жигд хэрэгжих, хот хөдөөгийн ялгааг харгалзсан зохицуулалттай байх шаардлагатай.
2	Оролцогчдын нас, ажиллаж буй хүүхдийн нас	<b>Эцэг эхийн</b> 48.8% нь 36–45 нас, 29.2% нь 26–35 нас, 19.1% нь 46-аас дээш насныхан байна.  <b>Багш нарын</b> 31.5% нь бага анги, 28.2% нь	Хүүхдийн цахим хэрэглээний эрсдэл бага ангиас эхлэн нэмэгдэж байгаа бөгөөд идэвхтэй хүүхэд өсгөн хүмүүжүүлж буй насныхан энэ	Бага наснаас нь цахим аюулгүй байдлын боловсрол олгох, насанд тохирсон хэрэглээний

		дунд ба ахлах ангийн хүүхэдтэй ажилладаг.	асуудалтай хамгийн их тулгарч байна.	зохицуулалт шаардлагатай.
3	Хүүхдийн цахим хэрэглээний хугацаа	Хүүхдийн 37.6% нь өдөрт 1–3 цаг, 29.5% нь 3–5 цаг, 13.5% нь 5–8 цаг, 3.7% нь 8 цагаас дээш хугацааг цахим орчинд өнгөрүүлдэг. Нийт хүүхдийн 67.1% нь өдөрт 1–5 цаг, 17.2% нь 5 цагаас дээш хэрэглээтэй.	Хүүхдийн цахим хэрэглээ өдөр тутмын хэвийн хэрэглээнээс давж, донтох эрсдэлтэй түвшинд хүрч байгааг харуулж байна. Урт хугацааны хэрэглээ нь нойрны алдагдал, анхаарал төвлөрөл сулрах, сэтгэл зүйн өөрчлөлт, сурлагын бууралтад нөлөөлөх эрсдэлтэй.	Дэлгэц ашиглалтын хугацааны зөвлөмж, насны ангилалтай автомат хязгаарлалт, эцэг эхийн хяналтын хэрэгслийг хуульчлах шаардлагатай.
4	Хүүхдийн хамгийн их ашигладаг платформ	<b>Эцэг эхийн судалгаанд</b> YouTube 62.0%, Facebook 48.7%, TikTok 27.6%, Instagram 25.1%, онлайн тоглоом 22.9% байна. <b>Багш нарын судалгаанд</b> Facebook 85.2%, TikTok 68.4%, Instagram 63.2%, YouTube 53.9%, онлайн тоглоом 40.4% гэж үнэлсэн.	Эцэг эх хүүхдийн харагдах хэрэглээг илүү анзаарч байгаа бол багш нар хүүхдийн харилцаа, дээрэлхэлт, сэтгэл зүйн нөлөө илүү ажиглагддаг платформыг өндөр үнэлжээ. Энэ нь хүүхдийн бодит хэрэглээ гэр бүлийн хяналтаас давсан байж болзошгүйг харуулж байна.	Хуулийн зохицуулалт нэг платформд бус олон платформ дамнасан, нэгдсэн хамгаалалтын бодлоготой байх шаардлагатай.
5	Хүүхдийн цахим орчинд тулгарч буй эрсдэл	<b>Эцэг эхийн</b> 52.9% нь “тулгарч байгаагүй”, 26.0% нь “мэдэхгүй” гэж хариулсан. <b>Харин багш нарын судалгаанд</b> “тулгарч байгаагүй” дөнгөж 15.5% байсан бөгөөд цахим дээрэлхэлт 11.8%, хортой контент 7.5%, хавсарсан олон төрлийн эрсдэл өндөр гарсан.	Эцэг эх хүүхдийн бодит эрсдэлийг бүрэн мэдэхгүй байгаа бол багш нар хүүхдийн зан төлөв, сэтгэл зүйд илэрч буй үр дагаврыг илүү бодитоор ажиглаж байна.	Эрсдэлийг мэдээлэх, бүртгэх, хамгаалах нэгдсэн тогтолцоо болон эцэг эхийн мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай.

6	Эцэг эхийн хяналт ба багшийн ажиглалт	<p><b>Эцэг эхийн</b> 51.7% нь “заримдаа”, 34.3% нь “тогтмол” хяналт тавьдаг гэжээ.</p> <p><b>Харин багш нарын</b> 74.3% нь сурагчид асуудлаа нуудаг, 71.3% нь эцэг эхийн оролцоо сул гэж үзсэн.</p>	Эцэг эхийн өөрийн үнэлгээ болон багш нарын үнэлгээ хоорондоо ихээхэн зөрүүтэй байна. Энэ нь хяналт тогтолцоотой бус, технологийн мэдлэг дутмаг байгааг илтгэнэ.	Эцэг эхэд зориулсан дижитал боловсрол, сургалт, хяналтын хэрэгслийн хүртээмжийг бодлогын түвшинд дэмжих шаардлагатай.
7	Хүүхдийн хувийн орон зай	<p><b>Эцэг эхийн</b> 48.6% нь хүүхдийн хувийн орон зайг хүндэтгэх ёстой гэж үзсэн.</p> <p><b>Багш нарын</b> 89.0% нь эрсдэлд өртсөн сурагчийн мэдээллийг нууцалдаг гэжээ.</p>	Хүүхдийн аюулгүй байдал ба хувийн мэдээллийн хамгаалалтын тэнцвэр чухал байгааг хоёр тал хүлээн зөвшөөрч байна.	Хүүхдийн мэдээлэл хадгалах, дамжуулах, хамгаалах тусгай журам хуульд тусгах шаардлагатай.
8	Насны ангиллаар цахим хэрэглээ	<p><b>Эцэг эхийн байр суурь:</b> 08–10 насанд 42.4% нь “хязгаарлагдмал”, 38.0% нь “огт ашиглуулахгүй” гэж үзсэн. 11–12 насанд 57.4% нь “хязгаарлагдмал”, 26.2% нь “эцэг эхийн хяналттай” ашиглуулах нь зөв гэж хариулсан. 13–15 насанд 52.8% нь “хязгаарлагдмал”, 35.7% нь “эцэг эхийн хяналттай” ашиглуулах байр суурьтай байна. 16-аас дээш насанд 47.1% нь “хязгаарлагдмал”, 24.0% нь “эцэг эхийн хяналттай”, 21.6% нь “чөлөөтэй” ашиглуулах боломжтой гэж үзсэн.</p>	Судалгааны үр дүнгээс харахад эцэг эх болон багш нарын аль аль нь бага насны хүүхдийн цахим хэрэглээнд хатуу хязгаарлалт шаардлагатай гэж үзэж байна. Ялангуяа 08–10 насанд багш нарын 53.4% нь “огт ашиглуулахгүй” гэсэн байр суурьтай байгаа нь бага ангийн хүүхдүүдийн анхаарал төвлөрөл, зан төлөв, сэтгэл зүйд цахим хэрэглээний сөрөг нөлөө илүү ажиглагдаж байгаатай холбоотой. Нас ахих тусам “хязгаарлагдмал” болон “эцэг эхийн хяналттай”	Хуульд насны ангилалд суурилсан шаталсан зохицуулалт тусгах шаардлагатай. Үүнд бага насны хүүхдийн цахим сүлжээний хэрэглээнд хатуу хязгаарлалт тогтоох, тодорхой нас хүртэл эцэг эхийн зөвшөөрөл болон хяналттай ашиглуулах, өсвөр насныханд зориулсан screen time, шөнийн хэрэглээ, алгоритмын хязгаарлалт, default хамгаалалтын тохиргоог үе шаттай хэрэгжүүлэх зохицуулалт шаардлагатай.

		<p><b>Багш нарын байр суурь:</b> 08–10 насанд 53.4% нь “огт ашиглуулахгүй”, 30.6% нь “хязгаарлагдмал”, 15.7% нь “эцэг эхийн хяналттай” ашиглуулах нь зөв гэж үзсэн. 11–12 насанд 55.1% нь “хязгаарлагдмал”, 25.4% нь “эцэг эхийн хяналттай”, 19.0% нь “огт ашиглуулахгүй” гэж үзсэн. 13–15 насанд 55.8% нь “хязгаарлагдмал”, 36.4% нь “эцэг эхийн хяналттай” ашиглуулах нь зөв гэж хариулсан. 16-аас дээш насанд 46.3% нь “хязгаарлагдмал”, 33.7% нь “эцэг эхийн хяналттай”, 17.8% нь “чөлөөтэй” ашиглуулах боломжтой гэж үзсэн.</p>	<p>ашиглуулах байр суурь давамгайл хэвээр байгаа нь өсвөр насныханд ч цахим орчны эрсдэл өндөр байгааг харуулж байна.</p>	
9	Хүүхдийг хортой контентоос хамгаалах шаардлага	<p><b>Эцэг эхийн байр суурь:</b> 62.5% нь “бүрэн дэмжсэн”, 29.9% нь “санал нийлнэ” гэж хариулсан бөгөөд нийт оролцогчдын 92.4% нь хүүхдийг хортой контентоос хамгаалах зорилгоор тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэж үзсэн.</p> <p><b>Багш нарын байр суурь:</b> 79.1% нь “бүрэн дэмжсэн”, 15.5% нь “санал нийлнэ” гэж</p>	<p>Судалгааны үр дүнгээс харахад эцэг эх болон багш нарын аль аль нь хүүхдийг нас, хөгжлийн онцлогт тохироогүй контентоос хамгаалах шаардлагатай гэдэг дээр өндөр санал нэгдэж байна. Ялангуяа багш нарын дунд “бүрэн дэмжсэн” хувь өндөр байгаа нь хүчирхийлэл, бэлгийн агуулга, амиа хорлолт, донтуулах болон айдас төрүүлэх</p>	<p>Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохироогүй хүчирхийлэл, бэлгийн агуулга, өөртөө гэмтэл учруулах, амиа хорлолтыг өдөөх, донтуулах болон сэтгэл зүйд сөрөг нөлөөтэй контентод хуульчилсан хязгаарлалт тогтоох шаардлагатай. Мөн платформуудыг хүүхдэд чиглэсэн агуулгын ангилал, шүүлтүүр, автомат хамгаалалтын</p>

		хариулсан бөгөөд нийт 94.6% нь хязгаарлалт шаардлагатай гэж үзсэн.	контентын сөрөг нөлөө хүүхдийн зан төлөв, сэтгэл зүй, сургалтын орчинд бодитоор илэрч байгааг харуулж байна.	системтэй байх үүргийг хуульд тусгах шаардлагатай.
10	Хүүхдийн бүртгэлд автоматаар идэвхжүүлэх шаардлагатай хамгаалалтын тохиргоо	<p><b>Эцэг эхийн байр суурь:</b> Хувийн хаягийн нууцлал (private profile) — 92.4%, танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах — 94.7%, байршил хуваалцахыг унтраах — 77.2%, ёс бус үг хэллэгтэй коммент устгах — 95.2%, шөнийн хэрэглээг хязгаарлах — 95.5%, дэлгэц ашиглалтын хугацааны хязгаар — 93.8%, донтох зан төлөв өдөөсөн богино видеог хязгаарлах — 95.5%, насанд хүрэгчдийн болон сөрөг нөлөөтэй контентыг хязгаарлах — 96.6%, насанд тохиромжгүй live/stream хязгаарлах — 94.1%, 2 шатлалт нэвтрэлт (2FA) идэвхжүүлэх — 91.5% гэж тус тус дэмжсэн.</p> <p><b>Багш нарын байр суурь:</b> Хувийн хаягийн нууцлал — 95.4%, танихгүй хүнээс мессеж авахыг хязгаарлах — 95.5%, байршил хуваалцахыг унтраах — 82.2%, ёс бус үг хэллэгтэй коммент</p>	Хоёр бүлгийн дэмжлэг бүх үзүүлэлт дээр 90 хувиас дээш байгаа нь хүүхэд хамгааллыг хэрэглэгч өөрөө идэвхжүүлэх бус платформын анхдагч тохиргоонд суурилуулах шаардлагатай гэсэн бодлогын нийтлэг ойлголт бүрдсэнийг харуулж байна. Ялангуяа насанд хүрэгчдийн контент, ёс бус сэтгэгдэл, донтуулах богино видео, шөнийн хэрэглээ зэрэгт өндөр хязгаарлалт шаардлагатай гэж үзжээ.	Хуульд “Safety by Default” болон “Privacy by Default” зарчмыг тусгах шаардлагатай. Үүнд хүүхдийн аккаунтыг автоматаар private хэлбэрээр үүсгэх, танихгүй хүнтэй холбогдох боломжийг хязгаарлах, насанд тохироогүй контентыг автоматаар шүүх, screen time болон шөнийн хэрэглээний хязгаарлалт, 2 шатлалт хамгаалалт, донтуулах алгоритм болон богино видеоны автомат хязгаарлалтыг платформын заавал мөрдөх үүрэг болгон хуульчлах шаардлагатай.

		устгах — 97.5%, шөнийн хэрэглээг хязгаарлах — 95.5%, дэлгэц ашиглалтын хугацааны хязгаар — 96.0%, донтох богино видеог хязгаарлах — 96.1%, насанд хүрэгчдийн болон сөрөг контентыг хязгаарлах — 97.5%, насанд тохиромжгүй live/stream хязгаарлах — 96.4%, 2 шатлалт нэвтрэлт идэвхжүүлэх — 93.1% гэж тус тус дэмжсэн.		
11	Алгоритмын нөлөө	<b>Эцэг эхийн</b> 92.2%, багш нарын 95.6% нь алгоритм хүүхдийг донтуулдаг гэж үзсэн. Багш нарын 68.1% нь “маш их нөлөөлдөг” гэж хариулсан.	Богино видео, autoplay, notification зэрэг алгоритмын механизм нь хүүхдийн анхаарал төвлөрөл, зан төлөв, сурлагад сөргөөр нөлөөлж байна.	Алгоритмын ил тод байдал, хүүхдэд чиглэсэн донтуулах загварчлалыг хязгаарлах зохицуулалт шаардлагатай.
12	Хортой контентыг устгах хугацаа	<b>Багш нарын</b> 99.0% нь, <b>Эцэг эхчүүдийн</b> 97.0% нь хортой контентыг устгах хугацааг хуульчлах шаардлагатай гэж үзсэн.	Энэ нь судалгааны хамгийн өндөр дэмжлэгтэй үзүүлэлт бөгөөд хортой контент хүүхдэд маш хурдан сөрөг нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.	Контентыг тодорхой хугацаанд устгах платформын үүрэг, хариуцлага, зөрчлийн хариуцлагыг хуульчлах шаардлагатай.

### 1.3. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон нь

Энэхүү хэсэгт нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, хамгаалалттай холбоотой асуудлын хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон бусад этгээдийг тодорхойлж, тэдгээрт үзүүлж буй нөлөөллийг “Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах” тухай хуулийн хүрээнд хийгдсэн тандалтын судалгааны үр дүнд үндэслэн авч үзэв.

Хүснэгт 2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлэг

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1.	Төрийн байгууллага, албан тушаалтан	<ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн сүлжээнд хүүхдийн хэрэглээг зохицуулах, зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр зөвлөмж боловсруулдаг боловч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоо хангалтгүй байна.</li> <li>• Харилцаа холбооны зохицуулах хорооноос эцэг, эх, багш, үйлчилгээ эрхлэгч болон хүүхдэд зориулсан зөвлөмж боловсруулж цахим хуудсаар дамжуулан хүргэдэг боловч тэдгээрийн сурталчилгаа, хэрэглээ, бодит хэрэгжилт сул байна.</li> <li>• Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт цахим орчны зөв зохистой хэрэглээ, эрсдэлийн талаарх агуулга хангалтгүй байгаа тул сургалтын гарын авлага, модуль, хэрэглэгдэхүүн боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн байна.</li> <li>• Цагдаа, прокурор, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байгууллагууд тодорхой төрлийн шторк, зөвлөмж, гарын авлага боловсруулдаг боловч зорилтот бүлэгт үр нөлөөтэй хүрч чадахгүй байна.</li> </ul>
2.	Аж ахуйн нэгж, байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>• Интернетийн үйлчилгээ эрхлэгчид насанд хүрээгүй хэрэглэгчдэд зориулсан сөрөг мэдээлэл шүүх программ, хамгаалалтын хэрэгслийн талаар мэдээлэл өгөх үүргийг хуульчлан зохицуулах шаардлагатай байна.</li> <li>• Аж ахуйн нэгж, байгууллагууд нийгмийн сүлжээгээр сурталчилгаа, мэдээлэл түгээхдээ насанд хүрээгүй хүнд тохиромжгүй агуулгад анхааруулах тэмдэглэгээ байрлуулах, хандалтыг хязгаарлах техник, программын шийдлийг хангалттай ашиглахгүй байна</li> </ul>
3.	Төрийн бус байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд байгаа боловч хүүхдийн цахим орчны хэрэглээ, эрсдэлийн талаарх судалгаа, шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажил тогтмол, системтэй хэрэгжихгүй байна.</li> </ul>
4.	Иргэн	<ul style="list-style-type: none"> <li>• Цахим платформ, үйлчилгээний төрөл нэмэгдэхийн хэрээр хүүхдийн интернетийн хэрэглээний хугацаа өсөж байгаа боловч эцэг, эхийн хяналт хангалтгүй байна.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг, эхчүүд хүүхдийн ашиглаж буй төхөөрөмж, платформ дээрх хамгаалалтын болон хяналтын тохиргоог идэвхжүүлэхгүй, ашиглах мэдлэг дутмаг байна.</li> <li>• Интернэтийн зохистой хэрэглээ, эрсдэлийн талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх байдал хангалтгүй бөгөөд зарим тохиолдолд эцэг, эх өөрсдөө цахим хэрэглээний мэдлэг, чадвар сул байна.</li> </ul>
5.	Бусад хүн, хуулийн этгээд	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийг зохисгүй, сөрөг нөлөө бүхий контентоос хамгаалах зорилгоор тодорхой хязгаарлалт, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байна.</li> <li>• Цахим хэрэглээтэй холбоотой мэдлэг, мэдээлэл түгээх сургалт, нөлөөллийн контент, олон нийтийн сурталчилгаа хангалтгүй байна</li> </ul>

Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх зөрчигдөж буй нөхцөл байдал нь холбогдох статистик, судалгааны үр дүнгээр илэрч байна. Тухайлбал, “Өсвөр үеийнхний цахим<sup>5</sup> хэрэглээний өнөөгийн байдал” судалгааны “Цахим орчны хүүхдийн эрхийн зөрчил” хэсэгт:

- Гурван хүүхэд тутмын нэг нь цахим орчин дахь хувийн мэдээллийн нууцлалын тохиргооны талаар мэдлэггүй бөгөөд эцэг, эхчүүдийн мэдлэг хүүхдээсээ доогуур түвшинд байгааг;
- Хоёр хүүхэд тутмын нэг нь садар самуун агуулгатай мэдээлэлтэй тогтмол тулгардаг, таван хүүхэд тутмын дөрөв нь цахимаар зүй бус утгатай зурвас хүлээн авдаг бөгөөд эцэг, эхчүүдийн 95 хувь нь ийм төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ ашиглах чадваргүй байгааг;
- Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй эсэхийг тодруулдаггүй, мөн бага насны хүүхэдтэй өрхөд хамгаалалтын программ ашиглуулах талаар мэдээлэл өгдөггүй байгааг;
- Гурван хүүхэд тутмын нэгний гар утасны дугаар өөр хүний нэр дээр бүртгэлтэй байгаа нь хүүхдийг сөрөг нөлөө бүхий мэдээллээс хамгаалах, хяналт тавих боломжийг бууруулж байгааг тус тус дурдсан байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр тусгайлсан эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хүүхдийн цахим орчны эрсдэл нь зөвхөн хүүхдэд бус гэр бүл, боловсролын байгууллага, нийгэмд бүхэлд нь нөлөөлж байна. Юуны өмнө хүүхдийн сэтгэл зүй, зан төлөв, нийгмийн харилцаа, сурлагын үзүүлэлтэд сөрөг өөрчлөлт гарч байгааг

<sup>5</sup> [www.fcy.gov.mn](http://www.fcy.gov.mn), Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан /албан хэрэгцээнд/, 2018 он, х26

багш нар ажигласан байна. Судалгаанд оролцогчдын 52.2 хувь нь зан төлөвийн өөрчлөлт, 45.2 хувь нь сэтгэл зүйн шинж тэмдэг, 42.1 хувь нь цахим хэрэглээтэй холбоотой донтолын шинж ажиглагдсан гэж хариулжээ.

Мөн эцэг эхчүүд хүүхдийн цахим хэрэглээнд хяналт тавихад хүндрэлтэй байгаа бөгөөд технологийн мэдлэгийн ялгаа, цаг завьн асуудал, хүүхдийн эсэргүүцэл зэрэг нь гэр бүлийн орчинд шинэ сорилт болж байна.

Боловсролын байгууллагын хувьд багш, нийгмийн ажилтнуудын ачаалал өндөр, мэдлэг сургалт хангалтгүй, нэгдсэн журам тодорхой бус байгаа нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Иймээс хүүхдийн цахим орчны асуудал нь зөвхөн нэг салбарын асуудал бус хүүхэд, гэр бүл, боловсрол, нийгмийн хамгаалал, хууль эрх зүйн олон талт оролцоог шаардсан нийгмийн цогц асуудал болсон байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, тухайлбал цахим дарамт, гүтгэлэг, цахим шоглолт, садар самуун үйлдэлд уруу татах, сэтгэл санааны болон бие махбодын дарамтад оруулах зэрэг үйлдлийн тоо нэмэгдэж байгаа нь хүүхдийн эрхийг цахим орчинд хамгаалах асуудлыг нэн чухал түвшинд авч үзэх шаардлагыг бий болгож байна. Хүүхдийн хувийн мэдээлэл ил тод байх, эцэг, эхийн хараа хяналт сул байх зэрэг нь хүүхдийг цахим орчны эрсдэл, гэмт хэргийн хохирогч болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн олон нийтийн дунд хүүхдийн цахим оролцоо, хэрэглээтэй холбоотой зөв ойлголт, ухамсар, хандлагыг төлөвшүүлэх, хүүхдэд интернэтийг аюулгүй, зохистой ашиглах мэдлэг олгох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулсан эрх зүйн орчин хангалтгүй байна.

Иймээс нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа нь цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэхгүй орхигдуулах, урьдчилан сэргийлэх тогтолцоо сулрах нөхцөлийг бүрдүүлж байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН НЬ**

Нийгмийн сүлжээ болон цахим платформын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, хүүхдийн өдөр тутмын амьдрал, боловсрол, харилцаа, мэдээлэл авах орчинд гүнзгий нэвтэрч байгаатай холбоотойгоор хүүхдийн цахим орчин дахь эрх, аюулгүй байдлыг хангах асуудал нь төрөөс онцгойлон анхаарах шаардлагатай нийгмийн харилцааны нэг болоод байна. Хэдийгээр цахим орчин нь хүүхдийн хөгжих, суралцах, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нэмэгдүүлж байгаа боловч нөгөө талаас цахим дарамт, хувийн мэдээллийн зөрчил, зохисгүй контент, цахим мөлжлөг, донтох эрсдэл, сэтгэл зүйн сөрөг нөлөөлөл зэрэг шинэ төрлийн эрсдэлийг бий болгож байна.

Иймд нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, хамгаалалттай холбоотой асуудлыг судлан тодорхойлж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолсон болно.

Асуудлыг шийдвэрлэх зорилго нь хүүхдийг цахим орчин дахь аливаа эрсдэл, сөрөг нөлөөлөл, цахим дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, зохисгүй контент, хувийн мэдээллийн зөрчил зэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим орчин дахь хүүхэд хамгааллын тогтолцоо, байгууллагын хамтын ажиллагаа, хяналт, зохицуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн “Цахим орчинд хүүхэд хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулахад оршино.

Түүнчлэн энэхүү хууль нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах зарчимд тулгуурлан цахим орчин дахь хүүхэд хамгааллын нэгдсэн бодлого, урьдчилан сэргийлэх тогтолцоо, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, төр, хувийн хэвшил, эцэг эх, боловсролын байгууллага болон цахим үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэнэ.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1. Цахим платформ, нийгмийн сүлжээ болон үйлчилгээ эрхлэгчдийн хүүхэд хамгааллын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;** Нийгмийн сүлжээ, цахим платформ, интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хүүхдэд сөрөг нөлөө бүхий контентын хандалтыг хязгаарлах, нас баталгаажуулах, хүүхдийн нууцлал хамгаалах, мэдээлэл устгах, гомдол мэдээлэл шийдвэрлэх зэрэг хүүхэд хамгааллын үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- 2. Эцэг, эх, асран хамгаалагч, боловсролын байгууллага болон бусад этгээдийн оролцоо, үүргийг тодорхойлох;** Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийн цахим хэрэглээнд зохистой хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвартай байх, боловсролын байгууллага хүүхдэд цахим боловсрол олгох, цахим орчны аюулгүй хэрэглээний талаарх мэдлэг, дадлыг төлөвшүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.
- 3. Төрийн байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоо, хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох;** Хүүхдийн эрх хамгаалал, цахим хөгжил, боловсрол, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, хяналт, шуурхай арга хэмжээ авах тогтолцоог тодорхой болгож, салбар хоорондын зохицуулалтыг сайжруулна.
- 4. Хүүхдийн нийгмийн сүлжээн дэх эрх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;** Хүүхдийн хувийн мэдээлэл, цахим мөр, харилцаа холбоо, цахим хэрэглээтэй холбоотой мэдээллийг хууль бусаар цуглуулах, ашиглах, түгээх, гуравдагч этгээдэд дамжуулах зэрэг эрсдэлээс хамгаалах, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хамгаалалтын зохицуулалтыг бий болгоно.
- 5. Нийгмийн сүлжээн дэх хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх;** Хүүхэд, эцэг эх, хууль ёсны төлөөлөгчөөс ирүүлсэн гомдол, мэдээллийг

хүлээн авах, шийдвэрлэх, контентыг хязгаарлах, устгах, холбогдох байгууллагад шилжүүлэх үйл ажиллагааг түргэн шуурхай, чирэгдэлгүй хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгоно.

**6. Хүүхдийн цахим боловсрол, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих;**

Хүүхдэд цахим орчны эрсдэл, зохистой хэрэглээ, хувийн мэдээллээ хамгаалах мэдлэг олгох, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

**7. Хүүхдийг сөрөг нөлөө бүхий контент болон цахим эрсдэлээс хамгаалах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;**

Хүүхдэд зориулсан default хамгаалалтын тохиргоо, насны ангилал, эцэг эхийн хяналтын хэрэгсэл, контент шүүх технологи, шөнийн хэрэглээний хязгаарлалт зэрэг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг эрх зүйн хүрээнд тодорхойлно.

**8. Нийгмийн сүлжээн дэх хүүхэд хамгааллын талаар олон улсын чиг хандлага, стандартад нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн хорооны Ерөнхий тайлбар №25 болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн хүүхдийн цахим орчин дахь эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

**ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН НЬ**

Асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг үр дагаврыг харьцуулан судлахдаа Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын Тав дахь хэсэгт заасан зохицуулалтын хувилбар тогтоох аргачлалыг баримталсан болно.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой харилцаа нь өнөөгийн байдлаар Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид салангид, ерөнхий байдлаар зохицуулагдаж байгаа бөгөөд хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалт, платформын үүрэг хариуцлага, насны хамгаалалтын механизм, хортой контентын хязгаарлалт, алгоритмын нөлөөлөл зэрэг шинэ төрлийн эрсдэлийг бүрэн хамарч чадахгүй байна. Иймд уг асуудлыг зөвхөн бодлогын баримт бичиг, захиргааны зохицуулалт, олон нийтийн соён гэгээрүүлэх арга хэмжээгээр бус, тусгайлсан эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх шаардлага үүсэж байна.

Аргачлалын 5.1-д асуудлыг шийдвэрлэх дараах зохицуулалтын хувилбаруудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
- хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
- зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- төрөөс санхүүгийн интервенц хийх;

- төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- захиргааны шийдвэр гаргах;
- хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Дээрх хувилбаруудыг нийгмийн хэрэгцээ, хүүхдийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийн боломж, үр нөлөө, зардал үр өгөөжийн харьцааны хүрээнд харьцуулан судлав.

### Хүснэгт 3. Асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбар

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	“Тэг” хувилбар	Одоогийн эрх зүйн хийдэл хэвээр үргэлжилж, хүүхдийн цахим орчин дахь эрсдэлийг бууруулах боломжгүй байна.	Нэмэлт зардал гарахгүй боловч тулгамдсан асуудал үргэлжилнэ.	Үр дүнгүй
2.	Олон нийтийг соён гэгээрүүлэх	Эцэг эх, багш, хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх боломжтой боловч платформын зохицуулалт, алгоритмын нөлөөллийг шийдвэрлэх боломжгүй.	Тодорхой хэмжээний төсөв шаардагдана. Урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.	Үр дүнгүй
3.	Зах зээлийн механизмаар зохицуулах	Платформууд сайн дурын үндсэн дээр хамгаалалтын тохиргоо хэрэгжүүлэх боломжтой боловч заавал мөрдөх үүрэг үүсэхгүй.	Хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх ч нэгдсэн стандарт тогтохгүй.	Тогтворгүй үр дүнтэй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төсөл, хөтөлбөрөөр тодорхой арга хэмжээ авч болох боловч урт хугацааны эрх зүйн баталгаа бүрдэхгүй.	Өндөр төсөв шаардагдах бөгөөд тогтвортой бус.	Үр дүнгүй
5.	ТББ, хувийн хэвшлээр чиг үүрэг гүйцэтгүүлэх	Хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой ажил хэрэгжих боломжтой боловч улсын хэмжээнд нэгдсэн хэрэгжилт хангах боломжгүй.	Зардал харьцангуй бага боловч хяналт сул байна.	Хэсэгчилсэн үр дүнтэй
6.	Захиргааны шийдвэр, журам гаргах	Түр хугацаанд тодорхой харилцааг зохицуулах боломжтой боловч хүүхдийн эрхийн үндсэн баталгааг бүрдүүлэхэд хангалтгүй.	Зардал бага боловч эрх зүйн хүчин чадал сул.	Хангалтгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалт, платформын үүрэг, хариуцлагыг цогцоор нь	Хэрэгжилтийн тодорхой зардал шаардагдах боловч	Үр дүнтэй

		зохицуулах бүрдэнэ.	боломж	урт хугацаанд үр өгөөж өндөр.	
--	--	------------------------	--------	----------------------------------	--

Дээрх хувилбаруудаас дараах хувилбарыг онцлов.

### **Хувилбар 1. Захиргааны шийдвэр, журам гаргах**

Энэ хувилбарын хүрээнд хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахтай холбоотой тодорхой асуудлыг салбарын журам, дүрэм, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах боломжтой байна.

Тухайлбал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны А/53, А/95, А/76 дугаар тушаалаар баталсан “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам” батлагдан хэрэгжиж байна. Тус журамд:

- Хүүхдэд хортой агуулгыг ангилах;
- Насны ангиллын тэмдэглэгээ хэрэглэх;
- Цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн үүрэг;
- Эцэг эхийн хяналтын тохиргоо;
- Боловсролын байгууллагын үүрэг;
- 18+ контентын шүүлтүүр;
- Хүүхдийг цахим дарамт, урхидалт, дээрэлхэлтээс хамгаалах;
- Хортой агуулгыг устгах, хязгаарлах;
- Платформд хандах хандалтыг түр хязгаарлах зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Гэвч дээрх журам нь практик хэрэгжилтийн хувьд хангалтгүй байгаа нь судалгаа болон бодит нөхцөл байдлаас харагдаж байна. Тухайлбал:

- Олон улсын платформуудад Монгол Улсын журам шууд хэрэгжих эрх зүйн болон техникийн боломж сул;
- Нас баталгаажуулалтын нэгдсэн систем бүрдээгүй;
- Алгоритмын эрсдэлийг бууруулах зохицуулалт тодорхой бус;
- Хүүхдэд ээлтэй default хамгаалалтын тохиргоо нийтлэг хэрэгжихгүй байгаа;
- Эцэг эхийн хяналтын хэрэгслийн хэрэглээ сул;
- Хэрэгжилтэд тавих хяналт, тайлагнал, хариуцлагын механизм хангалтгүй;
- Платформын хүлээх үүрэг, хариуцлага тодорхой бус;
- Хүүхдийн хувийн мэдээлэл хамгаалах зохицуулалт практикт үр нөлөө багатай байна.

Мөн уг журам нь захиргааны хэм хэмжээний актын хүрээнд батлагдсан тул олон улсын платформуудад заавал мөрдүүлэх, зөрчилд үр нөлөөтэй хариуцлага тооцох, хүүхдийн цахим орчин дахь эрхийг бие даасан байдлаар хамгаалах эрх зүйн хүчин чадал хангалтгүй байна.

Иймд зөвхөн журам, дүрмээр зохицуулах хувилбар нь хүүхдийн цахим орчин дахь эрсдэлийг цогцоор нь бууруулах, платформын хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг бодитой хамгаалах зорилгод бүрэн хүрэх боломжгүй гэж үзэв.

### **Хувилбар 2. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах**

Энэ хувилбарын хүрээнд хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг бие даасан хуулиар цогцоор нь зохицуулах боломж бүрдэнэ.

Өнөөгийн байдлаар хүүхдийн цахим орчин дахь хамгаалалттай холбоотой зарим харилцааг Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон салбарын зарим журам, захиргааны актаар хэсэгчлэн зохицуулж байгаа боловч эдгээр зохицуулалт нь нийгмийн сүлжээний платформын үүрэг, алгоритмын эрсдэл, нас баталгаажуулалт, хүүхдэд ээлтэй хамгаалалтын анхны тохиргоо (default safety settings), хүүхдийн мэдээллийн хамгаалалт зэрэг шинэ төрлийн харилцааг бүрэн хамарч чадахгүй байна.

Түүнчлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, захиргааны зохицуулалтын хэрэгжилт сул, олон улсын платформуудад заавал мөрдүүлэх эрх зүйн хүчин чадал хангалтгүй, хяналт, хариуцлагын тогтолцоо тодорхой бус байгаа нь хүүхдийн эрхийг бодитоор хамгаалахад хүндрэл үүсгэж байна.

Иймд “Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” бие даасан хуулийн төсөл боловсруулах замаар дараах асуудлыг нэгдсэн бодлого, эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

- Нийгмийн сүлжээний платформын эрх, үүрэг, хариуцлага;
- Хүүхдийн нас баталгаажуулалтын тогтолцоо;
- Хүүхдэд зориулсан default хамгаалалтын тохиргоо;
- Хүүхдийн хувийн мэдээлэл хамгаалах;
- Хортой болон насанд тохироогүй агуулгын хязгаарлалт;
- Алгоритмын эрсдэлийг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- Хүүхдэд чиглэсэн зан төлөвт суурилсан сурталчилгааг зохицуулах;
- Эцэг эхийн хяналт, мэдээлэл авах боломж;
- Хүүхдийн цахим боловсрол, урьдчилан сэргийлэх тогтолцоо;
- Төрийн байгууллагуудын чиг үүрэг, хамтын ажиллагааны уялдаа;
- Платформын тайлагнал, хяналт, хариуцлагын механизм.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооны 2021 оны “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25”-д улс орнууд хүүхдийн эрхэд суурилсан, эрсдэлд суурилсан, насны онцлогт тохирсон зохицуулалт хэрэгжүүлэх, платформын хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангах шаардлагатайг зөвлөсөн нь энэхүү хувилбарын хэрэгцээ, үндэслэлийг бататгаж байна.

Түүнчлэн Европын Холбооны Digital Services Act (2022), Их Британийн Online Safety Act (2023), Австралийн Online Safety Act (2021) зэрэг олон улсын эрх зүйн зохицуулалтад платформын эрсдэлийн үнэлгээ, хүүхдийн аюулгүй байдлын үүрэг, алгоритмын нөлөөллийг бууруулах, хүүхдэд ээлтэй хамгаалалтын тохиргоог хуульчилсан нь дэлхий нийтийн чиг хандлага болж байна.

Иймд “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалтыг хүний эрхэд суурилсан, тогтвортой, хэрэгжилттэй эрх зүйн орчноор хангах боломжтой бөгөөд асуудлыг урт хугацаанд системтэйгээр шийдвэрлэх хамгийн үр нөлөөтэй хувилбар гэж үзэж байна.

**ДӨРӨВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН НЬ**

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газраас баталсан аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Энэ талаарх тодорхой хариултыг Хавсралт 3-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

#### **4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Хүүхдийн эрх нь хүний эрхийн салшгүй хэсэг бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхдийн амьд явах, хөгжих, хамгаалуулах, оролцох үндсэн эрхийг баталгаажуулсан байдаг. Монгол Улс тус конвенцод 1990 онд нэгдэн орсон бөгөөд хүүхдийн эрхийг Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар хамгаалж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25” (General Comment No.25 on children’s rights in relation to the digital environment)-д хүүхэд цахим орчинд оролцох, мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, хөгжих эрхтэй боловч цахим орчин дахь эрсдэлээс хамгаалагдах ёстойг онцлон тодорхойлсон байдаг. Тус ерөнхий тайлбарт улс орнууд хүүхдийн эрхэд суурилсан, насны онцлогт тохирсон, эрсдэлд суурилсан зохицуулалтыг хэрэгжүүлэх, платформын хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах, хортой агуулга болон алгоритмын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй болохыг зөвлөсөн байна.

Мөн хүүхдийн цахим орчин дахь хамгаалалт нь хүүхдийн мэдээлэл авах, боловсрол эзэмших, цахим оролцооны эрхийг хязгаарлах хэлбэрээр бус, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах, аюулгүй орчин бүрдүүлэх зарчимд үндэслэх ёстойг тэмдэглэсэн байдаг.

Гэвч цахим технологи, нийгмийн сүлжээний хэрэглээ эрчимтэй нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд хүүхэд цахим дарамт, бэлгийн мөлжлөг, хортой агуулга, донтуулах алгоритмын нөлөөлөл, хувийн мэдээллийн зөрчил зэрэг шинэ төрлийн эрсдэлд өртөх болсон нь хүүхдийн аюулгүй орчинд амьдрах, хөгжих эрхэд сөргөөр нөлөөлж байна.

“Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төсөл боловсруулах хувилбар нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны дээрх зөвлөмж, олон улсын чиг хандлагад нийцүүлэн хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах, платформын хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн насны онцлогт тохирсон хамгаалалтын механизмыг бий болгох, хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэж байна.

Түүнчлэн хүүхдийн цахим орчин дахь бэлгийн мөлжлөг, цахим дарамт, хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх, хүүхдийн эрхийн баталгааг хангах эерэг үр нөлөөтэй болно.

#### **4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд хүүхдийн цахим аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх эерэг үр нөлөөтэй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллага, олон

улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, техник технологийн хамгаалалтын шийдэл нэвтрүүлэх, цахим боловсролыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Мөн цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, цахим дарамтаас урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжирснаар нийгэм, эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээтэй холбоотой урт хугацааны зардлыг бууруулах ач холбогдолтой.

#### **4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд эерэг үр нөлөө үзүүлнэ.

Тухайлбал:

- Хүүхдийн нас баталгаажуулалтын систем,
- Хүүхдэд зориулсан default хамгаалалтын тохиргоо,
- Хортой агуулгыг шүүх болон ангилах технологи,
- Алгоритмын эрсдэлийг бууруулах арга хэмжээ,
- Эцэг эхийн хяналтын хэрэгсэл,
- Хүүхдийн цахим боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо зэрэг хамгаалалтын механизмыг үе шаттай нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Түүнчлэн боловсролын байгууллага, эцэг эх, платформ үйлчилгээ эрхлэгч болон төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж, хүүхдэд ээлтэй цахим орчны соёлыг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Нийгмийн сүлжээний хэрэглээтэй холбоотой цахим дарамт, сэтгэл зүйн эрсдэл, донтох зан үйл, хортой контентын нөлөөллийг бууруулах замаар хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд хөгжих нөхцөл сайжрах ач холбогдолтой.

#### **4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

“Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний үзэл баримтлал, хүүхдийн эрхийг хамгаалах зарчимтай нийцнэ. Түүнчлэн:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц,
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт,
- Хүүхдийн эрхийн тухай хууль,
- Хүүхэд хамгааллын тухай хууль,
- Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль,
- Кибер аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой уялдаж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэнэ.

## **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙСЭН БАЙДАЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг болон “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-д заасны дагуу үүссэн асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын дараах боломжит хувилбаруудыг судалсан болно. Үүнд:

- Захиргааны шийдвэр гаргах буюу журам, дүрмээр зохицуулах;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Дээрх хувилбаруудын хүрээнд хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, нийгмийн сүлжээний платформын үүрэг хариуцлага, хүүхдийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийн боломж, эрх зүйн хүчин чадал, урт хугацааны үр нөлөө зэргийг харьцуулан үнэлэв.

Захиргааны шийдвэр гаргах буюу журам, дүрмээр зохицуулах хувилбарын хүрээнд тодорхой зохицуулалтууд хэрэгжиж эхэлсэн байна. Тухайлбал, “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-аар хүүхдэд хортой агуулгыг хязгаарлах, насны ангилал хэрэглэх, эцэг эхийн хяналтын тохиргоо, платформд тавих тодорхой шаардлагыг тусгасан байна.

Гэвч дээрх зохицуулалт нь:

- Олон улсын платформуудад заавал мөрдүүлэх эрх зүйн хүчин чадал сул;
- хэрэгжилт, хяналтын тогтолцоо хангалтгүй;
- Нас баталгаажуулалтын нэгдсэн систем бүрдээгүй;
- Алгоритмын эрсдэл, хүүхдийн мэдээллийн хамгаалалт, default хамгаалалтын тохиргоо зэрэг асуудлыг бүрэн зохицуулаагүй;
- Платформын хүлээх үүрэг, хариуцлага тодорхой бус зэрэг хүндрэлтэй байгаа нь практик хэрэгжилтээс харагдаж байна.

Иймд зөвхөн журам, захиргааны актаар зохицуулах нь хүүхдийн цахим орчин дахь эрсдэлийг бууруулах, хүүхдийн эрхийг бодитой хамгаалах, платформын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгод бүрэн хүрэхэд хангалтгүй гэж үзэв.

Харин хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалттай холбоотой харилцааг цогцоор нь зохицуулах боломжтой байна. Тухайлбал:

- Платформын үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Хүүхдийн нас баталгаажуулалтын тогтолцоог бий болгох;
- Хүүхдэд зориулсан default хамгаалалтын тохиргоог хуульчлах;
- Хортой болон насанд тохироогүй агуулгын хязгаарлалт тогтоох;
- Алгоритмын эрсдэлийг бууруулах;
- Хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах;
- Эцэг эхийн хяналтын механизмыг тодорхой болгох;
- Төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдааг хангах зэрэг асуудлыг хүний эрхэд суурилсан, тогтвортой эрх зүйн орчны хүрээнд шийдвэрлэх боломж бүрдэж байна.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооны 2021 оны “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25”-д улс орнууд хүүхдийн эрхэд суурилсан, эрсдэлд суурилсан зохицуулалт хэрэгжүүлэх, платформын хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах

үүрэгтэй болохыг зөвлөсөн нь энэхүү зохицуулалтын хувилбарын хэрэгцээ, үндэслэлийг бататгаж байна.

Иймд дээрх зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан үзэхэд “Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүүхдийн эрхийг хамгаалах, цахим орчин дахь эрсдэлийг бууруулах, олон улсын чиг хандлагад нийцсэн тогтвортой эрх зүйн орчныг бүрдүүлэх боломжтой хамгийн үр нөлөөтэй хувилбар гэж дүгнэв.

Мөн уг хуулийн төслийг боловсруулж, хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, чөлөөтэй байх эрх, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцоор хүлээсэн үүргийг хангах ач холбогдолтой байна.

Түүнчлэн энэхүү зохицуулалт нь хүүхдийн цахим аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох, цахим орчин дахь хүүхдийн эсрэг эрсдэлийг бууруулах замаар нийгэм, хүний хөгжилд эерэг үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

## **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)**

Бид олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийхдээ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 8.3-т заасан “эрх зүйн соёл түүх, газар зүйн байршил, эрх зүйн эх сурвалжийн ангилал”<sup>6</sup>-ыг харгалзан үзсэний зэрэгцээ нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг баталж, жишиг болгон хөгжүүлж чадсан улс орнуудыг сонгосон болно.

### **НЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### **1.1. АВСТРАЛИ УЛСЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Австрали улс 2015 онд Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийг баталсан бөгөөд 2021 онд өргөжүүлж Цахим аюулгүй байдлын тухай хууль<sup>7</sup>-ийг баталсан ба тус хууль нь 2022 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэхүү хуулийн онцлог нь насанд хүрээгүй хүүхэд болон насанд хүрсэн Австрали хүн бүрт үйлчилж байгаагаар онцлог юм. Тус хууль нь нийт 16 хэсэг, 240 зүйлээс бүрдэх төрөлжсөн хууль юм. Нийт 209 хуудсаас бүрдэх тус хуулийн хуулийн зорилт нь:

- (а) Австраличуудын цахим орчны аюулгүй байдлыг сайжруулах; болон
- (б) Австраличуудын цахим орчны аюулгүй байдлыг дэмжих”<sup>8</sup> болно.

Тус хуулийн 5 дугаар зүйлд нэр томъёоны тодорхойлолтыг оруулж өгсөн бөгөөд “хүүхэд” гэдэг нь 18 насанд хүрээгүй хүнийг хэлнэ гэж заасан. Тус хуулийн 6 дугаар бүлэгт хүүхдийн цахим гадуурхалт, дээрэлхэлтийн талаарх ойлголтыг

<sup>6</sup> Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалын 8.3

<sup>7</sup> 2021 оны Австрали улсын Цахим аюулгүй байдлын тухай хууль

<sup>8</sup> 2021 оны Австрали улсын Цахим аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйл

тодорхойлсон ба дараа дараагийн холбогдох бүлэгт энэ талаарх гомдлыг хэрхэн гаргах, хаана гаргах, хянан шалгах зэрэг ажиллагаануудыг нарийвчлан заасан байсан.

Тус хуульд 2024 оны 12 дугаар сард өөрчлөлт оруулсан бөгөөд тус өөрчлөлтөөр 16 хүртэлх насны хүүхдийн цахим хэрэглээг бүрэн хаахаар зохицуулсан.

Тодруулбал, Австралийн хүүхдүүдийн 80 хувь нь Youtube, TikTok, Instagram, Snapchat зэрэг платформыг ашигладаг бөгөөд ямар нэгэн насны хязгаарлалт байхгүй, хяналтын механизм хангалтгүй зэргээс шалтгаалан насанд хүрээгүй хүүхэд ямар нэгэн шүүлтүүргүйгээр мэдээ, мэдээллийг авах, гэмт хэргийн хохирогч болж байгаа тул ийнхүү хуулийн шаардлагатай арга хэмжээг авч буйгаа зарлажээ.

Тус хуулийн дагуу нийгмийн сүлжээний платформ хөгжүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд 16-аас доош насны хүүхдийг нэвтрүүлэхгүй, хаяг үүсгэхгүй байх үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол торгуулийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Нөгөө талаар энэ нь тухайн хүүхэд болон эцэг, эхэд ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй байх талаар мөн дурджээ.

## **1.2. АНУ-ЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

АНУ-ын нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжид дараах хуулиуд хамаарна. Үүнд:

**1. Нийгмийн сүлжээнд хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (COPPA).** Энэхүү актыг 1998 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталсан бөгөөд 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Энэхүү акт нь 13-аас доош насны хүүхдүүдийн хувийн мэдээллийг цуглуулахад үйлчилнэ. Цахим хуудасны оператор нууцлалын бодлогодоо ямар мэдээлэл оруулах болон эцэг, эх, асран хамгаалагчаас баталгаажуулах зөвшөөрлийг хэзээ, хэрхэн авах, мөн 13-аас доош насныхны маркетинг хязгаарлах зэрэг хүүхдийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахад оператор ямар үүрэг хариуцлага хүлээх зэргийг нарийвчлан тусгасан. Хэдийгээр 13-аас доош насны хүүхдүүд эцэг, эхийнхээ зөвшөөрлөөр хувийн мэдээллээ өгч болох боловч олон цахим сайтууд, ялангуяа олон нийтийн сүлжээний сайтууд зардал, ажлын ачаалал зэргээс шалтгаалан 13-аас доош насны хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэхээс татгалздаг, мөн тэднийг өөрсдийнхөө цахим хуудсыг ашиглахыг хориглодог байна.

Энэхүү хууль нь дараах агуулга бүхий 12 зүйлээс бүрдэнэ: 1. Хүүхэд, 2. Оператор, 3. Комисс, 4. Ил болгох, 5. Холбооны агентлаг, 6. Интернэт, 7. Эцэг, эх, 8. Хувийн мэдээлэл, 9. Эцэг, эхийн баталгаажуулсан зөвшөөрөл, 10. Хүүхдэд чиглэсэн цахим хуудас эсхүл цахим үйлчилгээ, 11. Этгээд, 12. Цахим хаяг тус тус орно.

**2. Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль (CIPA)**- Энэхүү хуулийг АНУ-ын Конгресс 2000 онд баталсан бөгөөд хүүхдүүд интернэт ашиглан садар самуун эсвэл хор хөнөөлтэй контентод нэвтрэхийг хязгаарлах зорилготой болно. CIPA нь E-rate хөтөлбөрөөр дамжуулан интернэт холболт эсвэл дотоод холболтын хөнгөлөлт авдаг сургууль, номын сангуудад тодорхой шаардлага

тавьдаг. Энэхүү хөтөлбөр нь тухайн шаардлага хангасан сургууль, номын сангуудад тодорхой харилцаа холбооны үйлчилгээ, бүтээгдэхүүнийг илүү хямд болгох хөтөлбөр байдаг. 2001 оны эхээр Холбооны улсын харилцаа холбооны комисс (FCC) нь CIPA-г хэрэгжүүлэх дүрмийг гаргаж, 2011 онд тус дүрмийг шинэчилсэн байна.

Хэрэв CIPA-д хамрагдах сургууль, номын сангууд нь технологийн хамгаалалтын арга хэмжээг багтаасан интернэтийн аюулгүй байдлын бодлоготой гэдгийг нотлож баталгаажуулаагүй бол E-rate хөтөлбөрийн хөнгөлөлтийг авахгүй болно. Хамгаалалтын арга хэмжээ нь дараах дүрс зургуудын интернэтийн хандалтыг хаах буюу шүүх ёстой: (а) садар самуун; (б) хүүхдийн порнограф; эсвэл (в) насанд хүрээгүй хүмүүст хор хөнөөлтэй (насанд хүрээгүй хүмүүсийн ханддаг компьютерийн хувьд) дүрс зураг зэрэг болно. Энэхүү интернэтийн аюулгүй байдлын бодлогыг батлахаас өмнө сургууль, номын сангууд нь зохих мэдэгдэл гаргаж, нэгээс доошгүй нийтийн сонголт, уулзалт зохион байгуулж, санал, хүсэлтийг шийдвэрлэнэ.

CIPA-д хамрагдах сургуулиудыг гэрчилгээ олгоходоо дараах хоёр нэмэлт шаардлагыг тавьдаг: 1) интернэтийн аюулгүй байдлын бодлогод насанд хүрээгүй хүүхдүүдийн цахим үйл ажиллагаанд хяналт тавих; 2) XXI зуунд Хүүхдийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу насанд хүрээгүй хүүхдүүдэд нийгмийн сүлжээний цахим хуудас, чат өрөөнд бусад хүмүүстэй харилцах, цахим дарамтын тухай ойлголт, хариу арга хэмжээ авах зэрэг нийгмийн сүлжээнд зохистой зан үйлийг төлөвшүүлэх талаар сургах ёстой.

CIPA-д хамрагдах сургууль, номын сангууд дараах асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн интернэтийн аюулгүй байдлын бодлогыг баталж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Насанд хүрээгүй хүмүүсийн интернэт дэх зохисгүй зүйлд хандах, аюулгүй байдал;
- Цахим шуудан, чат өрөө болон шууд цахим харилцааны бусад хэлбэрийг ашиглах үед насанд хүрээгүй хүмүүсийн аюулгүй байдал;
- Насанд хүрээгүй хүмүүсийн нийгмийн сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх, үүнд "хакердах" болон бусад хууль бус үйлдлийг хориглох;
- Насанд хүрээгүй хүмүүсийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй задруулах, ашиглах, тараахыг хориглох;
- Хүүхдэд хор хөнөөлтэй материалд нэвтрэх эрхийг хязгаарлах арга хэмжээ.

CIPA нь зөвхөн харилцаа холбооны үйлчилгээнд хөнгөлөлт авдаг сургууль, номын сангуудад үйлчилдэггүй бөгөөд сургууль, номын сангууд E-rate-ийн санхүүжилт авахаасаа өмнө CIPA-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхээ баталгаажуулах хэрэгтэй байдаг.

Эрх бүхий этгээд нь шударга ёс болон хууль ёсны бусад зорилгод нийцүүлэн нэвтрэх боломжийг чөлөөтэй олгохын тулд насанд хүрсэн хүн тухайн цахим орчныг ашиглах үед хаалтын эсвэл шүүлтийн программыг идэвхгүй болгож болно.

CIPA нь насанд хүрээгүй эсвэл насанд хүрэгчдийн интернэтийн хэрэглээг хянадаггүй болно.

**3.Нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах тухай хууль (СОРА)**- Энэхүү хуулийг АНУлс 1998 онд баталсан бөгөөд Интернет дэх насанд хүрээгүй хүүхдэд хор хөнөөлтэй гэж тодорхойлсон аливаа материалд насанд хүрээгүй хүмүүсийн хандалтыг хязгаарлах зорилготой байсан боловч 2009 онд болсон гурван ч удаагийн шүүх хурлаар тус хуулийн эсрэг байнгын ажиллагааг идэвхижүүлсэн тул хүчин төгөлдөр болоогүй.

СОРА нь "насанд хүрээгүй хүүхдэд хортой мэдээлэл"-ийг нийтэлдэг бүхий л арилжааны эрхлэгчдийг өөрсдийн сайтад насанд хүрээгүй хүмүүсийн нэвтрэх эрхийг хязгаарлахыг шаардсан байсан.

**4. Хориннэгдүгээр зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль**- Видео үйлчилгээ үзүүлэгчид хүүхдийн порнограф гаргахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг цахим орчин дахь түрэмгийлэгч нараас хамгаалах, улс хоорондын худалдаанд хүүхдийн хувийн мэдээллийг худалдах, худалдан авахыг хязгаарлах зорилгоор 1934 оны Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль юм.

### **6.3 ЯПОН УЛС- ХҮҮХЭД АЮУЛГҮЙ, ТАЙВАН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭХ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ (2008 ОН)**

Энэхүү хууль нь нийгмийн сүлжээнд хүүхдэд хор хөнөөлтэй мэдээлэл түгэн тархсантай холбогдуулан интернэтийг зөв зохистой хэрэглэх чадварыг хүүхдэд суулгахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, тус хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн (filtering) програм хангамжийн ажиллагааг дээшлүүлэх, түүний хэрэглээг түгээн дэлгэрүүлэх, тухайн хор хөнөөлтэй мэдээллийг хүүхэд интернэтээс үзэх боломжийг аль болох багасгах арга хэрэгслийг тодорхойлох замаар хүүхдийн эрхийг хамгаалах зорилготой болно.<sup>9</sup>

Тус хуулиар хүүхдийн интернэтийн зөв зохистой хэрэглээтэй холбоотой үндсэн төлөвлөгөө, боловсрол, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжих, хүүхэд интернэтээс хор хөнөөлтэй мэдээлэл олж үзэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эцэг, эх, асран хамгаалагч, төрийн захиргааны байгууллага, гар утас, интернэтийн оператор компани, хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн (filtering) програм хангамж зохион бүтээгч зэрэг тус харилцаанд оролцогч этгээдүүдийн үүрэг, оролцоо, интернэтийн зөв зохистой хэрэглээтэй холбоотой олон нийтийн байгууллын дэмжлэг, хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн (filtering) үйл ажиллагаа хөгжүүлэгчийн бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулна.

### **6.4 ИТАЛИ УЛС-ХҮҮХДИЙН ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛ, ГАДУУРХАЛТАЙ /CYBER-BULLYING/ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ (2017 ОН)**

Тус хуулиар нийгмийн сүлжээнд хүүхдийг доромжилсон эсвэл нэр төрийг гутаасан мэдээлэл нийтлэх, интернэтээр айлган сүрдүүлэх эсвэл хувь хүний мэдээллийг хулгайлахыг хориглосон. Нийгмийн сүлжээнд дээрэлхүүлж, гадуурхагдсан хохирогч нь тус агуулгыг нийтлэлсэн цахим хуудас эрхлэгчээс тухайн мэдээллийг 48 цагийн дотор устгах шаардлага гаргаж болно. Уг хуулиар Итали

<sup>9</sup> <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=420AC1000000079>

Улсад цахим дээрэлхэл, гадуурхал /cyber-bullying/ гэдэг ойлголтыг хууль зүйн талаас анх удаа тодорхойлж, нийт сургуулиудад интернэт орчин дахь хариуцлагын талаар сурагчдад боловсрол олгох, цахим дээрэлхэл, гадуурхал, цахим орчны зөрчлийг илрүүлж, тэмцэх ажлыг хариуцсан ажилтантай байх шаардлагыг тавьж өгсөн.

## **6.5 БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь цахим аюул заналхийлэл, эрсдэлийн талаар мэдлэгтэй байх, цахим эрин үед интернэт хэрэглэгчдийн хувьд хүүхдүүдийн аюулгүй байдал, хувийн нууцыг хамгаалах мэдлэгтэй байхын зэрэгцээ үйлчлэх боломжтой нэгдсэн хууль тогтоомж, үр дүнтэй техник, захиргааны болон нийгмийн арга хэмжээ авах шаардлагатай гэж үздэг. БНСУ-ын Үндсэн хууль нь иргэний үндсэн эрх чөлөөг баталгаажуулж, хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн эрх чөлөөг зохицуулсан ерөнхий заалтыг агуулдаг бөгөөд тусгай хуулиудад хүүхдийн боловсрол, сайн сайхныг зохицуулсан байдаг.

### **БНСУ-ын Үндсэн хууль<sup>10</sup>-ийн:**

21-р зүйлийн (4): “Үг хэллэг, хэвлэл мэдээллийн аль нь ч бусдын нэр төр, эрхийг зөрчиж, олон нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүйг гутааж болохгүй.”;

37-р зүйлийн (2): “Үндсэн хуульд нэмэлтээр “үндэсний аюулгүй байдал, хууль, хэв журмыг сахиулах, нийтийн сайн сайхны төлөө” шаардлагатай бол Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хязгаарлаж болно” гэж тус тус заасан байдаг.

**Сүлжээний хэрэгжилтийн тухай хууль<sup>11</sup>** /Мэдээлэл, харилцааны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгааллыг дэмжих ажиллагаа/ 2016-ийн:

44-р зүйлийн (5): Интернэтэд жинхэнэ нэрээр бүртгүүлэх (ЖНБ) систем нь 2007 онд танилцуулагдсан. Энэ хуулийн нэг хэсэг болсон тус систем нь 2010 онд БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхэд маргаан дагуулж шийдвэрлэгдэж байсан ба шүүхийн 2010 Хёон Ма 47, 252<sup>12</sup> дугаартай хэрэгт энэ хуулийн 44-р зүйлийн 5 дугаарт заасан жинхэнэ нэрээр бүртгүүлэх системийг Үндсэн хуульд харш гэж үзсэн.

Энэ системийг танилцуулах шалтгаан бол үндэслэлгүй цуурхал, цахим дээрэлхэл, гадуурхалыг зогсоох болон хувийн нууцад халдах зэрэг гэмт хэргээс урьдчилан хамгаалах зорилгоор интернэтэд нэвтрэхээс өмнө нь интернэт хэрэглэгчдийн хэн болохыг баталгаажуулахыг шаарддаг байна. ЖНБ системийг үг хэлэх эрх чөлөөг зөрчсөн гэх үндэслэлээр 2012 онд Үндсэн хуулийн шүүхэд хандсан байна. Үндсэн хуулийн шүүх уг системийг үндсэн хуульд харш гэж үзсэн боловч ЖНБ-ийн зорилгыг хууль ёсны хэмээн үзсэн. Мөн хувийн мэдээллийг хулгайлах хэд хэдэн тохиолдлоос болж ЖНБ-ийг цуцалсан боловч интернэтэд нэвтрэх боломжийг олгох Ай-пин системийг нэвтрүүлсэн явдал нь онцлох хэсэг болсон.

Солонгос улс цахим бүртгэлийн тогтолцоондоо хүүхдийн насыг магадлан тогтоох программыг ашигладаг ба энэхүү программ нь нийгмийн сүлжээнд хүүхдийг

<sup>10</sup> <http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/67127/98324/F2042155478/KOR67127%20English.pdf>

<sup>11</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=38422&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38422&lang=ENG)

<sup>12</sup> <http://opennetkorea.org/en/wp/wp-content/uploads/2014/03/Korean-real-name-law-decision-english.pdf>

хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалахад зориулагдсан. Түүнчлэн тус улс интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудаас хүүхдэд хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн программ ашиглаж байхыг үүрэг болгон хуульчилсан байдаг.

Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>13</sup>

Энэхүү хуулиар сурагч хариуцсан албанд өргөдөл гаргаж буй хохирогч сурагчдыг сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлж, таатай нөхцөл байдлыг төлөвшүүлэх зорилгоор хохирогч, түрэмгийлэн халдагч сурагчдыг хооронд нь эвлэрүүлэх замаар суралцагчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Тус хуульд “Цахим дээрэлхэл, гадуурхал” гэдгийг интернэт, гар утас болон бусад мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслээр суралцагчид тодорхой сурагчийн хувийн мэдээллийг задруулах, эсвэл тухайн сурагчийн талаар худал, цуурхал тараах зорилгоор бусад сурагчдын сэтгэл санааг хохироож, зовлон шаналалд унагах, улмаар байнга болон давтан үйлдэх аливаа хэлбэрийг хэлнэ<sup>14</sup> гэж тодорхойлсон бол “сургууль” гэж Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, тусгай сургууль, төрөлжсөн сургуулийг, мөн дээрх хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу үйл ажиллагаа явуулж буй сургуулийг хэлнэ<sup>15</sup> гэж заасан.

## 6.6 ШВЕД УЛС

Швед Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид 1990 онд нэгдэн орж, 2020 оны 1-р сарын 1-нд дотоодын хууль тогтоомжуудаа уялдуулсан байна<sup>16</sup>. Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд ерөнхий дэмжлэг болгох зохицуулалтыг Мэдээллийг хамгаалах ерөнхий журам /GDPR/<sup>17</sup>-д тусгасан.

Швед Улс нь Европын Холбоонд 1995 оны 1 сарын 1-ны өдөр нэгдэн орсон тул Европын Холбооны хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт<sup>18</sup> тус улсад үйлчилнэ.

Европийн Холбооны Цахим худалдааны заавар (Directive on electronic commerce)-т тусгаснаар аж ахуйн нэгжүүд нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах талаарх ёс зүйн дүрэмтэй байх, үүнийгээ хэрэгжүүлэн ажиллах шаардлагыг тогтоосон<sup>19</sup>. Үүний зэрэгцээ Европын Холбооны Дуу дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн үйлчилгээний тухай заавар (EC Directive of the Audiovisual Media

<sup>13</sup> <https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=199081&viewCls=engLsInfoR&urlMode=engLsInfoR#0000>

<sup>14</sup> Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсрэг арга хэмжээ авах тухай хуулийн 1-3 дах зүйл

<sup>15</sup> Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсрэг арга хэмжээ авах тухай хуулийн 2.2 дах зүйл

<sup>16</sup> <https://www.togetherscotland.org.uk/news-and-events/news/2018/06/sweden-to-incorporate-the-uncrc-into-law/>

<sup>17</sup> [https://gdprhub.eu/Data\\_Protection\\_in\\_Sweden](https://gdprhub.eu/Data_Protection_in_Sweden)

<sup>18</sup> [https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC\\_united\\_nations\\_convention\\_on\\_the\\_rights\\_of\\_the\\_child.pdf?\\_ad=sd=www.unicef.org.uk.1644975131543&\\_ad\\_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D\(not%2520set\)%26co%3D\(not%2520set\)%26ke%3D\(not%2520set\).1644975131543&\\_ad\\_cw=1644975110033.1644975131543&\\_ad\\_id=3f637e28-b702-4661-be5e-dba9ea34294b.1644975110.2.1644975110.1644975110.b9ec6fed-1206-411e-a88c-0c3be100d0de.1644975131543&\\_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109](https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_ad=sd=www.unicef.org.uk.1644975131543&_ad_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D(not%2520set)%26co%3D(not%2520set)%26ke%3D(not%2520set).1644975131543&_ad_cw=1644975110033.1644975131543&_ad_id=3f637e28-b702-4661-be5e-dba9ea34294b.1644975110.2.1644975110.1644975110.b9ec6fed-1206-411e-a88c-0c3be100d0de.1644975131543&_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109)

<sup>19</sup> 16 дугаар зүйлийн 1 <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32000L0031>

Services 2010/13/EU)-д хэрэглэгчдийн хүсэлтээр интернэтээр нэвтрүүлэг түгээгч нь хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс, мөн зохисгүй зар сурталчилгаанаас хамгаалах ёстой байх тухай заасан нь хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах маш чухал зохицуулалт болсон<sup>20</sup>.

Түүнчлэн 2011 онд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүүхдийн порнографтай тэмцэх тухай заавар батлагдсан ба энэхүү хүрээнд нийгмийн сүлжээнд хүүхдийн порнограф үзүүлэх болон “садар самуунд уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох” гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхаар тусгасан<sup>21</sup>. Мөн Европын холбоо нь гишүүн орнуудын нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд байнга үнэлэлт, дүгнэлт өгч байх эргэх холбоог хэрэгжүүлдэг.

Швед Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын оролцогч тул нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг тус конвенцын хүрээнд тодруулах нь чухал. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3-р зүйлд Хүүхдийн талаарх бүх арга хэмжээ, шийдвэрийг гаргахдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан үзэх ёстой гэж заасан байх ба конвенцод тусгасан бүх эрхийг хүүхдэд холбоотой асуудалд хамааруулахгүй боловч үндсэн дөрвөн зарчим баримтлах шаардлагатай байдаг.

Швед Улс интернэтийн аюулгүй орчин хөтөлбөрийн хүрээнд салбарын өөрийн зохицуулалт мөн төрийн болон салбарын хамтарсан зохицуулалтын дагуу гурван гол арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд: уг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг ёс зүйтэй байхыг хөхиүлэн дэмжих замаар ёс зүйн дүрэмтэй болох; контентын шүүлтийн болон чансаа тогтоох технологи хөгжүүлэх; эцэст нь олон нийтийн дунд энэ талаарх ухамсарыг дээшлүүлэх арга хэмжээг авдаг.

Швед Улсын мэдээлэл хамгаалах ерөнхий журам /Хүүхдийн эрх/. Энэ журамд хүүхдийн тухай асуудлыг илүү онцлон тусгасан байх ба бага насны хүүхэд нь өөрийн хувийн мэдээлэл ямар аюулд өртөж болох тухай мэдлэг хомс байдагаас тэдний хувийн мэдээлэлд тусгайлан анхаарал тавьж, хамгаалах шаардлагатай гэж үздэг байна.

НҮБ нь 16 нас хүрсэн хүүхэд өөрийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээнд өгөх эсэх талаар шийдвэр гаргах чадамжтай гэж үздэг бол НҮБ-ын гишүүн улс орнууд энэхүү шийдвэр гаргах насны талаар өөр журам /буруулж/ тогтоож болдог. Швед Улсын хувьд 13 нас хүрсэн хүүхэд<sup>22</sup> өөрийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээнд өгөх эсэх талаар шийдвэр гаргах чадамжтай гэж үздэг. Мөн тус журамд хүүхэдтэй холбогдолтой мэдээллийг авах, мөн ашиглахад хэрхэн хариуцлагатай байх талаар чухал зарчмуудыг тусгасан байдаг.

*Хэвлэл мэдээллийн хорттой нөлөөллөөс хүүхдийг хэрхэн хамгаалдаг вэ?*

Маркетингийн тухай хуульд<sup>23</sup> 16 нас хүрээгүй хүүхдэд зар сурталчилгаа шууд түгээх болон шууд худалдан авалт хийх сэдэл төрүүлэхийг хориглодог. Мөн Радио

<sup>20</sup> <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32010L0013>

<sup>21</sup> <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32011L0093>

<sup>22</sup> Шведэд зөвшөөрлийн нас нь Мэдээлэл хамгаалах тухай хуулийн § 4-ийн дагуу 13 нас байна.

<sup>23</sup> <https://www.government.se/4abc0a/contentassets/747603b3d1a04351b1773524c7de3c84/2008486-marketing-act>

болон Телевизийн тухай<sup>24</sup> хуульд хүчирхийлэл, садар самууныг харуулсан зураглал бүхий контентыг хязгаарлах талаар заасан. Шведийн хэвлэл мэдээллийн зөвлөлөөс олон нийтэд хүргэх мэдээлэлд насны хязгаарыг зааж өгдөг нь хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллийн агуулгаас хамгаалдаг. Мөн телевизээр тодорхой төрлийн контентыг нэвтрүүлж болох өдрийн цагийг тухайн нэвтрүүлэгт тусгай зөвшөөрлөөр олгодог.

Энэ чиглэлээр ажилладаг төрийн байгууллагууд:

1. Шведийн хэвлэл мэдээллийн зөвлөл;
2. Шведийн хэрэглэгчийн агентлаг;
3. Шведийн хэвлэл, өргөн нэвтрүүлгийн байгууллага;
4. Хууль зүйн канцлерын алба;
5. Шведийн цагдаагийн байгууллага.

Хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд бэхжүүлэх зорилгоор Хүүхдийн Омбудсмен<sup>25</sup> болон Шведийн Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран олон нийтийн сүлжээ, тоглоом болон бусад цахим орчныг хариуцдаг хүмүүст зориулан гарын авлагыг гаргадаг<sup>26</sup> байна.

## **6.7 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Оросын Холбооны Улс (ОХУ) 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөргөөр нөлөөлөх мэдээллээс хүүхдийг хамгаалах тухай хуулийг<sup>27</sup> баталсан бөгөөд 2012 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байна. Тус хууль нь 7 бүлэг 23 зүйлтэй.

Тус хуулийн зорилго нь хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Хуулийн 2 дугаар зүйлд дараах нэр томъёог хууль тогтоогч тухайлан тайлбарлаж тодорхойлсон байна. Үүнд:

- “хүүхдийн мэдээлэл авах боломж” гэж хүүхдэд зориулсан нээлттэй мэдээллийг хүлээн авах, ашиглах боломж;
- “мэдээллийн бүтээгдэхүүний тэмдэг” гэж мэдээллийн бүтээгдэхүүний ангиллын дагуу мэдээллийн бүтээгдэхүүний график ба текстийн тэмдэглэгээ;
- “хүүхдийн мэдээллийн аюулгүй байдал” гэж мэдээллийн улмаас хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахууны хөгжилд хохирол учруулахаас хүүхдийг хамгаалахыг;
- “мэдээллийн бүтээгдэхүүн” гэж ОХУ-ын нутаг дэвсгэрт эргэлтэд оруулах зориулалттай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хэвлэмэл материал,

<sup>24</sup> <https://www.mprt.se/globalassets/dokument/lagar-och-regler/radioandtelevisionact2016.pdf>

<sup>25</sup> [https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms\\_accessible.pdf](https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf)

<sup>26</sup> [https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms\\_accessible.pdf](https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf)

<sup>27</sup> <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody&nd=102144583>

аливаа төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээрх дуу дүрсний бүтээгдэхүүн, цахим төхөөрөмж (компьютерийн программ) болон мэдээллийн санд зориулсан программууд, түүнчлэн хөгжөөнт арга хэмжээ, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, интернэт болон хөдөлгөөнт радио телефоны сүлжээгээр дамжуулан түгээх мэдээлэл;

- “хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн” гэж хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл санааны болон ёс суртахууны хөгжилд сэдэв, агуулга, уран сайхны загвар нь тохирсон мэдээллийн бүтээгдэхүүн;
- “мэдээллийн бүтээгдэхүүний ангилал” гэж энэ хуульд заасны дагуу тогтоосон хүүхдийн насны ангиллаар мэдээллийн бүтээгдэхүүнийг түүний сэдэв, төрөл, агуулга, уран сайхны загвараас хамааран ангилсаныг хэлнэ хэмээн тусгажээ.

Түүнчлэн, тус хуулийн 4 дүгээр зүйлд хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах чиглэлээр ОХУ-ын төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг хуульчилсан байна. Үүнд:

- хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах чиглэлээр төрийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдээллийн бүтээгдэхүүний эргэлтэд чиглэсэн холбооны арга хэмжээний жагсаалтыг боловсруулж хэрэгжүүлэх; (*Холбооны хуулийн 2021 оны 7-р сарын 1-ний өдрийн 264-фз-ийн нэмэлт, өөрчлөлт*)
- хуульд заасан мэдээллийн бүтээгдэхүүний шалгалт хийх журмыг тогтоох;
- хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд хортой мэдээллээс хамгаалах тухай ОХУ-ын хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд холбооны улсын хяналт хэрэгжүүлэх;
- хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах чиглэлээр ОХУ-ын зохих байгууллагуудын төрийн эрх баригчдын бүрэн эрхэд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүс нутгийн арга хэмжээний жагсаалтыг боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдээллийн бүтээгдэхүүний эргэлт, түүнчлэн энэхүү холбооны хуулиар тогтоосон бусад бүрэн эрх. (*Холбооны хуулийн 2019 оны 5-р сарын 1-ний өдрийн 93-фз, 2021 оны 7-р сарын 1-ний өдрийн 264-фз-р нэмэлт, өөрчлөлт оруулсан*).

Мөн хуулийн 6 дугаар зүйлд мэдээллийн бүтээгдэхүүнийг хуулийн шаардлагын дагуу дараах насны ангиллаар ангилдаг байна. Үүнд:

- зургаан нас хүрээгүй хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- зургаагаас дээш насны хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- арван хоёр наснаас дээш насны хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- арван зургаан нас хүрсэн хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;

- хүүхдэд хориглосон мэдээллийн бүтээгдэхүүн гэж тус тус ангиллалыг тогтоож өгсөн байна.

Ийнхүү ангилал тогтоосноороо хүүхэд өөрт нь тохироогүй мэдээ, мэдээллийг олж авахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Үүнээс гадна энэ хуулийн 14 дүгээр зүйлд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан мэдээлэл түгээх онцлогийг тусгасан байна:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бүртгэгдээгүй "Интернэт" мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд байгаа сайт нь мэдээллийн бүтээгдэхүүний тэмдэг (түүний дотор машинд уншигдах хэлбэрээр) ба хүүхдийн дунд тархалтыг хязгаарлах тухай анхааруулга бүхий бичвэрийг агуулж болно. Энэхүү Холбооны хуулийн шаардлагын дагуу сайтуудыг эзэмшигчид нь бие даан ангилна.
- Аудио-визуал үйлчилгээ нь энэ зүйлийн 3-р хэсэгт заасан мэдээллийн бүтээгдэхүүний ангиллын аль нэгэнд хамаарах мэдээллийн бүтээгдэхүүний тэмдэглэгээ (түүний дотор машинд уншигдахуйц хэлбэрээр) ба хүүхдийн дунд мэдээллийн бүтээгдэхүүний тархалтыг хязгаарлах тухай анхааруулга агуулсан байх ёстой гэж тусгагсан байна.

Дээр дурдсанчлан мэдээллийн хязгаарлалт, хяналтыг тогтоосноор хүүхдийг нийгмийн сүлжээнд хамгаалах механизм бүрэлдэн бий болдог.

## **6.8 ИХ БРИТАНИ УЛСЫН Нийгмийн сүлжээнд ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Их Британи нь техник, технологийн дэвшилттэй холбоотой үүсч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах арга замыг хэрэгжүүлж байна. Жишээ нь: Эрүүгийн болон олон нийтийн хэв журмыг сахиулах тухай хуульд садар самуун материал “хэвлэн нийтлэх” гэдэг ойлголт нь интернэт дэх агуулгыг адил хамрах болсон. Түүнчлэн технологи ашиглаж, компьютерийн тусламжтай эсхүл өөр ямар нэгэн техник ашиглан бий болгосон хүүхдийн дүрс зураг бүхий садар самуун хэв маягтай “дууриамал зураг” нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог. Цаашлаад, 1978 онд батлагдсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “зураг” гэх ойлголтыг цахим хэлбэрийг оруулан ойлгох тухай, мөн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. 2003 оны Садар самууны тухай хууль нь интернэтийг буруугаар ашиглан хүүхдүүдийг хохироох аюулаас хамгаалах үүднээс хүүхдийг садар самуун үйл хэрэгт ашиглах зорилгоор хүүхдийн итгэлийг олж аван, түүнтэй найз нөхдийн дотно харилцааг бий болгодог “садар самуун уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох” гэмт хэргийг хамааруулах болсон. Садар самуун уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох хэлбэрийг гэмт хэрэгт хамруулах болсоноор хүүхдийг өдөөн хатгах, хууран мэхлэх үйлдлийг таслан зогсоох хэм хэмжээг хуульчилсан.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдэгт компьютерийн тусламжтай бий болгосон хүүхдийн дүрсийг харуулсан садар самуун зураг нь Садар самуун зүйл хэвлэн нийтлэх тухай хуулийн дагуу хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл хэмээн тооцогдох болсон. Мөн уг хууль нь Английн насанд хүрэгчдэд зориулсан контент

түгээдэг цахим хуудасны операторууд насны хязгаар тогтоох тухай журамгүй байдгаас ийм төрлийн контент түгээхийг хууль бус үйлдэл болгон хуульчилсан.

Их Британи нь ЕХ-ны гишүүн орны хувьд Холбооны өмнө хүлээсэн хариуцлагын дагуу ЕХ-ны хөтөлбөр арга хэмжээг авахаас гадна өөрийн орны түүх, соёлын онцлогт тохирсон тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Их Британийн Дотоод хэргийн яам болон тус байгууллагын дэргэдэх Аюулгүй интернэт орчин бүрдүүлэх комисс (The Home Secretary's Internet Task Force) нь хүүхдэд зориулсан аюулгүй орчин бий болгох, хүүхдийг хамгаалах гэсэн хоёр үндсэн зорилго, чиг үүрэгтэй ажилладаг.

Үүний зэрэгцээ төрөөс санхүүждаг салбарын төлөөлөл болон цагдаа, шүүх байгууллагын төлөөлөл нь хамтарсан байдлаар цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор бий болсон “Цахим ертөнц дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийн төв” /The Child Exploitation and Online Protection Centre/ гэсэн хамтын зохицуулалт хэрэгжүүлдэг байгууллага эрчимтэй үйл ажиллагаа явуулдаг. Уг байгууллага нь хууль сахиулах байгууллагын нэг хэсэг учраас хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

1996 онд Их Британийн засгийн газрын дэмжлэгтэйгээр бий болсон Интернэтийн хяналтын байгууллага нь /The Internet Watch Foundation/ байнгын утас, факс, и-мэйлээр хууль бус агуулга, хүүхдийн порнограф болон хүүхдийг харуулсан садар самуун материал түгээж байгаа талаарх мэдээллийг олон нийтийн зүгээс хүлээн авдаг. Уг байгууллага нь холбогдох төрийн байгууллагууд, салбар байгууллагууд, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг.

Уг байгууллага нь салбартаа өөрийн бие даасан зохицуулалт бүхий хууль сахиулах бүрэн эрхгүй байгууллага (self-regulatory) боловч хуулийн дагуу бүрэн эрхийн хүрээнд олгогдсон холбогдох хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг тул хуулийн хэрэгжилт нь өндөр үр дүнтэй хэрэгжих боломжийг нөхцөлдүүлдэг.

Хууль бус агуулгатай, хууль бус агуулга бүхий магадлалтай мэдээлэл нийтэлдэг цахим хуудасны жагсаалтыг гаргаж, цаашид хуулийн дагуу ажиллуулах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлдэг байгууллага руу шилжүүлдэг. Энэ байгууллагын гол зорилго нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг ба “мэдэгдэх болон таслах” (notice and takedown) тактикийн дагуу эрчимтэй ажилладаг байна.

Өөрөөр хэлбэл, уг байгууллага нь тодорхой зөрчил гаргасан эсхүл гаргах өндөр магадлал бүхий сайт эрхлэгчдэд анхааруулах мэдэгдэл илгээдэг ба тус мэдэгдлийг хүлээн авсан тухайн байгууллага хэрэв үл тоомсорловол харьяалах хууль сахиулах байгууллагад мэдэгдэж, зохих арга хэмжээг авдаг. Энэхүү “мэдэгдэх болон таслах” арга хэмжээ нь цахим ертөнц дэх оюуны өмчийн зөрчлийн асуудалд маш өргөн хэрэглэгддэг арга юм. Тус байгууллага нь мөн олон улсын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.

Их Британийн томоохон 4 интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь ЕХ болон Английн төрийн уриалга, санаачлагын дагуу хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд хамгаалах үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрийг оруулах үүднээс өөрсдийн ёс зүйн дүрэмтэй бөгөөд шүүлтийн болон контентыг хаах техникийн тусламжтайгаар амиа хорлолт, хүчирхийлэл, порнограф зэрэг зүй бус контент хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд хамгаалах болсон. Интернэт орчныг хянах байгууллагаас гаргасан хаах боломжтой цахим хуудасны жагсаалтын дагуу контентыг хаах, түүнчлэн тусгай техникийн тусламжтайгаар хүүхдийн порнограф, хүчирхийлэл болон терроризмыг агуулсан контентыг хаадаг байна.

Их Британийн Засгийн газар утасгүй интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагатай шүүлтийн программ байршуулах тухай гэрээ байгуулан ажилладаг. Энэхүү хүрээнд нэлээдгүй утасгүй интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд шүүлтийн техникийн тусламжтайгаар хор хөнөөлтэй контентыг хязгаарласан байна. Гэсэн хэдий ч маш чухал гэгдэх бэлгийн боловсролын талаарх цахим сайт гэх мэт хор хөнөөлгүй, харин ч үр ашигтай сайтуудыг хаасан хэмээн олон нийтийн зүгээс ихээхэн гомдол гаргах болсон. Иймд хаах/хязгаарлах үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийх шаардлага гарсан ба шүүлтийн программ болон хаах үйл ажиллагаа нь хэр зохистой хийгдэж байгаа талаар судалгаа хийгдэж байгаа аж.

Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах газар нь олон нийтийн ашиг сонирхлыг харилцаа холбооны салбарт хамгаалахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ газар нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс интернэт дэх мэдээллийн агуулга ялангуяа садар самуун зүйлийг зохицуулах талаар холбогдох эрх бүхий байгууллагуудад зөвлөмж боловсруулж, тус хүрээнд маш идэвхтэй ажилладаг. Мөн Харилцаа холбооны зохицуулах газар нь интернэт дэх “телевизийн нэвтрүүлэг адил” (television-like content) агуулгыг зохицуулах болсон.

Их Британийн хүүхдэд зориулсан боловсролын, үйлчилгээний байгууллагуудын стандартад хяналт тавьдаг Офстед байгууллага (Office for Standards in Education, Children's Services and Skills /Ofsted/)-ын гаргасан Нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах талаарх заавар (the Ofsted eSafety guidance)-ын дагуу цахим аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн эсэхийг сургууль, дээд боловсролын байгууллагуудыг аттестатчилахдаа дүгнэдэг байна.

Боловсролын байгууллагууд шүүлтийн программтай байдаг ба сургуулийн хүүхдүүд болон оюутнуудын мэдээллийн технологийн хичээлд интернэтийн зохистой хэрэглээ, “садар самуун уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох”, “цахим дарамт буюу дээрэлхэл, гадуурхал” зэрэг ойлголтын талаар заадаг. Үүний зэрэгцээ нийгмийн ухамсар хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүүхдүүд, эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгчид, харилцаа холбооны хувийн хэвшлийн байгууллагуудад зориулсан [www.thinkuknow.co.uk](http://www.thinkuknow.co.uk) гэх тусгай цахим сайтыг төрийн зүгээс ажиллуулдаг байна.

## **6.9 БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС**

2019 оны 8-р сарын 22-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Кибер орон зайн удирдах газар Хүүхдийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээнд хамгаалах тухай журмыг гаргасан байна. Мэдээллийн нууцлалын шинэ журамд БНХАУ-ын нутаг дэвсгэрт байгаа хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулахад тавигдах өндөр түвшний шаардлагуудыг тусгасан. Энэ нь интернэт дэх хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тухай тусгайлан зохицуулсан Хятадын анхны эрх зүйн хэм хэмжээ болсон бөгөөд 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Тус журмын зорилго нь хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, хүүхдийн эрүүл хэвийн өсөлтийг дэмжих зорилгоор БНХАУ-ын Кибер аюулгүй байдлын тухай хууль, БНХАУ-ын Насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу боловсруулагдсан болно.

Хүүхдийн хувийн мэдээллийг цахимаар хамгаалах тухай журмын дагуу 14 нас хүрээгүй хүүхдийг насанд хүрээгүй гэж тодорхойлсон. БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх интернэт болон бусад холбогдох үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулахад энэхүү журам хамаарна. Ямар ч байгууллага, хувь хүн хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдалд халдсан мэдээллийг үйлдвэрлэх, гаргах эсхүл тарааж болохгүй. Хүүхдийн асран хамгаалагч нь асран хамгаалах чиг үүргээ зөв гүйцэтгэж, боловсрол, удирдамжаар дамжуулан хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах ухамсар, чадварыг дээшлүүлж, хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалж байх ёстой.

Журам нь сүлжээний операторуудаас<sup>28</sup> хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулахдаа зөв шударга, зайлшгүй шаардлагатай, бүрэн мэдээлэл авсны үндсэн дээр зөвшөөрөх, тодорхой зорилготой, баталгаатай аюулгүй байдал болон хууль ёсны дагуу ашиглах зарчмуудыг баримтлахыг шаарддаг. Мөн энэхүү журмын дагуу сүлжээний операторууд хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тусгай бодлого, хэрэглэгчийн гэрээ байгуулж, хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах үүрэг бүхий тусгай ажилтнуудыг томилсон байдаг.

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, шилжүүлэх, задруулахаас өмнө эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авах ёстой. Зөвшөөрөл авсан сүлжээний операторууд зөвшөөрөл өгөхөөс татгалзаж, дараах мэдээллийг хүүхдийн асран хамгаалагчид өгөх ёстой. Үүнд:

1. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулах зорилго, арга, хамрах хүрээ;

---

<sup>28</sup> Сүлжээний операторууд гэдэг нь БНХАУ-ын Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3-д заасны дагуу "Хятадын аливаа сүлжээ, сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн "эзэмшигч, менежер" гэсэн утгатай бөгөөд "сүлжээ" гэдэг нь компьютер болон холбогдох тоног төхөөрөмжийн систем, мэдээллийг цуглуулах, хадгалах, мэдээлэл дамжуулах, солилцох, боловсруулахыг хэлнэ" гэж томъёолсон байна. <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/translation-cybersecurity-law-peoples-republic-china/>

2. Хадгалах байршил, хадгалах хугацаа, харилцан тохиролцсон хадгалах хугацаа дууссаны дараа мэдээллийг боловсруулах;
3. Хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээ;
4. Хүүхдийн хувийн мэдээллийг ашиглах, шилжүүлэх, задруулах, хадгалахыг зөвшөөрөхөөс татгалзсаны үр дагавар;
5. Зөрчлийн талаар мэдээлэх эсхүл сүлжээний операторт гомдол гаргах арга хэрэглүүр;
6. Хүүхдийн хувийн мэдээллийг засах, устгах арга хэрэглүүр;
7. Сүлжээний операторууд мэдээлэл өгөх ёстой бусад асуудал.

Энэхүү журам нь сүлжээний операторуудад хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах зорилгодоо хүрэхэд шаардагдах хугацаанаас хэтрүүлэн хадгалахыг хориглож, мэдээллийн аюулгүй байдлыг шифрлэх болон бусад аргыг хэрэглэхийг операторуудаас шаарддаг. Үүнээс гадна сүлжээний операторууд хүүхдийн хувийн мэдээллийг ашиглахдаа захиргааны хууль тогтоомж, эсхүл хоёр талын тохиролцсон ашиглалтын зорилго, хүрээг зөрчихгүй байх ёстой. Сүлжээний операторууд гуравдагч этгээдийн үйлдвэрлэгчдийг татах, хүүхдийн хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэхээс өмнө аюулгүй байдлын үнэлгээ хийсэн байх ёстой байдаг байна.

Аливаа байгууллага, хувь хүн энэхүү журмыг зөрчсөн үйлдлийг илрүүлсэн тохиолдолд интернэтийн мэдээллийн хэлтэс эсхүл бусад холбогдох хэлтэст мэдээлж болно. Сүлжээний операторууд хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хангалтгүй хэрэгжүүлж, аюулгүй байдлын томоохон эрсдэлт оруулсан, аюулгүй байдлын зөрчил гарсан тохиолдолд интернэтийн мэдээллийн алба нь үүргийнхээ дагуу хариуцлага гаргасан ажилтантай ярилцах бөгөөд сүлжээний операторууд залруулга хийх, аюулыг арилгах арга хэмжээг шуурхай авч ажиллана<sup>29</sup>. Харин тухайн үүргээ биелүүлээгүй интернэтийн мэдээллийн алба болон бусад холбогдох хэлтэст Кибер аюулгүй байдлын тухай хууль, Интернэт мэдээллийн үйлчилгээний удирдлагын арга хэмжээ зэрэг холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг байна<sup>30</sup>.

#### **Хоёр. Хүүхдийн цахим орчин дахь хамгаалалтын зохицуулалтын олон улсын чиг хандлага**

АНУ-ын Үндэсний сэтгэцийн эрүүл мэндийн хүрээлэн (National Institute of Mental Health)-ийн судалгаагаар 13 насанд хүрээгүй хүүхдийн тархины хөгжил, танин мэдэхүй, өөрийгөө хянах болон эрсдэлийг үнэлэх чадвар бүрэн төлөвшөөгүй байдал нь хүүхдийн шийдвэр гаргалт, импульс хянах, урт хугацааны үр дагаврыг тооцоолох үүрэгтэй тархины урд хэсэг (prefrontal cortex)-ийн хөгжил өсвөр насны сүүл үе хүртэл үргэлжилдэг бол шагнал, сэтгэл хөдлөлийн хариу урвалтай холбоотой лимбик систем илүү эрт идэвхждэг байна.<sup>31</sup> Үүний улмаас бага насны хүүхэд допамины өдөөлтөд суурилсан урамшууллын механизм (dopamine-based reward system)-аар

<sup>29</sup> <https://www.chinalawtranslate.com/en/childrenspersonalinfoonline/>

<sup>30</sup> <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2019-10-28/china-regulation-on-online-protection-of-childrens-personal-information-issued/>

<sup>31</sup> National Institute of Mental Health, *The Teen Brain: 7 Things to Know*, 2024.

ажилладаг лайк дарах (ike), хуваалцах (share), хязгааргүй үзэх (endless scroll), алгоритмын санал болголтын арга (algorithmic recommendation) зэрэг донтуулах шинжтэй платформын нөлөөнд өртөмтгий, цахим дарамт, итгэл олж авах замаар бэлгийн хүчирхийлэлд татан оруулах үйлдэл(grooming), хортой агуулга, хувийн мэдээлэл алдах эрсдэлийг бодитоор үнэлэх чадвар сул байдаг<sup>32</sup>. АНУ-ын COPPA зохицуулалт нь 13 наснаас доош хүүхдийн хувийн мэдээллийг эцэг эхийн зөвшөөрөлгүй цуглуулахад тусгай шаардлага тавьдаг бөгөөд өнөөдрийн олон платформын 13 насны босго үүнтэй холбоотойгоор тогтсон байдаг.<sup>33</sup>

Харин 13–16 насны хүүхдийн хувьд нийгмийн сүлжээг бүрэн хориглох нь хүүхдийн мэдээлэл авах, боловсрол эзэмших, үзэл бодлоо илэрхийлэх, нийгмийн оролцоонд оролцох болон харилцах эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж олон улсын байгууллага, судлаачид үздэг.<sup>34</sup>

Австрали улс 16-аас доош насны хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээг бүрэн хаах зохицуулалт хэрэгжүүлсэн боловч практик хэрэгжилтийн явцад хүүхдүүд VPN, эцэг эхийн бүртгэл, нас баталгаажуулалтыг тойрох бусад арга ашиглан хаалтыг төвөггүй давж байгаа талаар судалгаа, тайлан гарсаар байна. Тухайлбал 2026 онд хийгдсэн судалгаагаар 12–15 насны хүүхдийн 60 гаруй хувь нь хориг хэрэгжсэний дараа ч нийгмийн сүлжээг VPN болон бусад аргаар үргэлжлүүлэн ашиглаж, хязгаарлалтыг тойрон гарч байгааг тэмдэглэсэн байна.<sup>35</sup> Мөн Австралийн болон олон улсын судлаачид насны хатуу хориг нь дангаараа үр дүнтэй хамгаалалт болж чадахгүй, харин хүүхдүүдийг илүү зохицуулалтгүй, эрсдэлтэй орчин руу шилжүүлэх, эсхүл онлайн орчинд учирсан эрсдэлийн талаар мэдээлэхээс айх нөхцөл үүсгэж болзошгүйг анхааруулжээ.<sup>36</sup>

Түүнчлэн хүүхэд, өсвөр насныхны хувьд нийгмийн сүлжээ нь зөвхөн эрсдэл бүхий орчин бус, харилцаа, дэмжлэг, сэтгэл зүйн тусламж авах хэрэгсэл болдог талаар судалгаанд дурдсан. Австралийн Хүүхдийн тусламжийн үйлчилгээний төв (Kids Helpline) болон сэтгэл зүйн байгууллагуудын мэдээлснээр зарим өсвөр насныхан нийгмийн сүлжээний хоригийн дараа дэмжлэг авдаг орчноосоо тусгаарлагдаж, сэтгэл гутрал, амиа хорлох бодолтой холбоотой хямралын шинжтэйгээр тусламж хүссэн тохиолдлууд бүртгэгдсэн байна.<sup>37</sup> Иймд олон улсын чиг хандлага нь нийгмийн сүлжээг бүрэн хориглох арга хэмжээнээс илүүтэйгээр платформын аюулгүй загварчлалын шаардлага, алгоритмын зохицуулалт, насанд тохирсон хамгаалалтын тохиргоо, эцэг эхийн оролцоо, сэтгэл зүйн дэмжлэг болон

---

<sup>32</sup> UNICEF, *Policy Brief on Online Platform Regulation and Child Safety*, 2025.

<sup>33</sup> Federal Trade Commission, *Children's Online Privacy Protection Rule (COPPA)*, 1998.

<sup>34</sup> UNICEF, *Policy Guidance on AI for Children and Child Rights in the Digital Environment, 2021–2024.*, United Nations Committee on the Rights of the Child, *General Comment No.25 (2021) on children's rights in relation to the digital environment*, 2021.

<sup>35</sup> Molly Rose Foundation, *Survey on Australia's Under-16 Social Media Restrictions, 2026*; Fortune, *Australian teens say social media ban is futile and look to VPNs*, 2026.

<sup>36</sup> Scott J. Fatt & Jasmine Fardouly, *Debate: Social media in children and young people – time for a ban?*, Child and Adolescent Mental Health, 2025.

<sup>37</sup> Molly Rose Foundation, *Written Evidence Submitted to UK Parliament on Social Media Ban Risks*, 2026.

цахим боловсролыг хамтад нь хэрэгжүүлэх “эрсдэлд суурилсан, тэнцвэртэй зохицуулалт”-д чиглэж байна.<sup>38</sup>

Харвардын их сургуулийн Хүүхдийн хөгжлийн төв (Harvard Center on the Developing Child)-ийн судалгаагаар 13–16 насанд хүүхдийн нийгмийн оролцоо, харилцаа, мэдээлэл авах, суралцах, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ эрчимтэй нэмэгддэг боловч тархины өөрийгөө хянах, сэтгэл хөдлөлөө зохицуулах, нийгмийн дарамтыг даван туулах чадвар бүрэн төлөвшөөгүй хэвээр байдаг байна.<sup>39</sup> Судалгаагаар өсвөр насныхан “peer validation” буюу бусдын үнэлэмжид илүү мэдрэмтгий байдаг тул алгоритмаар эрчимтэй түгээх (algorithmic amplification), бусадтай өөрийгөө харьцуулах (social comparison), донтуулах шинжтэй хэрэглээний загварчлал (addictive engagement design)-ын нөлөөнд илүү өртөмтгий байдаг гэж үздэг.<sup>40</sup> Иймээс Европын холбооны Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act, 2022) нь насанд хүрээгүй хэрэглэгчид ашиглах боломжтой платформд “өндөр түвшний нууцлал, аюулгүй байдал, хамгаалалт” хангах үүргийг хуульчилж, хүүхдэд чиглэсэн хэрэглэгчийн зан төлөвт суурилсан сурталчилгаа, алгоритмыг хориглосон байна.

Иймд 13–16 насанд нийгмийн сүлжээг ашиглуулах, аюулгүй байдлын анхны тохиргоо, танихгүй хүнтэй холбогдох боломжийг хязгаарлах болон байршил хуваалцах тохиргоог идэвхгүй болгох, хортой агуулгыг харуулахгүй байх, эцэг эхийн хяналт, алгоритмын эрсдэлийг бууруулах гэх зэрэг хамгаалалтын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээрх технологийн хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд нас баталгаажуулалтын системийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Их Британи, Европын Холбоо, АНУ, Сингапур зэрэг улс орнуудын цахим орчин дахь хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад платформын үйл ажиллагааны хүрээ, үйлчилгээний төрөл, хүүхдэд учруулж болзошгүй эрсдэлийн түвшинд үндэслэн ялгамжтай зохицуулалт хийх хандлага түгээмэл байна. Тухайлбал, Их Британийн Цахим аюулгүй байдлын хууль (Online Safety Act, 2023), Европын холбооны Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act, 2022) болон Австралийн Цахим аюулгүй байдлын хууль (Online Safety Act, 2021)-д платформд эрсдэлийн үнэлгээ хийх, насны баталгаажуулалт хэрэглэх, хортой агуулга болон алгоритмын нөлөөллийг бууруулах, хүүхдэд ээлтэй аюулгүй тохиргоог анхнаас нь бий болгох үүрэг хүлээлгэж байна. Иймд хуулийн төсөлд нийгмийн сүлжээний платформыг эрсдэлийн түвшнээр ангилж, эрсдэлийн үнэлгээнд суурилсан зохицуулалт хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

---

<sup>38</sup> UNICEF, *Child Rights in the Digital Environment*; United Nations Committee on the Rights of the Child, General Comment No.25, 2021.

<sup>39</sup> Harvard Center on the Developing Child, *Brain Development During Adolescence*, 2024.

<sup>40</sup> National Library of Medicine, *Social Media and Adolescent Mental Health*, 2025.

Харин Сингапур улсын хувьд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (Broadcasting Act, 1994)-иар олгогдсон эрхийн дагуу Мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хөгжлийн газар (IMDA)-аас Цахим аюулгүй байдлын үйл ажиллагааны журам (Code of Practice for Online Safety, 2023) баталж, тус журмаар технологийн урьдчилсан сэргийлэх хамгаалалтыг нарийвчлан зохицуулсан нь нийгмийн сүлжээг бүрэн хориглох бус, платформын хариуцлага, эрсдэлд суурилсан зохицуулалт, хэрэглэгчийн хамгаалалтын хэрэгсэл болон цахим боловсролыг хослуулсан практик хэрэгжилтэд чиглэж байна.

Энэ мэтчилэн АНУ, Австрали, Япон, Итали, БНСУ, ОХУ, ИБУИНВУ, БНХАУ, Сингапур, Казакстан, Малайз, Норвеги, Испани, Герман, Эстони зэрэг улс орнууд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх бодлого тодорхойлж, нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудыг баталжээ.

Эдгээрээс үзвэл улс орнуудын цахим хамгааллын зохицуулалт нь бүрэн хориглох арга хэмжээнд бус, хүүхдийн насны онцлогт тохирсон, зохистой хэрэглээний орчин бүрдүүлэх, хувийн мэдээлэл хамгаалах, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны ил тод байдал, эцэг эхийн оролцоо болон платформын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Европын Холбоо, НҮБ-ын Хүүхдийн сангийн баримт бичгүүдэд, хүүхэд хамгаалал, мэдээлэл авах эрх, хувийн нууц болон цахим оролцооны эрхийн тэнцвэрийг хадгалах зарчмыг чухалчилж байгаа нь насны баталгаажуулалтыг дангаараа хангалтгүй гэж үзэж байна. Иймд хуулийн үзэл баримтлалд хүүхдийн эрхийг хангасан, эрсдэлд суурилсан, технологийн хөгжлийг дэмжсэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангах тэнцвэртэй зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

## **ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Энэхүү судалгааг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу **Нийгмийн сүлжээнд хүүхийн аюулгүй байдлыг хангах** тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү тандан судалгааны хүрээнд хүүхэд, эцэг эх, багш, нийгмийн ажилтан болон хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдээс нийт 9,852 оролцогчийг хамруулсан судалгааны үр дүн, Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улсын туршлагад үндэслэн хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээ, цахим платформын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, хүүхдийн өдөр тутмын амьдрал, боловсрол, мэдээлэл авах, харилцаа холбоо тогтоох орчинд гүнзгий нэвтэрч байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхдүүд YouTube, Facebook, TikTok, Instagram зэрэг алгоритмд суурилсан платформыг өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд цахим хэрэглээ өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон байна.

Гэвч үүний зэрэгцээ хүүхдүүд цахим дээрэлхэлт, цахим дарамт, танихгүй хүнээс ирсэн чат, цахим залилан, бэлгийн шинжтэй дарамт, хортой контент, донтуулах богино видео, алгоритмын сөрөг нөлөөлөл зэрэг олон төрлийн эрсдэлд өртөж байгаа нь тогтоогдсон. Ялангуяа багш, нийгмийн ажилтнуудын ажиглалтаар хүүхдийн зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн шинж тэмдэг, цахим хэрэглээтэй холбоотой донтолт түгээмэл ажиглагдаж байгаа нь цахим орчны эрсдэл хүүхдийн эрүүл хөгжил, төлөвшилд бодит сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүд интернэтийг өдөрт дунджаар 2–5 цаг ашиглаж байгаа бөгөөд цахим хэрэглээний агуулга, хугацаанд эцэг эхийн хяналт хангалтгүй, хүүхдүүд цахим орчинд тулгарсан асуудлаа гэр бүлдээ мэдээлэхгүй байх хандлага түгээмэл байна. Түүнчлэн эцэг эх, багш нарын дийлэнх нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын талаарх мэдлэг, хамгаалалтын арга хэрэгслийн хэрэглээ хангалтгүй байгааг илэрхийлсэн бөгөөд хүүхдийг цахим орчинд хамгаалах тусгайлсан эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэсэн байр суурийг нийтлэг илэрхийлсэн байна.

Олон улсын хэмжээнд хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарал хандуулж, хууль тогтоомжоо шинэчлэх хандлага эрчимтэй хөгжиж байна. Тухайлбал, Европын Холбооны Digital Services Act, Их Британийн Online Safety Act, Австралийн Online Safety Act зэрэг хууль тогтоомжид платформын хариуцлага, хүүхдийн default хамгаалалт, алгоритмын эрсдэл, нас баталгаажуулалтын тогтолцоог тусгайлан зохицуулсан байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооны 2021 оны “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25”-д хүүхдийн эрх цахим орчинд бүрэн хэрэгжих ёстой бөгөөд улс орнууд хүүхдийн эрхэд суурилсан, эрсдэлд суурилсан, насны онцлогт нийцсэн зохицуулалт бий болгох үүрэгтэйг тодорхойлсон байна.

Монгол Улсын хувьд Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль зэрэг хууль тогтоомжид хүүхдийн эрх, мэдээллийн хамгаалалттай холбоотой тодорхой зохицуулалт тусгагдсан боловч хүүхдийн цахим орчин дахь хамгаалалтыг цогцоор нь зохицуулсан тусгайлсан эрх зүйн орчин хангалтгүй байна.

Тухайлбал:

- Платформын үүрэг, хариуцлага;
- Нас баталгаажуулалтын тогтолцоо;
- Хүүхдийн default хамгаалалтын тохиргоо;
- Алгоритмын ил тод байдал, эрсдэлийн зохицуулалт;
- Хортой контентын хязгаарлалт;
- Хүүхдийн өгөгдөл, хувийн мэдээллийн хамгаалалт;

- Эцэг эхийн хяналтын механизм;
- Гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлэх тогтолцоо зэрэг асуудал одоогийн эрх зүйн зохицуулалтад хангалттай тусгагдаагүй байна.

Иймд хүүхдийн цахим орчин дахь эрх, аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн соён гэгээрүүлэх арга хэмжээ, салангид журам, зөвлөмжөөр бус хүний эрхэд суурилсан, олон улсын чиг хандлагад нийцсэн, платформын үүрэг хариуцлагыг тодорхойлсон тусгайлсан хуулийн хүрээнд зохицуулах шаардлагатай гэж үзэв.

### **НАЙМ. ЗӨВЛӨМЖ**

Нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалтай холбоотой харилцааг цогцоор нь зохицуулах бие даасан эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага нэгэнт бий болсон байна.

Иймд дараах бодлогын болон эрх зүйн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. “Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” бие даасан хуулийн төслийг боловсруулж, хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалтыг цогцоор нь зохицуулах;
2. Нийгмийн сүлжээний платформуудад хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүрэг, хариуцлага, тайлагналын тогтолцоог хуульчлах;
3. Нас баталгаажуулалтын хүний эрхэд суурилсан, хувийн мэдээлэл хамгаалсан техникийн тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх;
4. “Safety by default”, “Privacy by default” зарчмыг хуульд тусгаж, хүүхдийн аккаунтыг анхдагчаар хамгаалалттай тохиргоотой үүсгэх зохицуулалт бий болгох;
5. Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохироогүй хүчирхийлэл, бэлгийн агуулга, еөртөө гэмтэл учруулах, амиа хорлолтыг өдөөх, донтуулах контентод хязгаарлалт тогтоох;
6. Хортой контентыг мэдээлснээс хойш тодорхой хугацаанд устгах платформын үүрэг, хариуцлагын зохицуулалтыг хуульчлах;
7. Хүүхдэд чиглэсэн донтуулах алгоритм, autoplay, endless scroll зэрэг механизмд эрсдэлийн үнэлгээ хийх, хязгаарлах зохицуулалт бий болгох;
8. Эцэг эх, асран хамгаалагчид зориулсан дижитал боловсрол, цахим аюулгүй байдлын сургалт, зөвлөмжийг тогтмол хэрэгжүүлэх;
9. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт цахим боловсрол, мэдээллийн аюулгүй байдал, цахим орчны эрсдэлийн талаарх агуулгыг үе шаттай тусгах;
10. Хүүхдийн цахим орчин дахь эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлэх нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;

11. Төрийн байгууллага, боловсролын байгууллага, платформ, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох;
12. Хүүхдийн цахим орчны асуудлаар тогтмол үндэсний хэмжээний судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийж, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах;
13. Хүүхдийн цахим орчны асуудлыг шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн онцлогтой уялдуулан тогтмол шинэчилж байх эрх зүйн уян хатан тогтолцоо бүрдүүлэх;
14. Хүүхдийг цахим дарамт, заналхийлэл, цахим мөлжлөг, гэмт хэрэг, зөрчил, амиа хорлолтыг өдөөсөн контентын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нэгдсэн тогтолцоог төрийн бодлогын түвшинд хэрэгжүүлэх.

### **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

#### **Нэг. Хууль, эрх зүйн акт**

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.
3. Иргэний хууль, 2002.
4. Эрүүгийн хууль, 2015
5. Зөрчлийн тухай хууль, 2017
6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019
7. Зар сурталчилгааны тухай хууль, 2002.
8. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998.
9. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016.
10. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016.
11. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012
12. Оюуны өмчийн тухай хууль, 2020
13. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021
14. Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2021
15. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998
16. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2002
17. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019.
18. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”. Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоол, 2021.
19. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал, Засгийн газрын 59 дүгээр тогтоол. 2016.
20. Хүүхдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 1989

#### **Хоёр. Монгол болон гадаад улсын эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25

2. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 2021 оны 5 дугаар 31-ний өдөр гаргасан “Цахим орчин дахь хүүхэд” шинэчлэн найруулсан зөвлөмж.
3. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан /албан хэрэгцээнд/, 2018 он.
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалт, 2017 он.
5. Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааны тайлан, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, 2021 он.
6. Европын Холбооны хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүүхдийн порнографтай тэмцэх тухай заавар, 2011
7. Европын Холбооны Дуу дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн үйлчилгээний тухай заавар, 2010

### Гурав. Гадаад эх сурвалж

1. 2021 оны Австрали улсын Цахим аюулгүй байдлын тухай хууль
2. 2021 оны Австрали улсын Цахим аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйл
3. <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=420AC1000000079>
4. <http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/67127/98324/F2042155478/KO R67127%20English.pdf>
5. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=38422&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38422&lang=ENG)
6. <http://opennetkorea.org/en/wp/wp-content/uploads/2014/03/Korean-real-name-law-decision-english.pdf>
7. <https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=199081&viewCls=engLsInfoR&urlMode=engLsInfoR#0000>
8. Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсрэг арга хэмжээ авах тухай хуулийн 1-3 дах зүйл
9. Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсрэг арга хэмжээ авах тухай хуулийн 2.2 дах зүйл
10. <sup>1</sup> <https://www.togetherscotland.org.uk/news-and-events/news/2018/06/sweden-to-incorporate-the-uncrc-into-law/>
11. <https://gdprhub.eu/Data Protection in Sweden>
12. [https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC\\_united\\_nations\\_convention\\_on\\_the\\_rights\\_of\\_the\\_child.pdf?\\_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109](https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109)
13. 16 дугаар зүйлийн 1 <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32000L0031>

14. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32010L0013>
15. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32011L0093>
16. Шведэд зөвшөөрлийн нас нь Мэдээлэл хамгаалах тухай хуулийн § 4-ийн дагуу 13 нас байна.
17. <https://www.government.se/4abc0a/contentassets/747603b3d1a04351b1773524c7de3c84/2008486-marketing-act>
18. <https://www.mprt.se/globalassets/dokument/lagar-och-regler/radioandtelevisionact2016.pdf>
19. [https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms\\_accessible.pdf](https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf)
20. [https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms\\_accessible.pdf](https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf)
21. <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody&nd=102144583>
22. <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/translation-cybersecurity-law-peoples-republic-china/>
23. <https://www.chinalawtranslate.com/en/childrenspersonalinfoonline/>
24. <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2019-10-28/china-regulation-on-online-protection-of-childrens-personal-information-issued/>
25. National Institute of Mental Health, *The Teen Brain: 7 Things to Know*, 2024.
26. UNICEF, *Policy Brief on Online Platform Regulation and Child Safety*, 2025.
27. Federal Trade Commission, *Children’s Online Privacy Protection Rule (COPPA)*, 1998.
28. UNICEF, *Policy Guidance on AI for Children and Child Rights in the Digital Environment*, 2021–2024., United Nations Committee on the Rights of the Child, *General Comment No.25 (2021) on children’s rights in relation to the digital environment*, 2021.
29. Molly Rose Foundation, *Survey on Australia’s Under-16 Social Media Restrictions*, 2026; Fortune, *Australian teens say social media ban is futile and look to VPNs*, 2026.
30. Scott J. Fatt & Jasmine Fardouly, *Debate: Social media in children and young people – time for a ban?*, *Child and Adolescent Mental Health*, 2025.
31. Molly Rose Foundation, *Written Evidence Submitted to UK Parliament on Social Media Ban Risks*, 2026.
32. UNICEF, *Child Rights in the Digital Environment*; United Nations Committee on the Rights of the Child, *General Comment No.25*, 2021.
33. Harvard Center on the Developing Child, *Brain Development During Adolescence*, 2024.
34. National Library of Medicine, *Social Media and Adolescent Mental Health*, 2025.



**Хавсралт 1. Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн түүвэр**

№	Хуулийн нэр	Зүйл, заалт
1.	<b>Хүүхэд хамгааллын тухай хууль</b>	<p><b>8 дугаар зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал</b></p> <p>8.1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална.</p> <p>8.2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.</p> <p>8.3.Хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ.</p> <p>8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>8.5.Арван зургаан насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 8.4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна.</p> <p>8.6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.</p>
2.	<b>Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль</b>	<p><b>29 дүгээр зүйл.Хориглох зүйл</b></p> <p>29.1.Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно.</p>

		<p>29.2.Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно.</p> <p>29.3.Мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.</p>
--	--	--



3.	<b>Кибер аюулгүй байдлын тухай хууль</b>	<p><b>15 дугаар зүйл.Цагдаагийн байгууллага</b></p> <p>15.1.Цагдаагийн байгууллага кибер аюулгүй байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.1.1.кибер халдлага, зөрчилтэй холбоотой гэмт хэргийн мэдээллийг хүлээн авч, хуульд заасан ажиллагааг явуулах;</p> <p>15.1.2.энэ хуулийн 15.1.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс гаргуулан авах;</p> <p>15.1.3.кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөмж, шаардлага, сэрэмжлүүлэг хүргүүлэх;</p> <p>15.1.4.кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, тоног төхөөрөмж, программ хангамжийг шалгах, судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах зорилгоор тоон шинжилгээний лаборатори ажиллуулах.</p>
4.	<b>Хэвлэл мэдээний эрх чөлөөний тухай хууль</b>	<p><b>3 дугаар зүйл.Мэдээлэлд хяналт тавихыг хориглох</b></p> <p>3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.</p> <p>3.2.Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.</p>
5.	<b>Зар сурталчилгааны тухай хууль</b>	<p><b>6 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага</b></p> <p>6.5.Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно:</p> <p>6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;</p> <p>6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;</p> <p>6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах.</p> <p><b>7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа</b></p> <p>7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.</p> <p>7.2.Дараахь зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно:</p> <p>7.2.2.бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа;</p> <p>7.3.Дараахь зүйлийн талаар хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгааг бодит байдалд үл нийцсэнд тооцно:</p> <p>7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно:</p> <p>7.4.1.бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжилсон;</p>

		<p>7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан;</p> <p>7.4.6.хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчсөн.</p> <p>7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно.</p> <p>7.6.Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно.</p> <p>7.7.Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно.</p> <p><b>12 дугаар зүйл.Интернэтээр түгээх зар сурталчилгаа</b></p> <p>12.1.Зар сурталчилгаа түгээгч нь бусдын эзэмшилд байгаа интернэтийн хуудсанд өөрийн зар сурталчилгаагаа зөвшөөрөлгүй байрлуулахыг хориглоно.</p> <p><b>16 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийн эрхийг хамгаалах</b></p> <p>16.1.Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд дараахь зүйлийг хориглоно:</p> <p>16.1.1.эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн нэр хүндийг бууруулах;</p> <p>16.1.2.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахыг эцэг, эх болон бусад этгээдээс шаардахыг хүүхдэд шууд зөвлөх, ухуулах, бусад хэлбэрээр нөлөөлөх;</p> <p>16.1.3.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авсан, эсхүл аваагүйгээс бусад хүүхдээс давуутай буюу дор байдалд орно гэсэн ойлголтыг хүүхдэд бий болгох;</p> <p>16.1.4.хүүхдийг аюултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгаанд ашиглах;</p> <p>16.1.5.тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэхэд шаардагдах мэдлэг, дадлага, туршлагын төвшинг бууруулж буюу өсгөж сурталчлах;</p> <p>16.1.6 бүтээгдэхүүний үнийн талаар буруу ойлголт хүүхдэд бий болгох.</p> <p>16.1.7.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 3.1.8-д зааснаас бусад нялх, балчир хүүхдэд зориулж үйлдвэрлэсэн хүнс болон хооллох хэрэгслийг сурталчлах;</p> <p>16.1.8.чихэр, давс, транс болон ханасан тос ихээр агуулсан хоол, хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаанд хүүхэд оролцуулах.</p>
6.	<b>Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль</b>	<p><b>5 дугаар зүйл.Садар самууныг сурталчлахыг хориглох</b></p> <p>5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.</p> <p>5.2.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.</p>

		<p><b>7 дугаар зүйл.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам</b>  7.2.3. 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах.</p> <p><b>8 дугаар зүйл.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйл</b>  8.1.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхэд дараахь зүйлийг хориглоно:  8.1.3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэх.</p>
7.	<b>Эрүүгийн хууль</b>	<p><b>16.8 дугаар зүйл.Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах</b>  1.Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p><b>16.9 дүгээр зүйл.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах</b>  1.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг:  2.1.кибер орчныг ашиглаж;  2.2.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p><b>26.1 дүгээр зүйл.Цахим мэдээлэлд хууль бусаар халдах</b>  1.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерийн өгөгдөл, системд нэвтэрсэн, танилцсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн өгөгдлийг</p>

		нуусан, хандалтад хязгаарлалт тогтоосон, компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагааг хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
8.	<b>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</b>	<b>32 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг</b> 32.4. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ.
9.	<b>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль</b>	<b>13 дугаар зүйл. Хориглох зүйл</b> 13.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хориглоно: 13.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерийн сүлжээг ашиглан сурталчлах;
10.	<b>Хүүхдийн эрхийн тухай хууль</b>	<b>6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх</b> 6.1. Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ: 6.1.5. хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах; <b>10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг</b> 10.1. Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ: 10.1.1. хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх; 10.1.2. хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх; 10.1.3. хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

		<p>10.1.4.хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;</p> <p>10.1.5.хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;</p> <p>10.1.6.хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;</p> <p>10.1.7.хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;</p> <p>10.1.8.хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах;</p> <p>10.1.9.хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;</p> <p>10.1.10.хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах;</p> <p>10.1.11.хууль тогтоомжид заасан бусад.</p>
<b>Бусад</b>		
16.	Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	<a href="https://legalinfo.mn/mn/detail/7045">https://legalinfo.mn/mn/detail/7045</a>
17.	“Цахим монгол” үндэсний хөтөлбөр	<a href="https://legalinfo.mn/mn/detail/9465">https://legalinfo.mn/mn/detail/9465</a>
18.	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	<a href="https://legalinfo.mn/mn/detail/4698">https://legalinfo.mn/mn/detail/4698</a>
19.	Үндэсний хөтөлбөр батлах тухай /Мэдээллийн аюулгүй байдал/	<a href="https://legalinfo.mn/mn/detail/4716">https://legalinfo.mn/mn/detail/4716</a>
20.	Гэмт хэргийн тухай хуулийн төсөл	<a href="https://mojha.gov.mn/newmojha/?p=557">https://mojha.gov.mn/newmojha/?p=557</a>
21.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	<a href="https://legalinfo.mn/mn/detail/6163">https://legalinfo.mn/mn/detail/6163</a>

**Хавсралт 2: Хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судалсан суурь асуултуудын хариулт**

**1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхгүй бөгөөд хүүхдийн ашиг сонирхолд суурилсан зохицуулалт байна.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зохицуулалт нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц болон үндэсний хууль тогтоомжтой нийцэж байна.
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Судалгаанд хүүхэд, эцэг эх, багш, нийгмийн ажилтан зэрэг оролцогчдыг хамруулсан.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй талуудыг тодорхойлсон
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			

	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Хүүхдийн цахим орчин дахь хамгаалалт, аюулгүй байдлын баталгаа сайжирна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		НҮБ-ын “Ерөнхий тайлбар №25”, Хүүхдийн эрхийн тухай конвенцтой нийцэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		Хүүхдийн эрх зөрчсөн этгээд болон платформын хариуцлагын зохицуулалт тусгагдана.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм		Хүүхдийг хортой контент, цахим дарамтаас хамгаалах зорилгоор тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм		Хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор насанд тохироогүй агуулгыг хязгаарлах шаардлагатай.
3.Эрх агуулагч <sup>[8]</sup>	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, платформ хэрэглэгчдийг тодорхойлсон.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм		Насны онцлог, эмзэг байдлыг харгалзан үзсэн.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		Хүүхдийн цахим хамгаалалтыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмзэг бүлгийн хэрэгцээг харгалзана.
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Платформ, төрийн байгууллага, боловсролын байгууллагын үүргийг тодорхойлно.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Хүүхдийн эрхийг жендэрийн тэгш байдлын зарчимд нийцүүлэн хамгаална.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Хүйсээс үл хамааран хүүхдийн эрхийг тэгш хамгаалах зохицуулалт байна.

## 2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Зах зээлд ялгавартай нөхцөл үүсгэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Хөрөнгө оруулалтын орчинд шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Тийм	Хүүхдийг олон улсын платформын эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлнэ.

2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм		Нас баталгаажуулалт, хамгаалалтын систем нэвтрүүлэх зардал гарч болзошгүй..
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм		Насанд тохироогүй контент, үйлчилгээний борлуулалтад тодорхой хязгаарлалт тогтоож болно.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм		Тайлагнал, мэдээлэл хүргүүлэх үүрэгтэй холбоотой зардал гарна.

5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		Цахим аюулгүй байдлын технологийн хөгжлийг дэмжинэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		Нас баталгаажуулалт, шүүлтүүрийн технологи хөгжих боломжтой.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		Аюулгүй дижитал үйлчилгээ хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаална.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Хяналт, технологи, аюулгүй байдлын чиглэлээр ажлын байр нэмэгдэж болно.

	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хэрэгжилт, хяналтын тогтолцоонд тодорхой төсөв шаардлагатай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Хяналт, зохицуулалтын чиг үүрэг нэмэгдэнэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Аюулгүй дижитал орчин бүрдүүлэхэд эерэг.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Олон улсын хүүхэд хамгааллын стандарттай нийцнэ

### 3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал,	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.

хөдөлмөрийн зах зээл	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны оролцоо нэмэгдэнэ.
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		Цахим аюулгүй байдлын шинэ стандарт нэвтэрнэ.
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Цахим орчны эрсдэлийг бууруулснаар сэтгэл зүйн эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлнэ.
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		Хүүхэд хамгааллын чиг үүрэг нэмэгдэнэ.
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		Цахим орчин дахь хүүхэд хамгааллын стандарт бий болно.
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		Нас баталгаажуулалт, шүүлтүүрийн технологи нэвтэрнэ.
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм		Байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Хүүхэд хамгааллын чиг үүрэг өргөжинө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		Хяналт, хэрэгжилтийн чиг үүрэг нэмэгдэнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм		Хүүхдийн эрхийн хамгаалалт сайжирна.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа өргөжинө.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Цахим донтолт, дарамтын эрсдэлийг бууруулна. Ингэснээр эерэг нөлөө үзүүлнэ.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм		Цахим хэрэглээний зохистой дадал төлөвшинө.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Хүүхэд хамгааллын үйлчилгээ сайжирна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөлөхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөлөхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг буурахад нөлөөлнө.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм		Хяналтын тогтолцоо сайжирна.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Цахим зөрчлийг илрүүлэх боломж нэмэгдэнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Харин хамгаалалт сайжирна..
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөхгүй.

#### 4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
------------------	------------------	---------	---------

1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Байгаль орчинд шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Тээврийн хэрэглээнд нөлөөлөхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Технологийн дэд бүтэцтэй холбоотой бага хэмжээний хэрэглээ өсөж болзошгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Нөлөөгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Нөлөөгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Байгаль орчны нөөцөд шууд нөлөөлөхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Байгаль орчны нөөцөд шууд нөлөөлөхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Байгаль орчны нөөцөд шууд нөлөөлөхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Байгаль орчны нөөцөд шууд нөлөөлөхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Усны нөөцөд нөлөөлөхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Усны нөөцөд нөлөөлөхгүй.

	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Усны нөөцөд нөлөөлөхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Хөрсний бохирдолтой холбоогүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Хөрсний бохирдолтой холбоогүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Газрын ашиглалтад нөлөөлөхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Газрын ашиглалтад нөлөөлөхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Газрын ашиглалтад нөлөөлөхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй.

**Хавсралт 3: “Нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалах” тухай хуулийн төслийн тандан судалгааны хүрээнд багш, нийгмийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, 11-17 насны хүүхдээс авсан судалгааны тайлан /БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ, НИЙГМИЙН АЖИЛТАН, ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ НАРТ ЗОРИУЛСАН ХУВИЛБАР/**

Энэхүү судалгааны зорилго нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, сургуулийн орчин дахь эрсдэл, багшийн оролцоо, нийгмийн сүлжээний зохицуулалт, хүүхдийн эрхийн хамгааллын талаарх ойлголт, хандлага, туршлагыг тодорхойлоход оршино.

Судалгаанд өгсөн мэдээллийг зөвхөн судалгаа, бодлого боловсруулах зорилгоор ашиглах бөгөөд таны хувийн мэдээллийг нууцлан хадгална.

**I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

- 1.Та аль аймгаас энэхүү судалгаанд оролцож байна вэ?
2. Та ихэвчлэн хэдэн насны хүүхдүүдтэй ажилладаг вэ? (олон сонголттой байж болно)

- Бага анги
- Дунд анги
- Ахлах анги

3. Таны албан тушаал

- Багш
- Нийгмийн ажилтан
- Хүүхдийн сэтгэл зүйч
- Бусад: \_\_\_\_\_

4. Таны ЕБС-д ажилласан жил:

- 1–3 жил
- 4–10 жил
- 10-аас дээш

## II. СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ЦАХИМ ЭРСДЭЛ

5.

Сурагчид цахим орчинд дараах эрсдэлтэй тулгарч буйг та ажиглаж байсан уу? (олон сонголттой)

- Цахим дээрэлхэлт
- Хортой агуулга бүхий контент
- Бэлгийн шинжтэй дарамт, хүчирхийлэл
- Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт
- Цахим залилан
- Мэдэхгүй
- Тулгарч байгаагүй
- Бусад:.....

6. Та сүүлийн 1 жилийн хугацаанд сурагч цахим орчны эрсдэлд өртсөн хэдэн тохиолдолтой ажилласан бэ?

- 1–2
- 3–5
- 6–10
- 10-аас дээш
- Байхгүй

7. Таны бодлоор хүүхдийн хамгийн их ашигладаг цахим платформ юу вэ?  
/олон сонголттой/

- Facebook
- Instagram
- TikTok
- YouTube
- Snapchat
- Threads
- NGL
- Discord

- X /Twitter/
- Онлайн тоглоомын платформ
- Мэдэхгүй
- Бусад: \_\_\_\_\_

### III . БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ, НИЙГМИЙН АЖИЛТАН, ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ НАРЫН ОРОЛЦОО

8.Сурагч цахим орчинд асуудалд өртсөн тохиолдолд ямар арга хэмжээ ав ах талаар та мэдлэгтэй юу?

- Тийм
- Үгүй
- Зарим талаар

9. Цахим орчинд эрсдэлд өртсөн сурагчийн хувийн мэдээллийг та нууцалд аг уу?

- Тийм
- Үгүй
- Зарим талаар

10. Цахим орчинд сурагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авахад танд хамгийн их тулгардаг хүндрэл юу вэ?

- Мэдлэг, сургалт дутмаг
- Сурагчид нууж хаадаг
- Эцэг эхийн оролцоо сул
- Сургуулийн бодлого тодорхой биш
- Цаг, ачаалал их
- Бусад: \_\_\_\_\_

11. Цахим орчинд асуудалд өртсөн сурагчийн талаарх багшийн ажиглалт:

- Зан төлөвийн өөрчлөлт
- Нийгмийн харилцааны өөрчлөлт
- Сургалтын үзүүлэлт
- Сэтгэл зүйн шинж тэмдэг
- Цахим хэрэглээтэй холбоотой донтолт
- Бусад.....

12. Танай сургууль дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлдэг үү?

Үзүүлэлт	Тийм	Үгүй
Цахим аюулгүй байдлын сургалт	○	○
Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	○	○
Хүүхдэд зориулсан сургалт	○	○
Дотоод журам	○	○

### ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

13. Дараах насны ангилалд цахим сүлжээний хэрэглээг ямар түвшинд зөвшөөрөх нь тохиромжтой вэ?

Насны ангилал	Огт ашиглуулахгүй	Хязгаарлагдмал ашиглуулах	Эцэг эхийн хяналттай ашиглуулах	Чөлөөтэй ашиглуулах
08–10 нас	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
11–12 нас	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
13–15 нас	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
16-с дээш	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>

14. Хүүхдийг нас, хөгжлийн онцлогт нь тохироогүй, хортой контентоос хамгаалах зорилгоор цахим орчин дахь тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэж та үзэж байна уу?

- Бүрэн санал нийлнэ
- Санал нийлнэ
- Зарим талаараа санал нийлнэ
- Санал нийлэхгүй
- Огт санал нийлэхгүй

15. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоо-нуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу?

Тохиргоо	Тийм	Үгүй
Хувийн хаягийн нууцлал (profile private байх)	<input type="radio"/>	<input type="radio"/>
Танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Байршил (location) хуваалцахыг унтраах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Ёс бус үг хэллэг ашигласан коммент устгах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Шөнийн хэрэглээг хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Дэлгэц ашиглалтын хугацааны хязгаар (screen time limit)	<input type="radio"/>	<input type="radio"/>
Донтох зан төлөв өдөөсөн богино видеог хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Насанд хүрэгчдийн агуулга, сэтгэл зүйн дарамт, сөрөг зан төлөвтэй холбоотой контентыг хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Хүүхдийн насанд тохиромжгүй live/stream	<input type="radio"/>	<input type="radio"/>
Бүртгэлд 2 шатлалт нэвтрэлт (2FA) идэвхжүүлэх	<input type="radio"/>	<input type="radio"/>

16. Нийгмийн сүлжээний алгоритм нь хүүхдийг донтуулах, хэт удаан хугац аагаар ашиглахад нөлөөлдөг гэж та үзэж байна уу?

- Маш их нөлөөлдөг
- Нөлөөлдөг
- Дунд зэрэг
- Бага нөлөөлдөг
- Огт нөлөөлдөггүй

17. Хортой контентыг устгах хугацааг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна уу?

- Тийм
- Үгүй

**“Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай”  
хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааны тайлан /Эцэг  
эх, асран хамгаалагч/**

**Судалгааны зорилго:** Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, нийгмийн сүлжээний хэрэглээ болон зохицуулалт, эцэг эхийн оролцоо, хүүхдийн эрхийн хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, хандлага, мэдлэгийн түвшинг тодорхойлоход оршино.

**Нэг. Асуумжийн тус бүрийн дүгнэлт**

Энэхүү судалгаанд нийт 670 оролцогч хамрагдсан бөгөөд багш, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага болон хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүд оролцсон болно.

**1.Та аль аймгаас энэхүү судалгаанд оролцож байна вэ?**

Хариулт	Давтамж	Хувь
Ховд	224	33.4%
Дархан-Уул	190	28.4%
Төв	125	18.7%
Хэнтий	82	12.2%
Завхан	25	3.7%
Улаанбаатар	17	2.5%
Булган	4	0.6%
Хариулаагүй	1	0.1%
Орхон	1	0.1%
Архангай	1	0.1%

Судалгаанд оролцогчдын хамгийн өндөр хувь нь Ховд аймгаас оролцсон бөгөөд нийт оролцогчдын 33.4 хувийг эзэлж байна. Үүний дараа Дархан-Уул аймаг 28.4 хувь, Төв аймаг 18.7 хувь, Хэнтий аймаг 12.2 хувийг тус тус эзэлжээ.

Энэхүү үзүүлэлтээс харахад судалгаанд баруун, төвийн болон хот суурин газрын төлөөлөл хамрагдсан нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын асуудал нь зөвхөн нийслэл төвтэй бус, орон нутгийн хэмжээнд ч бодитоор тулгамдаж буй асуудал болохыг харуулж байна. Ялангуяа Ховд, Дархан-Уул зэрэг аймгуудаас өндөр оролцоо бүртгэгдсэн нь боловсролын байгууллага болон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийн анхаарал, оролцоо идэвхтэй байгааг илтгэж байна.

Мөн энэхүү үр дүн нь хүүхдийн цахим хэрэглээ, цахим эрсдэл нь газарзүйн байршлаас үл хамааран улс даяар түгээмэл болсон бөгөөд хүүхэд хамгааллын бодлого, эрх зүйн зохицуулалтыг үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар боловсруулах шаардлагатайг харуулж байна.

**2. Та ихэвчлэн хэдэн насны хүүхдүүдтэй ажилладаг вэ? (олон сонголттой байж болно)**

Хариулт	Давтамж	Хувь
Бага анги	211	31.5%
Дунд анги, ахлах анги	189	28.2%
Дунд анги	131	19.6%
Ахлах анги	51	7.6%
Бага анги, дунд анги	46	6.9%
Бага анги, дунд анги, ахлах анги	39	5.8%
Бага анги, ахлах анги	3	0.4%

Судалгаанд оролцогчдын хамгийн өндөр хувь нь бага ангийн хүүхдүүдтэй ажилладаг гэж хариулсан бөгөөд нийт оролцогчдын 31.5 хувийг эзэлж байна. Үүний дараа дунд болон ахлах ангийн хүүхдүүдтэй хамтран ажилладаг оролцогчид 28.2 хувь, зөвхөн дунд ангийн хүүхдүүдтэй ажилладаг оролцогчид 19.6 хувийг тус тус эзэлжээ.

Энэхүү үзүүлэлтээс харахад судалгаанд боловсролын байгууллагын бүх шатны төлөөлөл оролцсон боловч бага болон дунд ангийн насны хүүхдүүдтэй өдөр тутам ажилладаг багш, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүд давамгайлж байна. Энэ нь хүүхдийн цахим хэрэглээ эрт наснаас эхэлж, бага насны хүүхдүүд цахим орчны эрсдэлд өртөх магадлал нэмэгдэж байгааг практик түвшинд анзаарч буйг илтгэж байна.

**3. Таны албан тушаал**

Хариулт	Давтамж	Хувь
Багш	615	91.8%
Нийгмийн ажилтан	23	3.4%

Хүүхдийн сэтгэл зүйч	6	0.9%
Сургалтын менежер	4	0.6%
сургалтын менежер	2	0.3%
Асран хамгаалагч	2	0.3%
Мэргэжилтэн	2	0.3%
байрны жижүүр	1	0.1%
Эмч	1	0.1%
Хувиараа	1	0.1%

Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 91.8 хувь нь багш нар эзэлж байна. Үүний зэрэгцээ нийгмийн ажилтан, хүүхдийн сэтгэл зүйч, сургалтын менежер зэрэг хүүхэд хамгаалал, сэтгэл зүй, боловсролын дэмжлэг үйлчилгээтэй холбоотой мэргэжилтнүүд мөн хамрагдсан байна.

Мөн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг мэргэжлийн оролцогчдын хариулт нь цахим орчны эрсдэл нь хүүхдийн сэтгэл зүй, зан төлөв, харилцаанд нөлөөлөх бодит хүчин зүйл болж байгааг нотолж байна. Иймээс хүүхэд хамгааллын асуудлыг зөвхөн техникийн зохицуулалт бус боловсрол, нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн дэмжлэгтэй уялдсан цогц бодлогоор авч үзэх шаардлагатай байна.

#### **4. Таны ЕБС-д ажилласан жил:**

Хариулт	Давтамж	Хувь
10-аас дээш	386	57.6%
4–10 жил	176	26.3%
1–3 жил	108	16.1%

Судалгаанд оролцогчдын 57.6 хувь нь ерөнхий боловсролын сургуульд 10-аас дээш жил ажилласан туршлагатай байгаа нь судалгаанд боловсролын салбарт олон жил ажилласан, практик туршлага бүхий оролцогчид давамгайлсныг харуулж байна. Харин 26.3 хувь нь 4–10 жил, 16.1 хувь нь 1–3 жил ажилласан байна.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим орчны эрсдэлтэй холбоотой асуудлыг зөвхөн түр зуурын эсвэл шинэ үзэгдэл гэж бус, боловсролын орчинд олон жилийн туршид ажиглагдаж буй бодит асуудал гэж үзэж байгааг илтгэж байна. Ялангуяа олон жил ажилласан багш, мэргэжилтнүүдийн өндөр оролцоо нь хүүхдийн зан төлөв, харилцаа, сэтгэл зүй, сургалтын орчинд цахим хэрэглээний өөрчлөлт, сөрөг нөлөөлөл эрчимтэй нэмэгдэж байгааг практик түвшинд мэдэрч буйг харуулж байна.

**5. Сурагчид цахим орчинд дараах эрсдэлтэй тулгарч буйг та ажиглаж байсан уу? (олон сонголттой)**

Хариулт	Давтамж	Хувь
Тулгарч байгаагүй	104	15.5%
Цахим дээрэлхэлт	79	11.8%
Цахим дээрэлхэлт, Хортой агуулга бүхий контент	51	7.6%
Хортой агуулга бүхий контент	50	7.5%
Мэдэхгүй	47	7.0%
Цахим дээрэлхэлт, Хортой агуулга бүхий контент, Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт	36	5.4%
Цахим дээрэлхэлт, Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт	31	4.6%
Цахим дээрэлхэлт, Хортой агуулга бүхий контент, Бэлгийн шинжтэй дарамт, хүчирхийлэл, Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт, Цахим залилан	27	4.0%
Цахим дээрэлхэлт, Хортой агуулга бүхий контент, Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт, Цахим залилан	22	3.3%
Цахим дээрэлхэлт, Хортой агуулга бүхий контент, Бэлгийн шинжтэй дарамт, хүчирхийлэл, Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт	20	3.0%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх нь сурагчид цахим орчинд төрөл бүрийн эрсдэлтэй тулгарч байгааг ажигласан байна. Хэдийгээр 15.5 хувь нь “Тулгарч байгаагүй” гэж хариулсан боловч үлдсэн оролцогчдын ихэнх нь цахим дээрэлхэлт, хортой агуулга бүхий контент, танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт, цахим залилан, бэлгийн шинжтэй дарамт зэрэг олон төрлийн эрсдэлийг нэрлэсэн байна.

Ялангуяа цахим дээрэлхэлт нь хамгийн түгээмэл ажиглагдсан эрсдэлийн нэг байгаа бөгөөд хортой агуулга бүхий контенттой хавсарсан байдлаар өндөр давтамжтай дурдагдсан байна. Үүнээс гадна танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт, цахим залилан, бэлгийн шинжтэй дарамт зэрэг ноцтой эрсдэлүүд хослон илэрч буй нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал зөвхөн мэдээллийн хэрэглээний асуудал биш, харин

хүүхдийн эрх, аюулгүй байдал, сэтгэл зүй, халдашгүй байдлыг хөндөж буй цогц асуудал болсныг харуулж байна.

Мөн “Мэдэхгүй” гэсэн хариулт 7.0 хувийг эзэлж байгаа нь зарим багш, ажилтнууд хүүхдийн цахим орчин дахь эрсдэлийг таньж илрүүлэх мэдлэг, ур чадвар хангалтгүй байж болзошгүйг илэрхийлж байна. Энэ нь хүүхдийн цахим эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Энэхүү үр дүн нь хүүхдүүд цахим орчинд нэг төрлийн бус, харилцан уялдаатай олон эрсдэлд зэрэг өртөж байгааг нотолж байгаа бөгөөд хүүхэд хамгааллын тогтолцоог цахим орчны нөхцөлд шинэчлэн хөгжүүлэх бодит шаардлага бий болсныг илтгэж байна.

**6. Та сүүлийн 1 жилийн хугацаанд цахим орчны эрсдэлд өртсөн хэдэн сурагчтай ажилласан бэ?**

Хариулт	Давтамж	Хувь
Байхгүй	406	60.6%
1–2	195	29.1%
3–5	44	6.6%
10-аас дээш	16	2.4%
6–10	9	1.3%

Судалгаанд оролцогчдын 60.6 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд цахим орчны эрсдэлд өртсөн сурагчтай ажиллаагүй гэж хариулсан боловч үлдсэн 39.4 хувь нь тодорхой тооны эрсдэлд өртсөн хүүхэдтэй ажилласан гэж хариулсан байна. Тухайлбал, 29.1 хувь нь 1–2 сурагч, 6.6 хувь нь 3–5 сурагч, 3.7 хувь нь 6-аас дээш сурагчтай ажилласан гэж хариулжээ.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим орчны эрсдэл нийтлэг шинжтэй болж эхэлснийг харуулж байна. Хэдийгээр бүх оролцогчид эрсдэлтэй тохиолдолтой ажиллаагүй гэж хариулсан ч нийт оролцогчдын бараг 10 хүн тутмын 4 нь цахим эрсдэлд өртсөн хүүхэдтэй ажилласан туршлагатай байгаа нь боловсролын орчинд энэ асуудал бодитоор илэрч байгааг нотолж байна.

Мөн 10-аас дээш эрсдэлтэй хүүхэдтэй ажилласан гэсэн хариулт байгаа нь зарим сургууль, орон нутаг, насны бүлэгт цахим орчны эрсдэл төвлөрсөн шинжтэй байж болзошгүйг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим орчны эрсдэлийг зөвхөн хувь хүний асуудал бус, боловсролын байгууллага болон хүүхэд хамгааллын тогтолцооны хэмжээнд авч үзэх шаардлагатайг илтгэж байна. “Байхгүй” гэсэн өндөр хувь нь хүүхдүүд эрсдэлд өртөөгүй гэсэн утгаас гадна багш, ажилтнууд цахим эрсдэлийг бүрэн илрүүлж чаддаггүй, хүүхдүүд мэдээлдэггүй, эсхүл мэдээлэх

тогтолцоо хангалтгүй байж болзошгүйг давхар илэрхийлж байна. Иймээс цахим орчны эрсдэлийг таних, мэдээлэх, бүртгэх тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

**7. Таны бодлоор хүүхдийн хамгийн их ашигладаг цахим платформ юу вэ? (олон сонголттой байж болно) Нийт хариултын тоо: 668**

Хариулт	Давтамж	Хувь
Facebook	569	85.2%
TikTok	457	68.4%
Instagram	422	63.2%
YouTube	360	53.9%
Онлайн тоглоомын платформ	270	40.4%
Snapchat	59	8.8%
NGL	39	5.8%
Threads	24	3.6%
X /Twitter/	12	1.8%
Discord	7	1.0%

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүдийн хамгийн өргөн хэрэглэдэг цахим платформд Facebook, Instagram, TikTok, YouTube болон онлайн тоглоомын платформууд давамгайлж багтаж байна. Ялангуяа Facebook, Instagram, TikTok хосолсон хэрэглээ хамгийн өндөр хувийг эзэлсэн бөгөөд олон оролцогч эдгээр платформыг YouTube болон онлайн тоглоомын орчинтой хавсарч ашигладаг гэж үзжээ. Хүүхдийн цахим хэрэглээ нэг платформоор хязгаарлагдахгүй, олон платформ дамнан, өндөр идэвхтэй хэрэглээ болж өөрчлөгдсөнийг харуулж байна. Түүнчлэн сошиал сүлжээ, дүрс бичлэгийн платформ болон онлайн тоглоомын орчин зэрэг нь хүүхдийн өдөр тутмын харилцаа, мэдээлэл авах, чөлөөт цагийн хэрэглээний үндсэн хэсэг болж байгааг илтгэж байна.

Мөн TikTok, YouTube зэрэг алгоритмд суурилсан платформууд өндөр давтамжтай дурдагдсан нь хүүхдүүд богино хэмжээний, өндөр давтамжтай контент хэрэглэж байгаа бөгөөд энэ нь донтох шинжтэй хэрэглээ, насанд тохироогүй контент, сэтгэл зүйн нөлөөлөл үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүйг харуулж байна. Онлайн тоглоомын платформууд түгээмэл хэрэглээнд багтаж байгаа нь хүүхдүүд зөвхөн мэдээллийн бус харилцаа, тоглоом, шууд харилцан үйлчлэлийн орчинд өргөн оролцож байгааг илэрхийлж байна.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим хэрэглээний орчин өргөжиж, платформ хоорондын уялдаа нэмэгдсэн нөхцөлд хүүхэд хамгааллын бодлого зөвхөн нэг төрлийн платформд төвлөрөх бус, олон платформ хамарсан цогц зохицуулалт шаардлагатай болсныг харуулж байна.

**8. Сурагч цахим орчинд асуудалд өртсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар та мэдлэгтэй юу?**

Хариулт	Давтамж	Хувь
Зарим талаар	385	57.5%
Тийм	210	31.3%
Үгүй	75	11.2%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 57.5 хувь нь сурагч цахим орчинд асуудалд өртсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар “зарим талаар” мэдлэгтэй гэж хариулсан байна. Харин 31.3 хувь нь хангалттай мэдлэгтэй гэж үзсэн бол 11.2 хувь нь огт мэдлэггүй гэж хариулжээ.

Энэхүү үзүүлэлт нь боловсролын байгууллагын ажилтнууд хүүхдийн цахим орчны эрсдэлийн асуудлыг тодорхой хэмжээнд ойлгож байгаа боловч бодит нөхцөлд хэрхэн хариу арга хэмжээ авах, хаана мэдээлэх, хүүхдийг хэрхэн хамгаалах талаар нэгдсэн ойлголт, практик чадавх хангалтгүй байгааг харуулж байна. Ялангуяа “зарим талаар” гэсэн хариулт өндөр байгаа нь цахим орчны эрсдэлтэй холбоотой асуудалд ажиллах арга зүй, эрх зүйн зохицуулалт, байгууллага хоорондын уялдаа тодорхой бус байж болзошгүйг илэрхийлж байна.

Мөн 11.2 хувь нь ямар арга хэмжээ авах талаар мэдлэггүй гэж хариулсан нь хүүхэд хамгааллын тогтолцоонд цахим орчны эрсдэлтэй холбоотой мэдлэг, ур чадварын зөрүү байгааг харуулж байна. Энэ нь хүүхэд цахим орчинд эрсдэлд өртсөн үед хохирлыг бууруулах, шуурхай хамгаалах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа хангалтгүй хэрэгжих эрсдэлийг бий болгож байна.

**9. Цахим орчинд эрсдэлд өртсөн сурагчийн хувийн мэдээллийг та нууцалдаг уу?**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	596	89.0%
Зарим талаар	59	8.8%
Үгүй	15	2.2%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 89.0 хувь нь цахим орчинд эрсдэлд өртсөн сурагчийн хувийн мэдээллийг нууцалдаг гэж хариулсан байна. Энэ нь боловсролын байгууллагын ажилтнууд хүүхдийн хувийн мэдээлэл, нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах асуудалд өндөр ач холбогдол өгч байгааг харуулж байна.

Гэсэн хэдий ч 8.8 хувь нь “зарим талаар” гэж хариулсан бөгөөд 2.2 хувь нь хувийн мэдээллийг нууцалдаггүй гэж хариулсан нь хүүхдийн мэдээлэл хамгаалалтын талаарх ойлголт, практик хэрэглээ жигд бус байгааг илтгэж байна. Ялангуяа цахим орчинд өртсөн хүүхдийн талаарх мэдээлэл алдагдах, бусдад тарах, давхар сэтгэл зүйн дарамтад орох эрсдэлийг үүсгэж болзошгүй нөхцөл байдал байгааг энэхүү үр дүн харуулж байна.

Мөн цахим орчны эрсдэлтэй холбоотой кейсүүд нь хүүхдийн нэр төр, сэтгэл зүй, аюулгүй байдалтай шууд холбоотой тул мэдээллийн нууцлал нь зөвхөн ёс зүйн асуудал бус хүүхдийн эрхийн хамгаалалтын үндсэн зарчим болохыг харуулж байна. Тиймээс хүүхдийн мэдээллийг хамгаалах, боловсруулах, дамжуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, байгууллагын журам, мэргэжлийн стандарт шаардлагатай байна.

**10. Цахим орчинд сурагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авахад танд хамгийн их тулгардаг хүндрэл юу вэ? (олон сонголттой байж болно) Нийт хариултын тоо: 623**

Хариулт	Давтамж	Хувь
Сурагчид нууж хаадаг, Эцэг эхийн оролцоо сул	151	22.5%
Сурагчид нууж хаадаг	63	9.4%
Мэдлэг, сургалт дутмаг, Сурагчид нууж хаадаг, Эцэг эхийн оролцоо сул	61	9.1%
Сурагчид нууж хаадаг, Эцэг эхийн оролцоо сул, Цаг, ачаалал их	60	9.0%
Эцэг эхийн оролцоо сул	60	9.0%
Мэдлэг, сургалт дутмаг	35	5.2%
Мэдлэг, сургалт дутмаг, Эцэг эхийн оролцоо сул	34	5.1%
Эцэг эхийн оролцоо сул, Цаг, ачаалал их	31	4.6%
Мэдлэг, сургалт дутмаг, Сурагчид нууж хаадаг, Эцэг эхийн оролцоо сул, Цаг, ачаалал их	20	3.0%

Мэдлэг, сургалт дутмаг, Сурагчид нууж хаадаг	18	2.7%
--	----	------

Судалгааны үр дүнгээс харахад цахим орчинд сурагчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хамгийн түгээмэл тулгарч буй хүндрэл нь сурагчид асуудлаа нууж хаадаг байдал болон эцэг эхийн оролцоо сул байдал байна. Ялангуяа эдгээр хоёр хүчин зүйл хавсарсан байдлаар хамгийн өндөр буюу 22.5 хувийг эзэлсэн нь хүүхдийн цахим орчны эрсдэлийг илрүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд гэр бүл болон хүүхдийн хамтын оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн “мэдлэг, сургалт дутмаг” гэсэн хүчин зүйл дангаар болон бусад хүндрэлтэй хавсарсан байдлаар өндөр давтамжтай дурдагдсан нь боловсролын байгууллагын ажилтнууд цахим орчны эрсдэлтэй ажиллах мэргэжлийн бэлтгэл, арга зүйн дэмжлэг хангалтгүй байгааг илэрхийлж байна. Үүнээс гадна “цаг, ачаалал их” гэсэн хүндрэл давхар дурдагдсан нь багш, нийгмийн ажилтнуудын ажлын ачаалал өндөр байдаг тул хүүхдийн цахим аюулгүй байдалд тогтмол хяналт, дэмжлэг үзүүлэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Өөр талаас нь харвал:

Хүндрэл	Давтамж	Хувь
Сурагчид нууж хаадаг	463	74.3%
Эцэг эхийн оролцоо сул	444	71.3%
Мэдлэг, сургалт дутмаг	233	37.4%
Цаг, ачаалал их	214	34.3%
Сургуулийн бодлого тодорхой биш	88	14.1%
Бусад	2	0.3%

**11. Цахим орчинд асуудалд өртсөн сурагчийн талаарх багшийн ажиглалт:**

Хариулт	Давтамж	Хувь
Зан төлөвийн өөрчлөлт	349	52.2%
Сэтгэл зүйн шинж тэмдэг	302	45.2%

Цахим хэрэглээтэй холбоотой донтолт	281	42.1%
Нийгмийн харилцааны өөрчлөлт	219	32.8%
Сургалтын үзүүлэлт	163	24.4%
Мэдэхгүй	2	0.3%

Судалгааны үр дүнгээс харахад цахим орчинд асуудалд өртсөн сурагчдад хамгийн түгээмэл ажиглагдаж буй өөрчлөлт нь зан төлөвийн өөрчлөлт бөгөөд нийт оролцогчдын 52.2 хувь нь энэ төрлийн шинж тэмдгийг ажигласан байна. Үүний дараа сэтгэл зүйн шинж тэмдэг 45.2 хувь, цахим хэрэглээтэй холбоотой донтолт 42.1 хувь, нийгмийн харилцааны өөрчлөлт 32.8 хувь, сургалтын үзүүлэлтийн өөрчлөлт 24.4 хувийг тус тус эзэлжээ.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим орчны эрсдэл нь зөвхөн цахим хэрэглээний асуудал бус, хүүхдийн зан төлөв, сэтгэл зүй, нийгмийн харилцаа, боловсролын орчинд бодитоор нөлөөлж буйг харуулж байна. Ялангуяа зан төлөв болон сэтгэл зүйн өөрчлөлт өндөр хувьтай байгаа нь цахим дарамт, зохисгүй контент, хэт хэрэглээ зэрэг нь хүүхдийн дотоод сэтгэлзүй, харилцааны чадвар, өөрийгөө илэрхийлэх байдалд сөргөөр нөлөөлж байгааг илтгэж байна.

Мөн цахим хэрэглээтэй холбоотой донтолын шинж 42.1 хувьд ажиглагдсан нь хүүхдүүдийн цахим орчинд өнгөрүүлэх хугацаа, алгоритмд суурилсан контентын нөлөө, онлайн тоглоом болон сошиал хэрэглээ хяналтгүй түвшинд хүрч болзошгүйг харуулж байна. Энэ нь хүүхдийн эрүүл хөгжил, төвлөрөл, нийгмийн оролцоонд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгож байна.

**12.1. Танай сургууль дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлдэг үү? [Цахим аюулгүй байдлын сургалт ]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	540	80.6%
Үгүй	130	19.4%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 80.6 хувь нь өөрийн сургуульд цахим аюулгүй байдлын сургалт зохион байгуулдаг гэж хариулсан бол 19.4 хувь нь ийм сургалт хэрэгжүүлдэггүй гэж хариулсан байна.

Энэхүү үзүүлэлт нь ерөнхий боловсролын сургуулиуд хүүхдийн цахим орчны эрсдэлийн асуудлыг тодорхой хэмжээнд анхаарч, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээллийн ажил зохион байгуулж байгааг

харуулж байна. Ялангуяа цахим орчны эрсдэл, цахим дээрэлхэлт, хувийн мэдээлэл хамгаалалт, зохистой хэрэглээ зэрэг асуудал нь сургуулийн орчинд бодит хэрэгцээ болсон тул сургалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага нэмэгдэж байгааг илтгэж байна.

Гэсэн хэдий ч нийт оролцогчдын бараг тавны нэг нь цахим аюулгүй байдлын сургалт зохион байгуулдаггүй гэж хариулсан нь сургуулиудын чадавх, нөөц, арга зүй, бодлогын хэрэгжилт жигд бус байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим аюулгүй байдлын боловсрол нь сургууль бүрт ижил түвшинд хүрэхгүй байгаа бөгөөд зарим хүүхэд хамгааллын үйлчилгээ, урьдчилан сэргийлэх мэдээллээс хоцрох эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.

**12.2. Танай сургууль дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлдэг үү? [Эцэг эхэд зориулсан зөвлөгөө]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	514	76.7%
Үгүй	156	23.3%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 76.7 хувь нь сургуульдаа эцэг эхэд зориулсан зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулдаг гэж хариулсан бол 23.3 хувь нь ийм арга хэмжээ хэрэгжүүлдэггүй гэж хариулсан байна.

Энэхүү үзүүлэлт нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангахад эцэг эхийн оролцоо чухал болохыг боловсролын байгууллагууд тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрч, зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа хэрэгжүүлж байгааг харуулж байна. Ялангуяа хүүхдийн цахим хэрэглээ гэр бүлийн орчинд явагддаг тул эцэг эхийн хяналт, дэмжлэг, ойлголт нь хүүхдийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байгааг илэрхийлж байна.

Гэсэн хэдий ч нийт оролцогчдын бараг дөрөвний нэг нь эцэг эхэд зориулсан зөвлөгөө өгдөггүй гэж хариулсан нь сургуулиудын хэрэгжилт, нөөц боломж, арга зүйн чадавх харилцан адилгүй байгааг харуулж байна. Энэ нь зарим эцэг эх хүүхдийн цахим хэрэглээ, эрсдэл, хамгаалалтын талаарх шаардлагатай мэдлэг, мэдээлэлгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Мөн өмнөх асуултуудад “эцэг эхийн оролцоо сул” гэсэн хүндрэл өндөр хувьтай гарсан нь эцэг эхэд зориулсан зөвлөгөө, мэдээллийн ажлыг илүү системтэй, үр дүнтэй, тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатайг давхар нотолж байна. Иймээс хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах асуудалд гэр бүлийн оролцоог бодлогын түвшинд тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

**12.3. Танай сургууль дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлдэг үү? [Хүүхдэд зориулсан сургалт]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	595	88.8%
Үгүй	75	11.2%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 88.8 хувь нь сургуульдаа хүүхдэд зориулсан цахим аюулгүй байдал, цахим хэрэглээтэй холбоотой сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулдаг гэж хариулсан байна. Харин 11.2 хувь нь ийм төрлийн сургалт зохион байгуулдаггүй гэж хариулжээ.

Энэхүү үзүүлэлт нь ерөнхий боловсролын сургуулиуд хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах асуудлыг тодорхой түвшинд үйл ажиллагаандаа тусгаж, хүүхдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлж байгааг харуулж байна. Ялангуяа хүүхдүүд цахим орчинд эрт наснаас идэвхтэй оролцож байгаа нөхцөлд цахим аюулгүй байдал, зохистой хэрэглээ, хувийн мэдээлэл хамгаалалт, цахим дээрэлхэлтээс сэргийлэх мэдлэгийг сургуулийн орчинд олгох хэрэгцээ өндөр байгааг илэрхийлж байна.

Гэсэн хэдий ч нийт оролцогчдын 11.2 хувь нь хүүхдэд зориулсан сургалт зохион байгуулдаггүй гэж хариулсан нь сургуулиудын хүртээмж, чадавх, арга зүйн дэмжлэг харилцан адилгүй байгааг харуулж байна. Энэ нь зарим хүүхэд цахим орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн мэдлэг, хамгаалалтын арга барилгүй байх эрсдэлийг бий болгож байна.

**12.4. Танай сургууль дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлдэг үү? [Дотоод журам]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	496	74.0%
Үгүй	174	26.0%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 74.0 хувь нь сургуульдаа хүүхдийн цахим орчны аюулгүй байдалтай холбоотой дотоод журам хэрэгжүүлдэг гэж хариулсан бол 26.0 хувь нь ийм журамгүй гэж хариулсан байна.

Энэхүү үзүүлэлт нь ерөнхий боловсролын сургуулиудын дийлэнх нь хүүхдийн цахим хэрэглээ, цахим эрсдэлтэй холбоотой асуудлыг зохицуулах шаардлагатай гэж үзэн тодорхой дотоод зохицуулалт хэрэгжүүлж байгааг харуулж байна. Энэ нь сургуулийн орчинд цахим аюулгүй байдал нь хүүхэд

хамгааллын бодит асуудал болж, байгууллагын түвшинд анхаарал хандуулах шаардлага үүссэнийг илэрхийлж байна.

Гэсэн хэдий ч нийт оролцогчдын дөрөвний нэгээс илүү хувь нь дотоод журамгүй гэж хариулсан нь сургуулиудын бодлогын хэрэгжилт, арга зүй, удирдлагын түвшний зохион байгуулалт харилцан адилгүй байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим орчны эрсдэлтэй холбоотой асуудал гарсан тохиолдолд сургууль бүр өөр өөр байдлаар хандах, хамгааллын арга хэмжээ жигд бус хэрэгжих эрсдэлийг бий болгож байна.

**13.1. Дараах насны ангилалд цахим сүлжээний хэрэглээг ямар түвшинд зөвшөөрөх нь тохиромжтой вэ? [08-10 нас]**

Хариулт	Давтамж	Хувь
Огт ашиглуулахгүй	358	53.4%
Хязгаарлагдмал ашиглуулах	205	30.6%
Эцэг эхийн хяналттай ашиглуулах	105	15.7%
Чөлөөтэй ашиглуулах	2	0.3%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 53.4 хувь нь 08–10 насны хүүхдийг цахим сүлжээ огт ашиглуулахгүй байх нь тохиромжтой гэж үзсэн байна. Үүний дараа 30.6 хувь нь хязгаарлагдмал байдлаар ашиглуулах, 15.7 хувь нь эцэг эхийн хяналттай ашиглуулах нь зөв гэж хариулжээ. Харин ердөө 0.3 хувь нь чөлөөтэй ашиглуулах боломжтой гэж үзсэн байна.

Энэхүү үр дүн нь бага насны хүүхдийн цахим орчны хэрэглээний эрсдэлийн талаарх олон нийтийн болгоомжлол өндөр байгааг харуулж байна. Ялангуяа 08–10 насны хүүхэд нь сэтгэл зүй, танин мэдэхүй, мэдээлэл шүүх чадвар бүрэн төлөвшөөгүй насны бүлэг тул цахим сүлжээний зохисгүй контент, танихгүй хэрэглэгчтэй харилцах эрсдэл, донтох шинжтэй хэрэглээ, сэтгэл зүйн нөлөөлөлд өртөх магадлал өндөр гэж үзэж байгааг илэрхийлж байна.

Мөн “хязгаарлагдмал ашиглуулах” болон “эцэг эхийн хяналттай ашиглуулах” гэсэн хариултууд өндөр хувьтай байгаа нь оролцогчид хүүхдийн цахим хэрэглээг бүрэн хориглох бус, насанд нь тохирсон хамгаалалт, хяналттай орчинд ашиглуулах шаардлагатай гэж үзэж байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим хэрэглээг зөвшөөрөхдөө насны онцлог, хамгаалалтын түвшин, эцэг эхийн оролцоог зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай гэсэн нийгмийн хандлагыг илэрхийлж байна.

**13.2. Дараах насны ангилалд цахим сүлжээний хэрэглээг ямар түвшинд зөвшөөрөх нь тохиромжтой вэ? [11-12 нас]**

Хариулт	Давтамж	Хувь
Хязгаарлагдмал ашиглуулах	369	55.1%
Эцэг эхийн хяналттай ашиглуулах	170	25.4%
Огт ашиглуулахгүй	127	19.0%
Чөлөөтэй ашиглуулах	4	0.6%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 55.1 хувь нь 11–12 насны хүүхдийг цахим сүлжээг хязгаарлагдмал байдлаар ашиглуулах нь тохиромжтой гэж үзсэн байна. Үүний дараа 25.4 хувь нь эцэг эхийн хяналттай ашиглуулах, 19.0 хувь нь огт ашиглуулахгүй байх нь зөв гэж хариулжээ. Харин ердөө 0.6 хувь нь чөлөөтэй ашиглуулах боломжтой гэж үзсэн байна.

Энэхүү үр дүн нь 11–12 насны хүүхдийн хувьд цахим хэрэглээг бүрэн хориглох бус тодорхой хяналт, зохицуулалттайгаар ашиглуулах нь зүйтэй гэсэн хандлага давамгайлж байгааг харуулж байна. Энэ насны хүүхдүүд цахим орчинд идэвхтэй нэвтэрч эхэлдэг боловч мэдээлэл шүүх, эрсдэл таних, өөрийгөө хамгаалах чадвар бүрэн төлөвшөөгүй хэвээр байгаа тул хяналтгүй хэрэглээ нь эрсдэлтэй гэж оролцогчид үзэж байгааг илэрхийлж байна.

Мөн “эцэг эхийн хяналттай ашиглуулах” гэсэн хариулт өндөр хувьтай байгаа нь хүүхдийн цахим хэрэглээнд гэр бүлийн оролцоо, хяналт чухал хэвээр байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангахад зөвхөн платформын зохицуулалт бус эцэг эхийн оролцоонд суурилсан хамгаалалтын механизм шаардлагатайг илтгэж байна.

Түүнчлэн “чөлөөтэй ашиглуулах” гэсэн хариулт маш бага хувьтай байгаа нь олон нийт бага болон дунд насны хүүхдийн цахим хэрэглээг хяналтгүй орчинд зөвшөөрөх нь зохисгүй гэж үзэж байгааг тодорхой харуулж байна. Энэ нь хүүхдийн насны онцлогт нийцсэн шаталсан зохицуулалт шаардлагатай гэсэн нийгмийн хүлээлтийг илэрхийлж байна.

### **13.3. Дараах насны ангилалд цахим сүлжээний хэрэглээг ямар түвшинд зөвшөөрөх нь тохиромжтой вэ? [13-15 нас]**

Хариулт	Давтамж	Хувь
Хязгаарлагдмал ашиглуулах	374	55.8%
Эцэг эхийн хяналттай ашиглуулах	244	36.4%

Огт ашиглуулахгүй	40	6.0%
Чөлөөтэй ашиглуулах	12	1.8%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 55.8 хувь нь 13–15 насны хүүхдийг цахим сүлжээг хязгаарлагдмал байдлаар ашиглуулах нь тохиромжтой гэж үзсэн байна. Үүний зэрэгцээ 36.4 хувь нь эцэг эхийн хяналттай ашиглуулах нь зөв гэж хариулсан бол ердөө 1.8 хувь нь чөлөөтэй ашиглуулах боломжтой гэж үзжээ.

Энэхүү үзүүлэлт нь өсвөр насны хүүхдүүд цахим орчинд идэвхтэй оролцох шаардлага нэмэгдэж байгаа ч тэднийг бүрэн чөлөөтэй орчинд ашиглуулах нь эрсдэлтэй гэж олон нийт үзэж байгааг харуулж байна. Ялангуяа энэ насны хүүхдүүд нийгмийн сүлжээ, онлайн харилцаа, контентын хэрэглээнд хамгийн идэвхтэй оролцдог үе шатанд байдаг тул цахим дарамт, хортой контент, донтох шинжтэй хэрэглээ, танихгүй хэрэглэгчтэй харилцах эрсдэл өндөр хэвээр байгааг оролцогчид анхаарч үзсэн байна.

Мөн “эцэг эхийн хяналттай ашиглуулах” гэсэн өндөр хувь нь өсвөр насны хүүхдэд тодорхой хэмжээнд бие даасан хэрэглээ олгох боловч хамгаалалт, хяналтын механизм шаардлагатай хэвээр байгааг илэрхийлж байна. Энэ нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдалд нас ахих тусам хэрэглээний эрх чөлөө нэмэгдэх боловч түүнтэй уялдсан хамгаалалтын зохицуулалт мөн шаталсан байдлаар хэрэгжих шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн “огт ашиглуулахгүй” гэсэн хариулт 6.0 хувь байгаа нь өсвөр насны хүүхдийн цахим хэрэглээний эрсдэлийн талаарх болгоомжлол тодорхой хэмжээнд хэвээр байгааг илэрхийлж байна. Иймээс энэ насны бүлэгт зөв хэрэглээ, өөрийгөө хамгаалах чадвар, цахим боловсрол хамгийн чухал хэрэгцээ болж байгааг энэхүү үр дүн харуулж байна.

**13.4. Дараах насны ангилалд цахим сүлжээний хэрэглээг ямар түвшинд зөвшөөрөх нь тохиромжтой вэ? [16-аас дээш]**

Хариулт	Давтамж	Хувь
Хязгаарлагдмал ашиглуулах	310	46.3%
Эцэг эхийн хяналттай ашиглуулах	226	33.7%
Чөлөөтэй ашиглуулах	119	17.8%
Огт ашиглуулахгүй	15	2.2%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын хамгийн өндөр хувь буюу 46.3 хувь нь 16-аас дээш насны хүүхдийн цахим сүлжээний хэрэглээг хязгаарлагдмал байдлаар ашиглуулах нь тохиромжтой гэж үзсэн байна. Үүний зэрэгцээ 33.7 хувь нь эцэг эхийн хяналттай ашиглуулах, 17.8 хувь нь чөлөөтэй ашиглуулах нь зөв гэж хариулжээ.

Энэхүү үр дүн нь ахлах насны хүүхдүүдийн хувьд цахим хэрэглээ нь боловсрол, харилцаа, мэдээлэл авах, нийгмийн оролцооны нэг хэсэг болсон хэдий ч бүрэн хяналтгүй орчинд ашиглуулах нь эрсдэлтэй хэвээр гэж олон нийт үзэж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хүүхэд нас ахих тусам цахим хэрэглээний эрх чөлөө нэмэгдэх боломжтой ч хамгаалалтын зохицуулалт, хариуцлагатай хэрэглээний шаардлага хэвээр байгааг илэрхийлж байна.

Мөн “чөлөөтэй ашиглуулах” гэсэн хариулт өмнөх насны бүлгүүдтэй харьцуулахад өссөн нь 16-аас дээш насны хүүхдүүд мэдээлэл боловсруулах, эрсдэл таних, өөрийгөө хамгаалах чадвар илүү хөгжсөн гэж үзэж байгааг илтгэж байна. Гэсэн хэдий ч нийт оролцогчдын олонх нь хязгаарлалт болон эцэг эхийн хяналтыг чухал хэвээр гэж үзсэн нь цахим дарамт, хортой контент, цахим залилан, донтох хэрэглээ зэрэг эрсдэл энэ насанд ч бодитой байгааг харуулж байна.

**14. Хүүхдийг нас, хөгжлийн онцлогт нь тохироогүй, хортой контентоос хамгаалах зорилгоор цахим орчин дахь тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэж та үзэж байна уу?**

Хариулт	Давтамж	Хувь
Бүрэн санал нийлнэ	530	79.1%
Санал нийлнэ	104	15.5%
Зарим талаар санал нийлнэ	30	4.5%
Санал нийлэхгүй	4	0.6%
Огт санал нийлэхгүй	2	0.3%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 79.1 хувь нь хүүхдийг нас, хөгжлийн онцлогт нь тохироогүй, хортой контентоос хамгаалах зорилгоор цахим орчин дахь тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэдэгтэй бүрэн санал нийлсэн байна. Мөн 15.5 хувь нь санал нийлнэ гэж хариулсан бөгөөд нийтдээ оролцогчдын 94.6 хувь нь хүүхдийг хортой контентоос хамгаалах зохицуулалтыг дэмжиж байгаа нь харагдаж байна.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын асуудал нийгмийн хэмжээнд бодит эрсдэл болсон бөгөөд насанд тохироогүй

контент хүүхдийн хөгжил, сэтгэл зүй, зан төлөвт сөрөг нөлөө үзүүлж байгааг олон нийт хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна. Ялангуяа өмнөх асуултуудад зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн шинж тэмдэг, цахим хэрэглээтэй холбоотой донтолт өндөр хувьтай гарсан нь хортой контентын нөлөөлөл хүүхдийн өдөр тутмын амьдралд бодитоор илэрч байгааг давхар нотолж байна.

Мөн эсэргүүцсэн байр суурь маш бага хувьтай байгаа нь хүүхдийн цахим орчны хамгаалалтад төрийн зохицуулалт, платформын хариуцлага, контентын ангилал зайлшгүй шаардлагатай гэсэн нийгмийн зөвшилцөл бүрдэж байгааг илэрхийлж байна. Энэ нь хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд цахим орчны зохицуулалт хийх нь үг хэлэх эрх чөлөөг хязгаарлах асуудал бус, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах бодлогын шаардлага гэж ойлгогдож байгааг харуулж байна.

**15.1. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Хувийн хаягийн нууцлал (profile private байх)]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	639	95.4%
Үгүй	31	4.6%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 95.4 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор хувийн хаягийн нууцлалын тохиргоог анхнаас нь автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим орчин дахь хамгаалалтын үндсэн механизм нь default буюу анхдагч тохиргооноос эхлэх ёстой гэсэн олон нийтийн маш өндөр дэмжлэг байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь хүүхдүүд өөрсдөө хувийн мэдээллийн эрсдэлийг бүрэн ойлгож, хамгаалалтын тохиргоог зөв хийх чадвар хангалтгүй байдаг тул платформын түвшинд урьдчилан хамгаалсан орчин бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байгааг илэрхийлж байна. Ялангуяа өмнөх асуултуудад танихгүй хүнээс ирсэн мессеж, цахим дарамт, бэлгийн шинжтэй дарамт, хувийн мэдээлэлтэй холбоотой эрсдэлүүд өндөр хувьтай гарсан нь хүүхдийн аккаунтыг нээлттэй байлгах нь аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байгааг харуулж байна.

Мөн энэхүү үр дүн нь хүүхэд хамгааллын бодлого зөвхөн хэрэглэгчийн сонголтод тулгуурлах бус, “safety by default” буюу анхдагчаар хамгаалсан орчны зарчимд суурилах шаардлагатайг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл хүүхэд өөрөө хамгаалалтаа идэвхжүүлэхийг хүлээх бус, платформ өөрөө хүүхдийн аюулгүй байдлыг урьдчилан хангах үүрэгтэй байх ёстой гэсэн хандлага давамгайлж байна.

**15.2. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	640	95.5%
Үгүй	30	4.5%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 95.5 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор танихгүй хүнээс мессеж хүлээн авах боломжийг анхдагчаар хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим орчин дахь хамгийн том эрсдэлийн нэг нь танихгүй хэрэглэгчтэй холбоо тогтоох асуудал гэж олон нийт үзэж байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт, бэлгийн шинжтэй дарамт, цахим залилан зэрэг эрсдэлүүдтэй шууд холбоотой байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн цахим орчны аюулгүй байдалд хамгийн түрүүнд хамгаалах шаардлагатай зүйл нь танихгүй этгээдтэй хяналтгүй харилцах боломж гэж оролцогчид үзэж байгааг илэрхийлж байна.

**15.3. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Байршил (location) хуваалцахыг унтраах]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	551	82.2%
Үгүй	119	17.8%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 82.2 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор байршил (location) хуваалцах тохиргоог анхдагчаар автоматаар унтраасан байх шаардлагатай гэж үзсэн байна.

Энэхүү үр дүн нь хүүхдийн бодит байршлын мэдээлэл цахим орчинд ил болох нь аюулгүй байдалд ноцтой эрсдэл үүсгэж болзошгүй гэсэн олон нийтийн болгоомжлол өндөр байгааг харуулж байна. Ялангуяа хүүхдийн байршлын мэдээлэл нь танихгүй этгээдтэй холбоо тогтоох, мөрдөх, дарамтлах, бэлгийн мөлжлөг, гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой тул үүнийг хүүхэд хамгааллын чухал асуудал гэж үзэж байгааг илэрхийлж байна.

Мөн энэхүү үр дүн нь хүүхдийн аюулгүй байдлыг зөвхөн хэрэглэгчийн сонголтод үлдээх бус платформын анхдагч хамгаалалтын бодлогын

хүрээнд шийдвэрлэх шаардлагатай гэсэн хандлага давамгайлж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн байршлын мэдээллийг автоматаар хамгаалах нь “privacy by default” болон “safety by default” зарчмын хүрээнд хэрэгжих ёстой гэж үзэж байна.

**15.4. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Ёс бус үг хэллэг ашигласан коммент устгах]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	653	97.5%
Үгүй	17	2.5%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын бараг бүхэлдээ буюу 97.5 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор ёс бус үг хэллэг агуулсан коментуудыг автоматаар устгах тохиргоог анхдагчаар идэвхжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь цахим орчин дахь хэл ярианы хүчирхийлэл, доромжлол, цахим дээрэлхэлт нь хүүхдийн аюулгүй байдалд хамгийн түгээмэл бөгөөд бодит эрсдэл болж байгааг олон нийт хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн шинж тэмдэг, цахим дээрэлхэлт зэрэг үзүүлэлтүүдтэй шууд уялдаж байна. Өөрөөр хэлбэл цахим орчин дахь доромжлол, ёс бус харилцаа нь хүүхдийн сэтгэл зүй, өөртөө итгэх байдал, нийгмийн харилцаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байгааг оролцогчид бодитоор ажиглаж буйг илэрхийлж байна.

**15.5. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Шөнийн хэрэглээг хязгаарлах]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	640	95.5%
Үгүй	30	4.5%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 95.5 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор шөнийн хэрэглээг анхдагчаар автоматаар хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим хэрэглээний хугацаа, давтамж нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, өдөр тутмын амьдралд бодит нөлөө үзүүлж байгааг олон нийт анхаарч байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан цахим хэрэглээтэй холбоотой донтолт, зан төлөвийн өөрчлөлт, сургалтын үзүүлэлтийн бууралт зэрэг асуудлуудтай шууд холбоотой байна. Ялангуяа шөнийн цагаар удаан хугацаанд цахим орчин ашиглах нь хүүхдийн нойр, сэтгэл зүй, төвлөрөл, сурлагын амжилт, бие бялдрын хөгжилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж оролцогчид үзэж байгааг илэрхийлж байна.

Түүнчлэн шөнийн хэрэглээг автоматаар хязгаарлах шаардлагатай гэсэн өндөр дэмжлэг нь хүүхдийн цахим хэрэглээнд “digital wellbeing” буюу цахим хэрэглээний эрүүл орчны бодлого шаардлагатай болсон болохыг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим хэрэглээний донтолт, хэт хамаарлыг зөвхөн гэр бүлийн асуудал бус хүүхэд хамгааллын бодлогын асуудал гэж үзэж байгааг илэрхийлж байна.

**15.6 Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Дэлгэц ашиглалтын хугацааны хязгаар (screen time limit)]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	643	96.0%
Үгүй	27	4.0%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 96.0 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дэлгэц ашиглалтын хугацааны хязгаарлалтын тохиргоог анхдагчаар автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим хэрэглээний хугацаа нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, боловсрол, өдөр тутмын амьдралд шууд нөлөөлж буй асуудал гэж олон нийт үзэж байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан цахим хэрэглээтэй холбоотой донтолт, зан төлөвийн өөрчлөлт, сургалтын үзүүлэлтийн бууралт, шөнийн хэрэглээ зэрэг асуудлуудтай шууд уялдаж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн цахим хэрэглээний асуудал нь зөвхөн контентын эрсдэл бус, мөн хэрэглээний хугацааны хэтрэлттэй холбоотой асуудал болсон болохыг илэрхийлж байна.

Мөн энэхүү үзүүлэлт нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад платформын анхдагч хамгаалалтын тохиргоо чухал үүрэгтэй гэж үзэж байгааг харуулж байна. Ялангуяа хүүхэд өөрөө хэрэглээний хугацаагаа зохистой түвшинд хянах чадвар хангалтгүй байдаг тул платформ болон төхөөрөмжийн түвшинд урьдчилан хамгаалсан хязгаарлалт шаардлагатай гэсэн хандлага давамгайлж байна.

**15.7. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Донтох зан төлөв өдөөсөн богино видеог хязгаарлах]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	644	96.1%
Үгүй	26	3.9%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 96.1 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор донтох зан төлөв өдөөсөн богино видеоны хэрэглээг анхдагчаар хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь алгоритмд суурилсан богино хэмжээний видео контент хүүхдийн анхаарал, сэтгэл зүй, хэрэглээний дадалд хүчтэй нөлөө үзүүлж байгааг олон нийт бодит эрсдэл гэж үзэж байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан цахим хэрэглээтэй холбоотой донтолт, шөнийн хэрэглээ, дэлгэц ашиглалтын хугацааны хэтрэлт, зан төлөвийн өөрчлөлт зэрэг асуудлуудтай шууд холбоотой байна. Ялангуяа богино видео платформууд нь хэрэглэгчийг удаан хугацаанд тасралтгүй хэрэглээнд байлгах алгоритмын бүтэцтэй байдаг тул хүүхдийн төвлөрөл, сэтгэл хөдлөл, цагийн менежмент, суралцах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж оролцогчид үзэж байгааг илэрхийлж байна.

Мөн энэхүү үзүүлэлт нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын асуудал зөвхөн илт хортой контентын асуудал бус, платформын алгоритм, хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөх дизайн, анхаарал татах механизмыг хамарч байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн цахим хамгаалалтад “algorithmic safety” буюу алгоритмын аюулгүй байдлын асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай болжээ.

**15.8. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Насанд хүрэгчдийн агуулга, сэтгэл зүйн дарамт үүсгэх, сөрөг зан төлөвийг өдөөх контентыг хязгаарлах]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	653	97.5%
Үгүй	17	2.5%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 97.5 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор насанд хүрэгчдийн агуулга, сэтгэл зүйн дарамт үүсгэх болон сөрөг зан төлөвийг өдөөх контентыг анхдагчаар автоматаар хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим орчны эрсдэлийн хамгийн ноцтой хэсэг

нь зохисгүй болон хортой контентын нөлөөлөл гэж олон нийт үзэж байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан сэтгэл зүйн шинж тэмдэг, зан төлөвийн өөрчлөлт, цахим донтолт, цахим дээрэлхэлт зэрэг асуудлуудтай шууд холбоотой байна. Ялангуяа хүчирхийлэл, бэлгийн агуулга, амиа хорлолт, өөртөө гэмтэл учруулахыг өдөөсөн, айдас түгшүүр төрүүлэх, сөрөг зан төлөвийг хэвийн мэт ойлгуулах контент нь хүүхдийн сэтгэл зүй, үнэт зүйл, зан төлөвт ноцтой нөлөө үзүүлж болзошгүй гэж оролцогчид үзэж байгааг илэрхийлж байна.

Мөн энэхүү үр дүн нь хүүхдийн хамгаалалтыг зөвхөн хэрэглэгчийн сонголтод үлдээх бус платформын түвшинд автоматаар хамгаалсан орчин бүрдүүлэх шаардлагатай гэсэн нийгмийн зөвшилцөл өндөр байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн аккаунтад насанд тохироогүй болон сэтгэл зүйд сөрөг нөлөөтэй контентыг анхдагчаар шүүж, хязгаарладаг “safe by default” зарчим хэрэгжих шаардлагатай гэж үзэж байна.

**15.9 Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Хүүхдийн насанд тохиромжгүй live/stream]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	646	96.4%
Үгүй	24	3.6%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 96.4 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор насанд тохиромжгүй live/stream контентыг анхдагчаар автоматаар хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь шууд дамжуулалтын платформууд хүүхдийн аюулгүй байдалд өндөр эрсдэл үүсгэж болзошгүй орчин гэж олон нийт үзэж байгааг харуулж байна.

Live/stream контент нь урьдчилан бүрэн хянагдах боломж хязгаарлагдмал байдаг тул хүчирхийлэл, бэлгийн агуулга, ёс бус хэллэг, аюултай үйлдэл, сэтгэл зүйн дарамт зэрэг контент хүүхдэд шууд хүрэх эрсдэл өндөр гэж оролцогчид үзэж байна.

Түүнчлэн энэхүү үр дүн нь хүүхдийн цахим хамгаалалтын асуудал зөвхөн статик контент бус бодит цагийн харилцаа, шууд дамжуулалтын орчны зохицуулалтыг хамрах шаардлагатай болсныг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг “real-time content safety” буюу бодит цагийн хамгаалалтын түвшинд авч үзэх шаардлагатайг илэрхийлж байна.

**15.10 Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу? [Бүртгэлд 2 шатлалт нэвтрэлт (2FA) идэвхжүүлэх]**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	624	93.1%
Үгүй	46	6.9%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 93.1 хувь нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор бүртгэлд 2 шатлалт нэвтрэлт (2FA)-ийг анхдагчаар автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим хаяг, хувийн мэдээлэл, аккаунтын аюулгүй байдал нь цахим хамгааллын үндсэн асуудал болсон гэж олон нийт үзэж байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим орчин дахь эрсдэл зөвхөн контентын түвшинд бус аккаунт хакердуулах, зөвшөөрөлгүй нэвтрэх, хувийн мэдээлэл алдагдах, цахим залилан, хуурамч дүр эсгэлт зэрэг кибер аюулгүй байдлын эрсдэлийг хамарч байгааг илэрхийлж байна. Ялангуяа хүүхдүүд нууц үг хамгаалалт, аюулгүй байдлын тохиргооны талаарх мэдлэг, дадал хангалтгүй байдаг тул платформын түвшинд урьдчилан хамгаалалт шаардлагатай гэж оролцогчид үзэж байна.

Мөн энэхүү үзүүлэлт нь хүүхдийн цахим аюулгүй байдлын асуудалд “cybersecurity by default” буюу кибер хамгаалалтын анхдагч стандарт хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн хандлага давамгайлж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн аккаунтыг энгийн хэрэглэгчийн түвшнээс илүү хамгаалалттай горимд байлгах нь хүүхэд хамгааллын үндсэн механизм байх ёстой гэж үзэж байна.

**15-р асуултын нэгдсэн дүгнэлт**

15-р асуулгын хүрээнд оролцогчдоос хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор платформын түвшинд анхдагч (default) хамгаалалтын тохиргоонуудыг автоматаар идэвхжүүлэх шаардлагатай эсэх талаар тодруулсан бөгөөд бүх үзүүлэлт дээр маш өндөр түвшний дэмжлэг илэрсэн байна. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 82.2–97.5 хувь нь хүүхдийн цахим орчинд хамгаалалтын default тохиргоо заавал байх шаардлагатай гэж үзжээ.

Ялангуяа ёс бус үг хэллэгтэй коммент устгах болон насанд хүрэгчдийн агуулга, сэтгэл зүйн дарамт үүсгэх контентыг хязгаарлах тохиргоог 97.5 хувь нь дэмжсэн нь хүүхдийн цахим орчны хамгийн том эрсдэл нь хортой контент, цахим дээрэлхэлт, сэтгэл зүйн дарамт гэж олон нийт үзэж байгааг харуулж байна. Мөн дэлгэц ашиглалтын хугацааг

хязгаарлах (96.0%), донтох зан төлөв өдөөсөн богино видео хязгаарлах (96.1%), шөнийн хэрэглээг хязгаарлах (95.5%) зэрэг үзүүлэлтүүд өндөр хувьтай гарсан нь хүүхдийн цахим хэрэглээний хэтрэлт, донтох шинжтэй хэрэглээ нь нийгмийн хэмжээнд бодит асуудал болсон болохыг илэрхийлж байна.

Түүнчлэн хувийн хаягийг “private” байлгах (95.4%), танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах (95.5%), 2 шатлалт нэвтрэлт идэвхжүүлэх (93.1%), байршил хуваалцахыг унтраах (82.2%) зэрэг үр дүн нь хүүхдийн хувийн мэдээлэл хамгаалалт, кибер аюулгүй байдал, танихгүй хэрэглэгчтэй харилцах эрсдэлийг бууруулах асуудалд олон нийт өндөр ач холбогдол өгч байгааг харуулж байна.

Мөн хүүхдийн насанд тохироогүй live/stream контентыг хязгаарлахыг 96.4 хувь нь дэмжсэн нь бодит цагийн контент, шууд харилцаанд суурилсан платформууд хүүхдийн аюулгүй байдалд шинэ төрлийн эрсдэл үүсгэж байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим хамгаалалт зөвхөн статик контент бус алгоритм, шууд дамжуулалт, хэрэглэгчийн харилцааны архитектурыг хамрах шаардлагатай болсныг илэрхийлж байна.

Эдгээр үр дүнг нэгтгэн үзвэл оролцогчид хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг зөвхөн хэрэглэгчийн сонголт, эцэг эхийн хяналтад даатгах бус платформын түвшинд автоматаар хамгаалсан орчин (“safety by default”, “privacy by default”) бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн хамгаалалт нь платформын үндсэн дизайн, алгоритм, тохиргооны бодлогын салшгүй хэсэг байх ёстой гэсэн нийгмийн хандлага давамгайлж байна.

**16. Нийгмийн сүлжээний алгоритм нь хүүхдийг донтуулах, хэт удаан хугацаагаар ашиглахад нөлөөлдөг гэж та үзэж байна уу?**

Хариулт	Давтамж	Хувь
Маш их нөлөөлдөг	456	68.1%
Нөлөөлдөг	184	27.5%
Дунд зэрэг	21	3.1%
Бага нөлөөлдөг	7	1.0%
Огт нөлөөлдөггүй	2	0.3%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 68.1 хувь нь нийгмийн сүлжээний алгоритм хүүхдийг донтуулах, хэт удаан хугацаагаар ашиглахад “маш их нөлөөлдөг”, 27.5 хувь нь “нөлөөлдөг” гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл нийт оролцогчдын 95.6 хувь нь алгоритмын нөлөөлөл хүүхдийн цахим хэрэглээний хэтрэлт, донтох зан төлөвт бодитой нөлөө үзүүлж байна гэж үзжээ.

Энэхүү үр дүн нь хүүхдийн цахим орчны эрсдэл зөвхөн контентын асуудал бус платформын алгоритм, хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөх технологийн дизайнтай шууд холбоотой болсон болохыг харуулж байна. Ялангуяа богино видео, endless feed, autoplay, personalized recommendation зэрэг алгоритмд суурилсан функцууд нь хүүхдийн анхаарлыг удаан хугацаагаар татах, хэрэглээг тасралтгүй үргэлжлүүлэх зорилготой ажилладаг гэж олон нийт үзэж байгааг илэрхийлж байна.

Түүнчлэн алгоритмын нөлөөллийг өндөр гэж үнэлсэн нь хүүхдийн сэтгэл зүй, анхаарал төвлөрөл, цагийн хэрэглээ, нийгмийн харилцаанд технологийн платформууд системтэй нөлөө үзүүлж байгааг олон нийт анзаарч байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим хамгааллын асуудалд “algorithmic accountability” буюу алгоритмын хариуцлагын асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай болсныг илэрхийлж байна.

**17. Хортой контентыг устгах хугацааг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна уу?**

Хариулт	Давтамж	Хувь
Тийм	663	99.0%
Үгүй	7	1.0%

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын бараг бүхэлдээ буюу 99.0 хувь нь хортой контентыг устгах хугацааг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлын асуудалд платформын хариуцлага, төрийн зохицуулалт, шуурхай хамгаалалтын механизм нэн шаардлагатай болсон гэсэн маш өндөр түвшний нийгмийн зөвшилцөл бүрдсэнийг харуулж байна.

Энэхүү үр дүн нь өмнөх асуултуудад өндөр хувьтай гарсан цахим дээрэлхэлт, сэтгэл зүйн дарамт, ёс бус хэллэг, насанд тохироогүй контент, live/stream эрсдэл, донтох контент зэрэг асуудлуудтай шууд холбоотой байна. Өөрөөр хэлбэл оролцогчид хортой контентыг зөвхөн мэдээлэх боломжтой байх нь хангалтгүй бөгөөд түүнийг тодорхой хугацаанд заавал устгах, хязгаарлах эрх зүйн үүрэг платформуудад байх ёстой гэж үзэж байгааг илэрхийлж байна.

Мөн хортой контентын тархалт хүүхдийн сэтгэл зүй, нэр төр, аюулгүй байдалд богино хугацаанд ч ноцтой нөлөө үзүүлж болзошгүй тул хариу арга хэмжээ удаашрах нь өөрөө эрсдэл болдог гэж олон нийт үзэж байгааг харуулж байна. Ялангуяа цахим орчин дахь контент маш хурдан тархдаг онцлогтой тул хүүхэдтэй холбоотой хортой агуулгад “time-sensitive protection” буюу хугацаанд суурилсан хамгаалалтын механизм шаардлагатай болжээ.

**Хоёр.НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Энэхүү судалгаанд нийт 670 оролцогч хамрагдсан бөгөөд багш, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүд оролцсон нь хүүхдийн өдөр тутмын орчин, зан төлөв, цахим хэрэглээтэй хамгийн ойр ажилладаг мэргэжлийн бүлгийн үнэлгээ гэдгээрээ онцлог ач холбогдолтой байна. Судалгаанд оролцогчид Монгол Улсын олон аймаг, нийслэлийг хамарсан нь уг судалгааг улсын хэмжээний бодлогын түвшний тандан судалгааны шинжтэй болохыг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн цахим орчин дахь эрсдэл нь бодитой бөгөөд боловсрол, сэтгэл зүй, зан төлөв, нийгмийн харилцаа, эрүүл мэндэд нөлөөлөх хэмжээнд хүрсэн байна. Тухайлбал оролцогчид цахим дээрэлхэлт, хортой контент, танихгүй хүнээс ирсэн мессеж, бэлгийн шинжтэй дарамт, цахим залилан зэрэг эрсдэлүүд хүүхдүүдэд түгээмэл тохиолдож байгааг онцолсон бөгөөд үүний үр дагаварт зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн шинж тэмдэг, цахим хэрэглээтэй холбоотой донтолт, сургалтын үзүүлэлтийн бууралт ажиглагдаж байгааг тэмдэглэсэн байна.

Мөн хүүхдийн хамгийн түгээмэл ашиглаж буй платформууд нь Facebook, Instagram, TikTok, YouTube болон онлайн тоглоомын платформууд байгаа нь алгоритмд суурилсан, донтох шинжтэй контент давамгайлсан орчин хүүхдийн өдөр тутмын амьдралын нэг хэсэг болсныг харуулж байна. Судалгаанд оролцогчдын 95.6 хувь нь нийгмийн сүлжээний алгоритм хүүхдийг донтуулах, хэт удаан хугацаагаар ашиглахад нөлөөлдөг гэж үзсэн нь платформын алгоритмын нөлөөлөл хүүхдийн эрх, эрүүл хөгжилтэй холбоотой бодлогын асуудал болсон болохыг нотолж байна.

Түүнчлэн оролцогчид хүүхдийн насны онцлогт тохирсон шаталсан хэрэглээний зохицуулалт шаардлагатай гэж үзэж байгаа нь харагдсан. Ялангуяа бага насны хүүхдийг цахим сүлжээнд огт ашиглуулахгүй эсхүл хатуу хязгаарлалттай ашиглуулах шаардлагатай гэсэн байр суурь давамгайлж байгаа бол өсвөр насны хүүхдүүдийн хувьд чөлөөт хэрэглээнээс илүү хяналттай, хамгаалалттай хэрэглээг дэмжсэн байна. Энэ нь хүүхдийн нас, хөгжлийн онцлогт суурилсан тусгайлсан эрх зүйн зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

Судалгааны хамгийн чухал үр дүнгийн нэг нь хүүхдийн хамгаалалтын “default” буюу анхдагч тохиргоог платформын түвшинд автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэсэн маш өндөр түвшний нийгмийн зөвшилцөл бүрдсэн явдал юм. Оролцогчдын дийлэнх нь хүүхдийн аккаунтыг “private” байлгах, танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах, байршил хуваалцахыг унтраах, дэлгэц ашиглалтын хугацааг хязгаарлах, шөнийн хэрэглээг хаах, донтох богино видео болон насанд хүрэгчдийн контентыг шүүх, live/stream хязгаарлах, 2 шатлалт нэвтрэлт идэвхжүүлэх зэрэг хамгаалалтын механизмыг платформууд автоматаар хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхэд хамгааллыг зөвхөн

хэрэглэгчийн сонголтод үлдээх бус “safety by default”, “privacy by default” зарчимд суурилсан зохицуулалт шаардлагатайг тодорхой харуулж байна.

Мөн оролцогчдын 99 хувь нь хортой контентыг устгах хугацааг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзсэн нь платформуудын сайн дурын бодлого хангалтгүй бөгөөд төрөөс платформын үүрэг, хугацаа, хариуцлагыг хуульчилж өгөх шаардлагатай гэсэн маш өндөр түвшний нийгмийн шаардлага үүссэнийг илэрхийлж байна.

Ийнхүү судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхдийн цахим орчны асуудал нь зөвхөн технологийн хэрэглээний асуудал бус хүүхдийн эрх, сэтгэл зүй, боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, платформын алгоритмын зохицуулалттай холбоотой цогц асуудал болсон байна. Иймд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах зорилготой “Цахим орчинд хүүхэд хамгаалах тухай” бие даасан хууль эрх зүйн зохицуулалт боловсруулах хэрэгцээ, шаардлага өндөр түвшинд бий болсон гэж үзэх үндэслэлтэй байна.

### **Гурав.БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ**

#### 1. “Цахим орчинд хүүхэд хамгаалах тухай” бие даасан хууль батлах

Хүүхдийн цахим орчны эрсдэл нь хүүхэд хамгааллын бие даасан бодлогын асуудал болсон тул хүүхдийн эрх, аюулгүй байдал, мэдээлэл хамгаалалт, платформын хариуцлага, алгоритмын зохицуулалтыг хамарсан тусгайлсан хууль батлах шаардлагатай байна.

#### 2. Насны ангилалд суурилсан зохицуулалт бий болгох

- Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон шаталсан хэрэглээний зохицуулалт бий болгох;
- Бага насны хүүхдийн цахим сүлжээний хэрэглээнд хатуу хамгаалалт, хязгаарлалт тогтоох;
- Нас баталгаажуулалтын системийг платформуудад заавал хэрэгжүүлэх;
- Насанд хүрээгүй хэрэглэгчийн аккаунтыг default байдлаар хамгаалалттай горимд ажиллуулах шаардлага тогтоох.

#### 3. “Safety by default” болон “Privacy by default” зарчмыг хуульчлах

Платформууд хүүхдийн хамгаалалтын үндсэн тохиргоог автоматаар идэвхжүүлэх үүрэгтэй байх шаардлагатай. Үүнд:

- Хувийн хаягийг private байлгах;
- Танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах;
- Байршил хуваалцахыг автоматаар унтраах;
- Ёс бус коммент, дарамт, хүчирхийллийн агуулгыг автоматаар шүүх;
- Шөнийн хэрэглээ болон дэлгэцийн хугацаанд хязгаарлалт хийх;
- Донтох богино видео, autoplay, endless feed зэрэг функцийг хүүхдийн аккаунтад хязгаарлах;

- 2 шатлалт нэвтрэлтийг default байдлаар идэвхжүүлэх шаардлагатай.

#### 4. Алгоритмын хариуцлагын зохицуулалт бий болгох

- Донтох зан төлөв өдөөсөн алгоритм, контент түгээлтийн механизмыг хязгаарлах;
- Хүүхдийн сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлэх контентын санал болголтод хяналт тавих;
- “Digital wellbeing” хамгаалалтын функцуудыг заавал хэрэгжүүлэх шаардлагатай.

#### 5. Хортой контентыг устгах хугацааг хуульчлах

- Хүүхэдтэй холбоотой хортой контентыг мэдээлсэн тохиолдолд тодорхой хугацаанд заавал устгах;
- Хүүхдийн эсрэг бэлгийн агуулга, хүчирхийлэл, цахим дээрэлхэлт, амиа хорлолтыг өдөөсөн контентод шуурхай арга хэмжээ авах;
- Хугацаанд нь устгаагүй платформд хариуцлага тооцох;
- Контент мэдээлэх, шийдвэрлэх үндэсний шуурхай тогтолцоо байгуулах шаардлагатай.

#### 6. Боловсролын байгууллагын үүргийг тодорхой болгох

- Сургуулиудад цахим аюулгүй байдлын дотоод журам заавал мөрдүүлэх;
- Хүүхэд, эцэг эх, багшид зориулсан цахим аюулгүй байдлын сургалтыг тогтмол хэрэгжүүлэх;
- Сургуулийн хүүхэд хамгааллын багт цахим орчны эрсдэлийн чиг үүрэг тусгайлан хариуцуулах;
- Хүүхдийн сэтгэл зүй, цахим донтох хэрэглээ, цахим дарамтыг эрт илрүүлэх аргачлал нэвтрүүлэх шаардлагатай.

#### 7. Эцэг эхийн оролцоог дэмжих бодлого хэрэгжүүлэх

- Эцэг эхэд зориулсан үндэсний хэмжээний цахим боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Parental control хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх;
- Эцэг эхийн хүүхдийн цахим хэрэглээнд тавих үүрэг, оролцоог хуульчлах шаардлагатай.

#### 8. Хүүхдийн кибер аюулгүй байдал, мэдээлэл хамгааллыг тусгайлан зохицуулах

- Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээхэд тусгай хамгаалалт тогтоох;
- Хүүхдийн аккаунтын мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хуульчлах;
- Кибер халдлага, хуурамч аккаунт, цахим залилангаас хамгаалах механизмыг сайжруулах шаардлагатай.

## 9. Хяналт, зохицуулалтын үндэсний тогтолцоо бий болгох

- Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын асуудал хариуцсан үндэсний зохицуулах байгууллага эсхүл салбар дундын нэгж байгуулах;
- Платформуудын хүүхэд хамгааллын хэрэгжилтэд хяналт тавих;
- Судалгаа, мониторинг, үнэлгээний тогтолцоог тогтмолжуулах шаардлагатай байна.

Нэгдсэн дүгнэлт:

Судалгааны үр дүн нь Монгол Улсад хүүхдийн цахим орчны эрсдэл бодитойгоор нэмэгдэж, хүүхдийн эрх, сэтгэл зүй, боловсрол, эрүүл мэндэд нөлөөлөх хэмжээнд хүрсэнийг харуулж байна. Түүнчлэн хүүхдийн хамгаалалтын асуудал нь зөвхөн хувь хүний хэрэглээний асуудал бус платформын алгоритм, технологийн дизайн, контентын бодлого, мэдээллийн аюулгүй байдал, төрийн зохицуулалттай холбоотой цогц асуудал болсон байна.

Иймд “Цахим орчинд хүүхэд хамгаалах тухай” тусгайлсан хууль батлах нь хүүхдийн эрх ашгийг хамгаалах, платформын хариуцлагыг тодорхой болгох, урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх, хүүхдийн аюулгүй, эрүүл цахим орчныг бий болгох бодит хэрэгцээ, шаардлага мөн гэж үзэхээр байна.

### **"Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай" хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааны асуумж**

#### **/ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД ЗОРИУЛСАН ХУВИЛБАР/**

Энэхүү судалгааны зорилго нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, нийгмийн сүлжээний хэрэглээ болон зохицуулалт, эцэг эхийн оролцоо, хүүхдийн эрхийн хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, хандлага, мэдлэгийн түвшинг тодорхойлоход оршино.

Судалгаанд өгсөн мэдээллийг зөвхөн судалгааны болон бодлого боловсруулах зорилгоор ашиглах бөгөөд оролцогчийн хувийн мэдээллийг нууцлан хадгалж, гуравдагч этгээдэд задруулахгүй болно.

## **I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

1. Таны нас:

18–25

26–35

- 36–45
- 46 ба түүнээс дээш

2. Таны хүүхэд өдөрт дунджаар хэдэн цагийг цахим платформ ашиглахад зарцуулж байна вэ?

- 1 цагаас бага
- 1–3 цаг
- 3–5 цаг
- 5–8 цаг
- 8 цагаас дээш
- Мэдэхгүй

3. Таны хүүхдийн хамгийн их ашигладаг платформ юу вэ? /олон сонголттой/

- Facebook
- Instagram
- TikTok
- YouTube
- Snapchat
- Threads
- NGL
- Discord
- X /Twitter/
- Онлайн тоглоомын платформ
- Мэдэхгүй
- Бусад: \_\_\_\_\_

4. Таны хүүхэд дараах эрсдэлтэй тулгарч байсан уу? /олон сонголттой/

- Цахим дээрэлхэлт
- Хортой агуулга бүхий контент
- Цахим залилан
- Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт
- Тулгарч байгаагүй
- Мэдэхгүй

## II. ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ОРОЛЦОО

5. Та хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьдаг уу?

- Тогтмол
- Заримдаа
- Ховор
- Хяналт тавидаггүй

6. Хүүхдийн цахим хэрэглээнд хяналт тавихад танд хамгийн их тулгардаг хүндрэл юу вэ?

- Цаг зав хүрэлцдэггүй
- Хяналт шаардлагагүй гэж боддог

- Хүүхэд эсэргүүцдэг
- Ямар эрсдэлтэйг сайн мэддэггүй
- Хяналтын хэрэгсэл ашиглаж чаддаггүй
- Бусад: \_\_\_\_\_

7. Хүүхдийн цахим хэрэглээг хянахдаа хүүхдийн хувийн орон зайг хүндэтгэх нь зүйтэй гэж үзэж байна уу?

- Тийм
- Үгүй

### III. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

8. Дараах насны ангилалд цахим сүлжээний хэрэглээг ямар түвшинд зөвшөөрөх нь тохиромжтой вэ?

Насны ангилал	Сошиал ашиглуулахгүй	Хязгаарлагдмал ашиглуулах	Эцэг эхийн хяналттай ашиглуулах	Чөлөөтэй ашиглуулах
08–10 нас	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
11–12 нас	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
13–15 нас	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
16-аас дээш	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>

9. Эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн цахим хэрэглээнд зохистой хяналт тавих замаар цахим орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй гэж та үзэж байна уу?

- Тийм
- Үгүй

10. Хүүхдийг нас, хөгжлийн онцлогт нь тохироогүй, хортой контентоос хамгаалах зорилгоор цахим орчин дахь тодорхой контентод хязгаарлалт тавих шаардлагатай гэж та үзэж байна уу?

- Тийм
- Үгүй

11. Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах тохиргоонуудыг анхнаас нь (default) автоматаар идэвхжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна уу?

Тохиргоо	Тийм	Үгүй
Хувийн хаягийн нууцлал (profile private байх)	<input type="radio"/>	<input type="radio"/>
Танихгүй хүнээс мессеж хүлээн авахыг хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Байршил (location) хуваалцахыг унтраах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Ёс бус үг хэллэг ашигласан коммент устгах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Шөнийн хэрэглээг хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>

Дэлгэц ашиглалтын хугацааны хязгаар (screen time limit)	<input type="radio"/>	<input type="radio"/>
Донтох зан төлөв өдөөсөн богино видеог хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Насанд хүрэгчдийн агуулга, сэтгэл зүйн дарамт, сөрөг зан төлөвтэй холбоотой контентыг хязгаарлах	<input type="radio"/>	<input type="radio"/>
Хүүхдийн насанд тохиромжгүй live/stream	<input type="radio"/>	<input type="radio"/>
Бүртгэлд 2 шатлалт нэвтрэлт (2FA) идэвхжүүлэх	<input type="radio"/>	<input type="radio"/>

12. Хортой контентыг устгах хугацааг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна уу?

- Тийм
- Үгүй

13. Нийгмийн сүлжээний алгоритм хүүхдийг донтуулж, хэт удаан ашиглахад нөл өөлдөг

гэж үзэж байна уу?

- Маш их нөлөөлдөг
- Нөлөөлдөг
- Дунд зэрэг
- Бага нөлөөлдөг
- Огт нөлөөлдөггүй

**"Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай" хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааны асуумжын дүн шинжилгээ**

**Судалгааны зорилго:** Энэхүү судалгааны зорилго нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, нийгмийн сүлжээний хэрэглээ болон зохицуулалт, эцэг эхийн оролцоо, хүүхдийн эрхийн хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, хандлага, мэдлэгийн түвшинг тодорхойлоход оршино.

Судалгааны ерөнхий үзүүлэлт: Нийт оролцогчдын тоо: 3102

### **1. Судалгаанд оролцогчдын бүсчилсэн тархалт**

Судалгаанд оролцогчдыг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн ангиллаар нэгтгэн авч үзвэл дараах байдалтай байна.  
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140840374051&show>

<b>Бүс</b>	<b>Хамрагдсан аймаг, хот</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>
Улаанбаатар	Улаанбаатар хот	251	8.1%
Төвийн бүс	Сэлэнгэ, Дархан-Уул, Төв	1,017	32.8%
Баруун бүс	Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий	952	30.7%
Зүүн бүс	Хэнтий, Дорнод, Сүхбаатар	381	12.3%
Хангайн бүс	Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл	137	4.4%
Говийн бүс	Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр	66	2.1%
Хариулаагүй	—	297	9.6%
<b>Нийт</b>		<b>3,101</b>	<b>100%</b>

Судалгааны бүсчилсэн тархалтаас харахад Төвийн бүс (32.8%) болон Баруун бүс (30.7%) хамгийн өндөр оролцоотой байгаа бөгөөд нийт оролцогчдын 63.5 хувийг бүрдүүлж байна. Энэ нь судалгааны мэдээлэл түгээлт, хамрагдалт эдгээр бүсэд илүү идэвхтэй явагдсан болохыг харуулж байна.

Баруун болон төвийн бүсэд цахим хэрэглээ өндөр байгаатай уялдан цахим орчны эрсдэлийн талаарх сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Харин Говийн бүс (2.1%), Хангайн бүс (4.4%) болон Улаанбаатар хотын оролцоо харьцангуй бага байгаа нь бүс хоорондын төлөөллийн тэнцвэрт байдалд тодорхой хэмжээнд нөлөөлж болзошгүй байна.

Зүүн бүсийн оролцоо 12.3 хувь байгаа нь цахим орчны хэрэглээ, хүүхдийн цахим аюулгүй байдлын асуудал зөвхөн төвлөрсөн бүсүүдэд бус хилийн болон алслагдсан аймгуудад ч мөн адил хамааралтай асуудал болсныг илтгэж байна.

Судалгаанд нийслэл болон 21 аймгийн төлөөлөл хамрагдсан нь хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын асуудал нь улсын хэмжээнд нийтлэг тулгамдсан асуудал болсныг илтгэж байна. Түүнчлэн орон нутгийн оролцоо өндөр байгаа нь хөдөө, орон нутагт ч хүүхдийн цахим хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, цахим орчны эрсдэл бодитой тулгарч байгааг харуулж байна.

## **2. Таны нас:**

<b>Хариулт</b>	<b>Давамж</b>	<b>Хувь</b>
----------------	---------------	-------------

36–45	1514	48.8%
26–35	905	29.2%
46 ба түүнээс дээш	593	19.1%
18–25	90	2.9%

**3. Таны хүүхэд өдөрт дунджаар хэдэн цагийг цахим орчимд зарцуулж байна вэ?**

Хариулт	Давтамж	Хувь
1–3 цаг	1166	37.6%
3–5 цаг	914	29.5%
5–8 цаг	418	13.5%
1 цагаас бага	379	12.2%
8 цагаас дээш	116	3.7%
Мэдэхгүй	109	3.5%

Судалгааны үр дүнгээс харахад нийт оролцогчдын 37.6 хувь нь хүүхэд өдөрт дунджаар 1–3 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг гэж хариулсан бол 29.5 хувь нь 3–5 цаг зарцуулдаг гэжээ. Өөрөөр хэлбэл нийт хүүхдийн 67.1 хувь нь өдөрт 1–5 цагийг цахим орчинд өнгөрүүлж байгаа нь цахим хэрэглээ хүүхдийн өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон болохыг харуулж байна.

Анхаарал татахуйц үзүүлэлт нь нийт хүүхдийн 17.2 хувь нь өдөрт 5 цагаас дээш хугацааг цахим орчинд өнгөрүүлдэг гэж хариулсан явдал юм. Үүнээс 3.7 хувь нь 8 цагаас дээш хугацаанд цахим хэрэглээтэй байгаа нь хэт хэрэглээ, донтох зан төлөв, сэтгэл зүйн болон бие махбодын эрсдэл үүсэх магадлалтайг илтгэж байна.

Харин 12.2 хувь нь 1 цагаас бага хэрэглэдэг гэж хариулсан нь зарим өрхүүдэд эцэг эхийн хяналт, хэрэглээний зохицуулалт харьцангуй сайн байж болзошгүйг харуулж байна. Мөн 3.5 хувь нь хүүхдийнхээ хэрэглээний хугацааг мэдэхгүй гэж хариулсан нь эцэг эхийн хяналт, оролцоо сул байгааг илтгэх үзүүлэлт гэж үзэж болно.

**4. Таны хүүхдийн хамгийн их ашигладаг платформ юу вэ? /олон сонголттой/**

Платформ	Давтамж	Хувь
YouTube	1922	62.0%
Facebook	1510	48.7%

TikTok	856	27.6%
Instagram	780	25.1%
Онлайн тоглоомын платформ	709	22.9%
Мэдэхгүй	165	5.3%
Snapchat	80	2.6%
Threads	25	0.8%
Discord	18	0.6%
NGL	12	0.4%
X /Twitter/	12	0.4%
Бусад платформууд	<1%	—

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүдийн хамгийн өргөн хэрэглэдэг платформ нь YouTube бөгөөд нийт оролцогчдын 62.0 хувь нь хүүхдээ энэ платформыг ашигладаг гэж хариулсан байна. Энэ нь видео контент төвтэй хэрэглээ хүүхдийн өдөр тутмын цахим хэрэглээнд давамгайлж байгааг харуулж байна. YouTube нь боловсролын болон танин мэдэхүйн агуулга түгээх боломжтой хэдий ч алгоритмд суурилсан контент санал болголт нь хүүхдийг насанд тохироогүй, хэт өдөөгч, донтуулах агуулгад өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Facebook платформ 48.7 хувийн хэрэглээтэй байгаа нь Монгол Улсад Facebook-ийн хэрэглээ гэр бүлийн орчин болон хүүхдийн хэрэглээнд өндөр хэвээр байгааг илтгэж байна. Гэвч Facebook орчинд хуурамч мэдээлэл, цахим дарамт, танихгүй хэрэглэгчтэй харилцах эрсдэл түгээмэл байдаг тул хүүхэд хамгааллын тусгай зохицуулалт шаардлагатай байна.

TikTok (27.6%) болон Instagram (25.1%) платформуудын хэрэглээ өндөр байгаа нь богино бичлэг, алгоритмд суурилсан контентын хэрэглээ хүүхдийн дунд эрчимтэй нэмэгдсэнийг харуулж байна. Эдгээр платформууд нь:

- анхаарал төвлөрөл бууруулах,
- донтох хэв шинж үүсгэх,
- биеийн дүр төрхийн дарамт,
- насанд хүрэгчдийн агуулгад өртөх,
- trend/challenge эрсдэл үүсгэх магадлал өндөртэй платформуудад тооцогддог.

Онлайн тоглоомын платформын хэрэглээ 22.9 хувь байгаа нь хүүхдүүдийн цахим хэрэглээ зөвхөн социал сүлжээгээр хязгаарлагдахгүй, тоглоомын орчинд ч төвлөрч байгааг харуулж байна. Судалгаанд Roblox, Mobile Legends, Standoff зэрэг тоглоомын нэр дурдагдсан нь multiplayer буюу олон хэрэглэгчтэй харилцах тоглоомын хэрэглээ түгээмэл байгааг илтгэж байна. Энэ төрлийн платформ нь:

- цахим дарамт,

- танихгүй хүнтэй харилцах,
- мөнгө зарцуулах шахалт,
- хүчирхийллийн агуулга,
- донтох эрсдэл үүсгэх магадлалтай.

Мөн Discord, Snapchat, NGL зэрэг платформуудын хэрэглээ бага хувьтай боловч аноним харилцаа, хувийн мэдээллийн эрсдэл, хяналт сул орчин байдгаараа хүүхэд хамгааллын хувьд өндөр эрсдэлтэй платформд тооцогддог.

Анхаарал татахуйц нэг үзүүлэлт нь 5.3 хувь нь хүүхдийнхээ ашигладаг платформыг мэдэхгүй гэж хариулсан явдал бөгөөд энэ нь эцэг эхийн дижитал оролцоо, хяналтын түвшин хангалтгүй байгааг илтгэж байна.

**5. Таны хүүхэд дараах эрсдэлтэй тулгарч байсан уу? /олон сонголттой/**

Эрсдэлийн төрөл	Давтамж	Хувь
Тулгарч байгаагүй	1642	52.9%
Мэдэхгүй	807	26.0%
Хортой агуулга бүхий контент	228	7.4%
Танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлт	110	3.5%
Хортой контент + танихгүй хүний хүсэлт	60	1.9%
Цахим залилан	31	1.0%
Цахим дээрэлхэлт	31	1.0%
Олон төрлийн хавсарсан эрсдэлүүд	100+	~3–4%

Судалгааны үр дүнгээс харахад нийт оролцогчдын 52.9 хувь нь хүүхэд нь цахим орчинд ямар нэгэн эрсдэлтэй тулгарч байгаагүй гэж хариулсан байна. Гэвч үүний зэрэгцээ 26.0 хувь нь “мэдэхгүй” гэж хариулсан нь анхаарал татахуйц өндөр үзүүлэлт юм. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн цахим орчны бодит хэрэглээ, тулгарч буй эрсдэлийн талаар хангалттай мэдээлэлгүй, хяналт сул байж болзошгүйг илтгэж байна.

Эрсдэлийн төрлөөс авч үзвэл хамгийн түгээмэл нь хортой агуулга бүхий контент (7.4%) байна. Үүнд:

- хүчирхийлэл,
- насанд хүрэгчдийн агуулга,
- айдас, түгшүүр төрүүлэх контент,
- донтох шинжтэй богино бичлэг,
- сөрөг зан үйл сурталчилсан агуулга хамаарах боломжтой бөгөөд энэ нь алгоритмд суурилсан платформууд хүүхдэд эрсдэлтэй контент санал болгож буйг харуулж байна.

Мөн 3.5 хувь нь танихгүй хүнээс ирсэн мессеж, хүсэлттэй тулгарч байсан гэж хариулсан нь хүүхэд цахим орчинд танихгүй этгээдтэй харилцах, grooming буюу итгэл олж ойртох замаар хүүхэд рүү чиглэсэн эрсдэлд өртөх боломж байгааг илтгэж байна.

Цахим дээрэлхэлт (1.0%) болон цахим залилан (1.0%) нь тоон дүнгээр харьцангуй бага мэт харагдаж байгаа боловч эдгээр нь хүүхдийн сэтгэл зүй, аюулгүй байдалд өндөр хор нөлөөтэй эрсдэлүүд юм. Түүнчлэн олон эрсдэл хавсарсан байдлаар илэрсэн хариултууд байгаа нь хүүхэд нэгэн зэрэг:

- хортой контент,
- цахим дарамт,
- залилан,
- танихгүй хүнтэй харилцах эрсдэл зэрэг олон талт аюулд өртөж байгааг харуулж байна.

Анхаарал татах нэг асуудал нь зарим оролцогч “тулгарч байгаагүй” болон тодорхой эрсдэлийг хамтад нь сонгосон байна. Энэ нь:

- асуулгын ойлгомж,
- эрсдэлийг таних чадвар,
- эцэг эхийн мэдлэгийн түвшин хангалтгүй байж болзошгүйг илтгэнэ.

## **6. Та хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьдаг уу?**

<b>Хариулт</b>	<b>Давтамж</b>	<b>Хувь</b>
Заримдаа	1604	51.7%
Тогтмол	1063	34.3%
Ховор	312	10.1%
Хяналт тавьдаггүй	123	4.0%
<b>Нийт</b>	<b>3102</b>	<b>100%</b>

Судалгааны үр дүнгээс харахад нийт оролцогчдын 51.7 хувь нь хүүхдийн цахим хэрэглээнд “заримдаа” хяналт тавьдаг гэж хариулсан бөгөөд энэ нь эцэг эхийн хяналт тогтмол бус, нөхцөл байдлаас хамаарсан шинжтэй байгааг илтгэж байна.

Харин 34.3 хувь нь тогтмол хяналт тавьдаг гэж хариулсан нь нийт оролцогчдын гуравны нэг орчим нь хүүхдийн цахим орчны хэрэглээнд идэвхтэй оролцож байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн цахим аюулгүй байдлыг хамгаалахад эцэг эхийн оролцоо чухал байгааг олон нийт ойлгож эхэлснийг илтгэх эерэг үзүүлэлт гэж үзэж болно.

Гэсэн хэдий ч нийт оролцогчдын 14.1 хувь нь “ховор” эсвэл “огт хяналт тавьдаггүй” гэж хариулсан нь анхаарал татахуйц үзүүлэлт юм. Энэ нь тодорхой бүлгийн хүүхдүүд:

- насанд тохироогүй контент,
- цахим дарамт,
- танихгүй хүнтэй харилцах,
- донтох хэрэглээ,
- онлайн залилан зэрэг эрсдэлд эцэг эхийн хяналтгүйгээр өртөх магадлалтайг харуулж байна.

Түүнчлэн өмнөх асуултын үр дүнтэй уялдуулан үзвэл оролцогчдын 26 хувь нь хүүхэд нь ямар эрсдэлтэй тулгарсныг “мэдэхгүй” гэж хариулсан нь цахим хэрэглээнд тавих хяналт, ойлголт хоёрын хооронд зөрүү байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл эцэг эхчүүд өөрсдийгөө хяналт тавьдаг гэж үздэг боловч хүүхдийн бодит цахим орчны үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэлгүй байх нөхцөл ажиглагдаж байна.

**7. Хүүхдийн цахим хэрэглээнд хяналт тавих явцад танд хамгийн их тулгардаг хүндрэл юу вэ? /олон сонголттой/**

Хүндрэл	Давтамж	Хувь
Цаг зав хүрэлцдэггүй	893	28.8%
Хяналтын хэрэгсэл ашиглаж чаддаггүй	493	15.9%
Хүүхэд эсэргүүцдэг	460	14.8%
Хяналт шаардлагагүй гэж боддог	283	9.1%
Ямар эрсдэлтэйг сайн мэддэггүй	169	5.4%
Цаг зав хүрэлцдэггүй + Хяналтын хэрэгсэл ашиглаж чаддаггүй	124	4.0%
Цаг зав хүрэлцдэггүй + Хүүхэд эсэргүүцдэг	97	3.1%
Хүүхэд эсэргүүцдэг + Хяналтын хэрэгсэл ашиглаж чаддаггүй	76	2.5%
Бусад хавсарсан хүндрэлүүд	~15%	—

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн цахим хэрэглээнд хяналт тавихад тулгарч буй хамгийн түгээмэл хүндрэл нь “цаг зав хүрэлцдэггүй” (28.8%) гэсэн хариулт байна. Энэ нь орчин үеийн гэр бүлүүдийн ажил, амьдралын ачаалал нэмэгдэж, эцэг эх хүүхдийн цахим орчин дахь үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Хоёр дахь түгээмэл хүндрэл нь “хяналтын хэрэгсэл ашиглаж чаддаггүй” (15.9%) гэсэн үзүүлэлт бөгөөд энэ нь эцэг эхчүүдийн технологийн мэдлэг, дижитал ур чадвар хангалтгүй байгааг илтгэж байна. Судалгаанд:

- “утас нь кодтой”,
- “хяналтын апп ашиглаж чаддаггүй”,
- “хүүхэд технологийн хувьд илүү мэдлэгтэй” зэрэг хариултууд олон давтагдсан нь эцэг эх, хүүхдийн хооронд технологийн мэдлэгийн ялгаа үүссэнийг харуулж байна.

Мөн 14.8 хувь нь “хүүхэд эсэргүүцдэг” гэж хариулсан нь хүүхдийн цахим хэрэглээ нь зөвхөн техникийн бус гэр бүлийн харилцаа, итгэлцэл, нууцлалын асуудалтай холбогдож байгааг илтгэж байна. Судалгаанд:

- “намайг хянаж байна гэж дургүйцдэг”,
- “өөр аккаунт нээдэг”,
- “хичээл хийнэ гэж эсэргүүцдэг” зэрэг хариултууд дурдагдсан нь хүүхдийн эсэргүүцэл цахим хяналтын бодит саад болж байгааг харуулж байна.

